

ЗАХИАЛАГЧ : ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР

**“ЭДИЙН ЗАСГИЙГ БҮСЧЛЭН ХӨГЖҮҮЛЭХ, ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ
БОДЛОГО”-ЫН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БУЙ**

“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖИЛ, БАЙРШЛЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН СУДАЛГАА”

ЭЦСИЙН ТАЙЛАН

СУДЛААЧ Г.ЭНХЖАРГАЛ

БОДЛОГЫН СУДАЛГААНЫ АГУУЛГА

НЭГ. ОРШИЛ

- 1.1. Бодлогын судалгааны үндэслэл, хэрэгцээ, шаардлага
- 1.2. Судалгааны ажлын зорилго, зорилт
- 1.3. Судалгааны ажлын хамрах хүрээ
- 1.4. Судалгааны ажлыг гүйцэтгэх нарийвчилсан төлөвлөгөө

ХОЁР. АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

- 2.1. Олон улсын онолын чиг хандлага
- 2.2. Судалгааны арга зүй, аргачлал

ГУРАВ. БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ

- 3.1. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, журам, тогтоол, эрх зүйн акт болон бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, хоорондын уялдаанд өгөх үнэлгээ
- 3.2. Тухайн салбарын бүсчилсэн хөгжлийн түүхэн хандлага, өөрчлөлт, өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ/ БХҮБ, Бүсүүдийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд/
- 3.3. Салбарын хөгжлийн цаашдын чиг хандлага
- 3.4. Бодлогын залгамж чанарт хийсэн шинжилгээ

ДӨРӨВ. САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

- 4.1. Салбарт тулгамдаж байгаа асуудал, хүндрэл, бэрхшээлийг тодорхойлох, түүнийг шийдвэрлэх арга замууд
- 4.2. SWOT, PESTELI шинжилгээ
- 4.3. Дүгнэлт, санал, зөвлөмж

ТАВ. ХӨГЖИЛ, БАЙРШЛЫН ОРОН ЗАЙН АНАЛИЗ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗУРАГЛАЛ

- 5.1. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, журам, тогтоол, эрх зүйн акт болон бодлогын баримт бичгүүдэд туссан байршилтай төсөл арга хэмжээнүүдийн байршлын газрын зураг *(Газрын зургийг заавал ArcGIS программ дээр боловсруулсан байна. Газрын зургийн SHP file-ыг Үндэсний хөгжлийн газарт хүлээлгэн өгнө.)*
- 5.2. Тухайн салбарт өөрийн санал болгож буй хөгжил байршлын орон зайн төлөвлөлтийн зураглал *(Газрын зургийг заавал ArcGIS программ дээр боловсруулсан байна. Газрын зургийн SHP file-ыг Үндэсний хөгжлийн газарт хүлээлгэн өгнө.)*

5.3. Тухайн салбарын хөгжил байршлын нийлүүлэлтийн сүлжээний зураглал(*Газрын зургийг заавал ArcGIS программ дээр боловсруулсан байна. Газрын зургийн SHP file-ыг Үндэсний хөгжлийн газарт хүлээлгэн өгнө.*)

5.4. Тухайн салбарын хөгжил байршлын нэмүү өртгийн сүлжээний болон орц, гарцын зураглал(*Газрын зургийг заавал ArcGIS программ дээр боловсруулсан байна. Газрын зургийн SHP file-ыг Үндэсний хөгжлийн газарт хүлээлгэн өгнө.*)

5.5. Ирээдүйд хөрөнгө оруулалт хийх тухайн салбарын тэргүүлэх чиглэлүүд

5.6. Тухайн салбарыг цаашид хөгжүүлэх нөхцөл, нөөц, боломжууд

ЗУРГАА. ШИНЖЛЭХ УХААНЫ ТЕХНОЛОГИЙН ЗӨВЛӨЛИЙН БОЛОН ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДЫН ДҮГНЭЛТ, САНАЛ

6.1. Тайланг холбогдох яамны шинжлэх ухаан технологийн зөвлөл болон холбогдох ажлын хэсгүүдээр хэлэлцүүлсэн дүгнэлт, санал

ДОЛОО. БОДЛОГЫН СУДАЛГААНЫ СХЕМ, ХАВСРАЛТУУД

7.1. Ашигласан материалын жагсаалт

Жич: Ашигласан материал болон ишлэл, зүйл заалтын эх сурвалжийг хугацаатайн тухай бүр оруулах, Үсгийн фонт- Arial –12 хэмжээтэй, үсэг хоорондын зай-1.15.

НЭГ. ОРШИЛ

1.1 Судалгааны ажлын үндэслэл, хэрэгцээ, шаардлага

Тус судалгаа нь Монгол Улсын “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах” бодлогыг үндэсний, салбарын, орон нутгийн бодлоготой уялдуулан боловсруулахад шаардлагатай “Бодлогын судалгаа” юм.

Бүс нутгийн хүрээн дэх үндэслэл, хэрэгцээ шаардлага:

- Үндэсний хөгжлийн газар нь “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь заалтын дагуу “Бүсчилсэн хөгжлийн бодлого”-ыг боловсруулах ажлыг холбогдох төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналд үндэслэн хамтран боловсруулах чиг үүрэгтэй. Мөн Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2017 оны 15 дугаар тогтоолын 5 дугаар заалтад тус газарт Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулах талаар чиглэл өгсөн.
- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг 2001 онд баталсан бөгөөд одоогийн Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, олон улсын харилцаа тухайн үеийн нөхцөл байдлаас ихээхэн өөрчлөгдөөд байна.
- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд үндэслэн боловсруулсан Монгол Улсын Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүсийн хөгжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжих хугацаа (нэгдүгээр үе шат-2006-2010 он, хоёрдугаар үе шат-2011-2015он) дууссан.
- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсүүдийн хөгжлийн хөтөлбөрийг Дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-тэй уялдуулан шинээр боловсруулах шаардлагатай байна.
- Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, “Аялал жуулчлалын тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай”, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай, Чөлөөт бүсийн тухай, хуулиудын уялдаа хангалтгүй, нутаг дэвсгэрийн нийгмийн харилцаа, орон зайн зохион байгуулалтыг оновчтой зохицуулдаг хуулийн нэгдмэл механизм болж үйлчлээгүйгээс шалтгаалж, үндэсний, бүс нутгийн хэмжээний хөгжлийн асуудлыг орон нутаг, салбарын бодлогоор зохицуулахыг эрмэлзэж байна.
- Даяаршлын нөхцөлд дэлхийн улсууд, түүний дотор хоёр хөрш орон болох ОХУ, БНХАУ-ын геополитик, геоэдийн засгийн чиг хандлага мэдэгдэхүйц өөрчлөгдөж, ОХУ нь Зүүн хойд Ази, Номхон далайн орнуудтай хамтын

ажиллагаагаа идэвхжүүлэхийг зорих боллоо. БНХАУ нь Ази, Европыг холбож байсан торгоны замын худалдаа, эдийн засгийн харилцааг үндэслэн “Нэг бүс-Нэг зам” санаачлагыг дэвшүүлж, энэ чиглэлд татагдаж байсан бүх орон, түүний дотор Хятад-Монгол-Орос гурван улсын хооронд эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийг батламжилж, хэрэгжүүлэхээр тохиролцоод байна.

Аялал жуулчлалын салбарын хүрээн дэх үндэслэл, хэрэгцээ, шаардлага:

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д Монгол Улс нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв болох зорилт тавьсан. Энэхүү зорилтод хүрэхийн тулд дараах 3 үе шаттай хэрэгжүүлэх ба үе тус бүр дээр зорилт тавьсан.

1-р үе шат (2016-2020) : Байгаль, соёлын өвийн үйлдвэрлэл, үзмэрүүдийн голлох төвүүдэд жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, олон улсын тавцанд Монголын аялал жуулчлалын онцлог дүр төрхийг бүрдүүлэх, байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж гадаадын жуулчдын тоог 1.0 саяд хүргэх.

2-р үе шат (2021-2025) : Бүсийн хэмжээнд олон улсын аялал жуулчлалын замналд нэгдэх, дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, аялал жуулчлалын олон төрөл, улирлын чанартай аялал жуулчлалыг хөгжүүлэх, Монголын нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын сурталчилгааг тасралтгүй сайжруулах, гадаадын жуулчдын тоог 1.5 саяд хүргэх.

3-р үе шат (2026-2030) : Байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж, нүүдлийн соёл, аялал жуулчлалын Монгол брэндийг дэлхийд сурталчлан, аялал жуулчлалаас орох орлогыг нэмэгдүүлэн, гадаадын жуулчдын тоог 2.0 саяд хүргэх.

“Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т аялал жуулчлалыг өөрийн орны өвөрмөц онцлог болон олон улсын жишиг, чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлэх, эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгон улмаар олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж, стратегийн зорилтуудыг дэвшүүлэн, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тогтоож, нарийвчилсан төлөвлөгөөг гарган, нэгдүгээр үе шат буюу эрчимтэй хөгжлийн үе 2016-2020 он, хоёрдугаар үе шат буюу тогтвортой хөгжлийн үе 2021-2025 он хүртэл хоёр үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн байна.

Аялал жуулчлалын салбарын хувьд эрс тэс цаг уурын байдлаас үүдсэн улирлын онцлог, аялал жуулчлалын бүтээгдэхүүний төрөлжилт хангалтгүй,

бүтээгдэхүүний үнэ өндөр, жуулчин тээвэрлэх, хүлээн авах хүчин чадал бага, мэргэжлийн ажиллах хүчин дутмаг, салбарын сургалт, судалгааны чанар хангалтгүй, статистик бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангуй, жуулчдыг татахад чиглэсэн маркетинг, гадаад сурталчилгааны ажил хангалтгүй, үйлчилгээний стандарт, аюулгүй байдал хангагдаагүй зэрэг асуудлуудыг “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т дэвшүүлэн, эдгээрийг шийдвэрлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Мөн салбарын төр, хувийн хэвшил, мэргэжлийн байгууллага, орон нутгийн иргэдийн хамтын ажиллагаа, түншлэлийн үр дүнтэй механизмийг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Олон улсын туршлагаас үзэхэд аялал жуулчлалын салбарын хөгжилд орон нутгийн иргэдийг татан оролцуулах нь нэн чухал бөгөөд тухайн орон нутгийн иргэд нийгмийн болон эдийн засгийн ашгийг хүртэж тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх бүрэн боломж бүрдэх юм.

Түүнчлэн аялал жуулчлалын бүсийн байгаль орчин, хүрээлэн буй орчинд нөлөөлөх байдлыг үнэлэн, орон нутгийн онцлог, байгалийн даац, хүчин чадалд тохирсон аялал жуулчлалын төрөл, бүтээгдэхүүнийг тодорхойлон, холбогдох салбарын хөгжилтэй уялдуулан шаардлагатай хөрөнгө оруулалт, хэрэгжүүлэх үйл ажиллагааг бүсийн хөгжлийн төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэх шаардлагатай байна.

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”- д Монголын аялал жуулчлалын онцлог дүр төрхийг бүрдүүлэх, байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх гэсэн тодорхой зорилт тавигдсан байгаа тул энэхүү судалгаагаар бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд орон зайн тодорхой төлөвлөлтийг санал болгох хэрэгтэй.

1.2 Судалгааны ажлын зорилго, зорилт

Энэхүү судалгааны зорилго нь Аялал жуулчлалын салбарын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлон учир шалтгааныг илрүүлж, бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан шийдвэрлэх арга замыг тодорхойлоход оршино.

Судалгааны үндсэн дээр Монгол Улсын аялал жуулчлалын салбарын хөгжил байршлын нэгдсэн төлөвлөлт, зураглалыг боловсруулж, Монгол Улсын “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах” бодлогын баримт бичигт тусгана.

1.3 Судалгааны ажлын хамрах хүрээ

Монгол Улсын эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлогыг аялал жуулчлалын салбартай уялдуулан, тулгамдаж буй асуудлыг улс үндэсний (олон улсын түвшинд), бүсийн (хөрш болон бүс нутгийн орнуудын хамтын ажиллагааны хүрээг хамруулан), аймаг, орон нутгийн түвшнээр харьцуулан судалж, шийдвэрлэх хувилбаруудыг тодорхойлно.

1.4 Судалгааны ажлыг гүйцэтгэх нарийвчилсан төлөвлөгөө

Хүснэгт 1.4.1 Судалгааны ажлын хуваарь

	<i>[Зөвлөхийн үйлчилгээг эхэлсэн нэг дэх сар, хоёр дахь сар гэх мэт]</i>											
Үйл ажиллагаа (ажлууд)	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Бэлтгэл, эхлэлийн тайлан	→											
Мэдээлэл цуглуулах, ярилцлага	→											
Салбарын нөхцөл байдлын дүн шинжилгээ	→											
Хөгжлийн бодлогын нөлөөллийн урьдчилсан үнэлгээ		→										
Эцсийн тайлан	→	→										

ХОЁР. АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

2.1.1 Олон улсын онолын чиг хандлага

Байршлын болон бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн онол болон газарзүйн онолын хөгжлийн хандлагаас үзэхэд ихэвчлэн хот байгуулалт болон аж үйлдвэрийн хөгжилд тулгуурласан байдаг. А.Веберийн бүсчилсэн хөгжлийн онолоос харахад хэрэглээний орон зайд буюу нөөцөд суурилан байрших, Б.Кристаллер бүсүүдийн таталцал, нөлөөллийн бүсийн талаар мөн зах зээлийн орон зайн зөв бүтэц болон хүн амын шилжилтийн маршрутыг тодорхойлсон байдаг. У.Айзард бүтээгдэхүүний тээвэрлэх зай, тээвэрлэлтийн хэмжээ зэргээс хамаарч бүтээгдэхүүний аль нь орон нутгийн, бүсийн, үндэсний түвшний болох нь тодорхойлогдоно гэсэн байна. Ф.Перру, Д.Дарвенг нар хөгжлийн хандлагаар нь үйлдвэрлэлийн салбарыг ангилсан бөгөөд үүнд, хөгжлийн их хурдтай бөгөөд бусад салбарын өсөлт хөгжлийг өдөөж өгдөг төрлийг тодорхойлсон байна. Аялал жуулчлалын салбар нь энэхүү төрөлд хамрагдах бөгөөд бусад үйлчилгээний салбарын өсөлтийг дэмжихээс гадна бусад салбартай уялдуулан хөгжүүлэх боломж өндөр, бусад аж үйлдвэрийн салбартай харьцуулахад байгаль экологи, нийгэм соёлд үзүүлэх сөрөг нөлөөлөл бага байдаг.

2.1.2 Дэлхийн аялал жуулчлалын чиг хандлага

Дэлхийн аялал жуулчлалын байгууллага (ДАЖБ)-аас олон улсын аялал жуулчлалыг 6-н бүс нутгийн ангилан тогтоосон. Үүнд: Европын бүс нутаг Америкийн бүс нутаг Африкийн бүс нутаг Зүүн Ази болон Номхон Далайн бүс нутаг Өмнөд Азийн бүс нутаг Ойрхи Дорнодын бүс нутаг зэргээр ангилсан. Орчин үед дэлхий дахины хөгжлийн ерөнхий чиг хандлага нь зохистой хэрэглээг төлөвшүүлэх, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг хөгжүүлэх, улс орнуудын өөр өөрийн өвөрмөц шинж төрх, баялагаа хадгалах замаар улам бүр даяаршлагдаж байна. Тус байгууллагаас гаргасан урт хугацааны урьдчилсан тооцооллоор 2030 он гэхэд олон улсын жуулчдын тоо 1.8 тэрбумд хүрч, дэлхийн хэмжээгээр жилд дунджаар 3.3 хувиар өсч, үүний үр дүнд олон улсын аялал жуулчлалын зах зээлд жил бүр 43 сая жуулчин шинээр нэмэгдэнэ гэж судалгаа гаргажээ. Харин ирэх 20 жилд нэг өдөрт дундажаар 5 сая орчим хүн амралт, зугаалга, бизнес, гэр бүл, найз нөхдийндөө зочлох зорилгоор олон улсын аялал хийх юм байна. Салбарын өсөлт нь эдийн засаг, нийгмийн төрөл бүрийн төсөл, хөтөлбөрүүд, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг дэмжих зэрэг олон зүйлд эерэгээр нөлөөлж, маш их шинэ боломжуудыг бий болгоно гэж Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын ерөнхий нарийн бичгийн дарга Талеб Рифай онцлон дурьджээ. 2015 оноос олон улсын аялагчдын тоо 2030 он гэхэд даруй 58 хувиар өснө гэж судлаачид таамаглаж байна.

Хойд Америкийн бүсийн аялал жуулчлалын өсөлт хамгийн удаан байна гэж таамагласан байна. Мөн 2030 он гэхэд Зүүн Хойд Ази дэлхийн хамгийн олон хүн аяладаг дэд бүс нутаг болно гэжээ. Үүнийг дагаад манай оронд ирэх жуулчдын тоо өсч болох юм. Түүнчлэн 2020 гэхэд нийт жуулчдын тоо 1995 онтой харьцуулахад 3 дахин нэмэгдэж 1.6 тэрбумд хүрэх хандлагатайг дээрх судалгаанд мөн дурьджээ. Аялалын чиглэлээс харвал Ази, Номхон далайн орнуудаар аялах жуулчдын тоо нэмэгдэх хандлагатай байгаа аж. Дэлхий дахинд тогтвортой хөгжлийн аялал жуулчлалыг дэмжин НҮБ-ээс 2017 оныг “Хөгжлийг дэмжих тогтвортой аялал жуулчлалын олон улсын жил” хэмээн тунхаглаж Дэлхийн аялал жуулчлалын байгууллага (UNWTO)-ын дор төрөл бүрийн арга хэмжээ зохион явуулж байна.

Тогтвортой хөгжил 2030 хөтөлбөрт тусгагдсан хөгжлийн зорилтод тогтвортой аялал жуулчлалын зорилтыг мөн тусгасан бөгөөд эрэлт хэрэгцээ өндөрсөж буй аялал жуулчлалын газар нутагт тогтвортой хөгжлийн боломжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах нь чухал. Зорилтын гол агуулга нь ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн соёл, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг сайжруулахтай холбогдох тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, хөгжлийн нөлөөг судлах асуудал юм.

ДАЖБ нь аялал жуулчлалтай шууд холбогдох Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ¹. Түүнчлэн тогтвортой аялал жуулчлалын зорилтууд бүгд хоорондоо уялдаа холбоотой, илүү өргөн хүрээнд эдгээр зорилтын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй гэсэн хандлага дэлгэрч байна².

Канадын цасны резорт болох Вистлер бүс нутагт 1974 онд бүс нутгийн хөгжлийг бүхэлд нь нэгтгэн, Вистлер резорт орон нутгийн захиргаа (Resort Municipality of Whistler) байгуулагдан, төлөвлөлтийн дагуу хотыг хөгжүүлж ирсэн.

1998 онд Канадын Вистлер резорт бүс “Вистлер Хүрээлэн буй орчны стратеги (Whistler Environmental Strategy)”, 2004 онд урт хугацааны хөгжлийн төлөвлөгөө болох “Вистлер 2020 (Whistler 2020) “ (2006 онд 2 дахь шинэчилсэн хувилбар) боловсруулсан. Вистлер 2020 тусгагдсан үнэлгээний үзүүлэлт нь Иргэдийн бүлгэм (коммюнити) гүйцэтгэлийн үзүүлэлт болон Үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан гэсэн 2 үндсэн хэсгээс бүрэлдэнэ.

Иргэдийн бүлгэмийн гүйцэтгэлийн үзүүлэлт нь иргэд болон жуулчдын байр суурь дээр тулгуурласан үзүүлэлт бөгөөд иргэдийн амьдрал ахуйн орчинг сайжруулах арга хэмжээнээс гадна хүрээлэн буй орчин, эдийн засгийн үзүүлэлтийг мөн хамруулсан. Үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан нь аялал

¹ Institutional Relations and Resource Mobilization – Tourism and the SDGs
<http://icr.unwto.org/content/tourism-and-sdgs>

² “Critical thinking to realize sustainability in tourism systems: reflecting on the 2030 sustainable development goals” (The Journal of Sustainable tourism) Karla Beluk, Christina T. Cavaliere, Freya Higgins-Desbiolles

жуулчлалын салбарын тогтвортой байдлыг үнэлэх зорилготой бөгөөд эдийн засгийн төдийгүй иргэдийн оролцоо, хүрээлэн буй орчны асуудлыг мөн хамруулна.

Түүнчлэн Вистлерт орон нутгийн тогтвортой байдалд тогтмол хяналт, мониторинг хийн, үр дүнг цахим хуудсаар ил тод мэдээлдэг байна. Үнэлгээний үзүүлэлтийг дараах хүснэгтэд дэлгэрэнгүй харуулав.

Хүснэгт 2.1.2 Вистлер 2020 тусгагдсан аялал жуулчлалын үнэлгээний үзүүлэлт

Ангилал	Төрөл	Үзүүлэлт
Иргэдийн хоршоо, бүлгэмийн гүйцэтгэлийн үзүүлэлт	Иргэдийн амьдрал ахуйг сайжруулах	Иргэдийн бүлгэмд хамрагдсан байдал
		Оршин суугчдын орон сууц худалдан авах чадвар
		Оршин суугчдын сэтгэл ханамж
		Хууль бус хэрэг
		Амралтын цагийн сэтгэл ханамж
		Орон нутгийн хүний нөөц
		Суралцах боломж орчны сэтгэл ханамж
		Иргэдийн эрүүл мэндийн байдал
	Резорт амралтын	Жуулчдын тоо
		Жуулчдын сэтгэл ханамж
		Вистлерийн сэтгэгдэл
	Хүрээлэн буй орчны хамгаалал	Эрчим хүчний хэрэглээний хэмжээ
		Хог хаягдал
		Нийт усны хэрэглээний хэмжээ
		Нүүрсхүчлийн хийн ялгаруулалт
	Эдийн засгийн хүчин чадал	Бүтээн байгуулалт (газар ашиглалтын хэмжээ)
		Жуулчдын нийт хоногийн тоо
		Нийт орлого
		Татварын орлого
	Хамтын ажиллагаа	Хөдөлмөр эрхлэгчдийн тоо
		Жилийн ор дүүргэлтийн хувь
		Шийдвэр гаргалт дахь оролцоо
	Үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан	Орон нутгийн эдийн засаг, резорт
Сонгуулийн ирц		
Цэцэрлэгт хүрээлэн		
Тосгоны арчилгаа үйлчилгээ		
Жуулчдад зориулсан үйлчилгээ		Тосгоны орчин, үзэмж
		Вистлерийн орчин, үзэмж
		Фестиваль, арга хэмжээ
		Вистлерийн нийтийн тээвэр
		Цагдан сэргийлэх, гал команд
		Хотын мэдээлэл
Оролцоо		Бүтээн байгуулалтын зөвшөөрөл
		Нэгдсэн резортын төлөвлөгөө
		Цахим хуудасны хандалт
		Санал авах, тусгах
		Итгэлийн түвшин

	Байгаль орчны хяналт	Оролцооны түвшин
		Ус, дулааны хэрэглээ
		Хаягдал усны чанар
		Нүүрсхүчлийн хийн ялгаруулалт
		Хог хаягдал, дахин ашиглалт
	Дэд бүтэц, барилга байгууламж, хөтөлбөрийн хяналт	Медо парк, спорт цогцолбор
		Цэвэрлэх байгууламжийн зардал
		Ундны усны зардал
		Халуун ус
		Зам арчилгаа, үйлчилгээ, цас цэвэрлэгээ
	Компанийн санхүүгийн эрүүл байдал	Арга хэмжээ, фестивалийн нөлөө
		Төсвийн зөрүү
		Хөрөнгө
		Татаас болон гадны хөрөнгө
		Хөрөнгийн зардал
		Зардлын ашиг

Эх сурвалж: Whistler-Community Performance Indicators, Corporate Plan Performance Reporting
<https://www.whistler.ca/municipal-gov/community-monitoring/community-performance-indicators>
<https://www.whistler.ca/municipal-gov/community-monitoring/corporate-plan-performance-reporting>

Манай улсын хувьд ч тухайн бүс нутгийн онцлог, аялал жуулчлалын төлөвлөгөө зорилтод тулгуурласан тогтвортой аялал жуулчлалын индикатор (Sustainable Tourism Indicator, STI) үнэлгээний тогтолцоог бий болгох шаардлагатай. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 буюу урт хугацааны хөгжлийн төлөвлөлтөд суурилсан дунд хугацаанд Бүсчилсэн хөгжлийн бодлого, аялал жуулчлалын бүс нутаг тус бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл, иргэд болон орон нутгийн оролцоо, байгаль орчны нөлөөлөл гэсэн 3 үндсэн үзүүлэлтээр тогтмол үнэлгээ хийн, үр дүнг ил тод мэдээлдэг тогтолцоо хэрэгцээтэй гэж үзэж байна.

Аялал жуулчлалын хүчин чадлын судалгаа

Аялал жуулчлалын хүчин чадлын талаарх ойлголтыг анх Дэлхийн Аялал жуулчлалын байгууллага 1981 онд аялал жуулчлалын зорин очих газрын байгаль орчны даацыг “Аялал жуулчлалын зорих газрын байгаль, нийгэм, соёл, эдийн засгийн орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй, ирсэн жуулчдын сэтгэл ханамжийг бууруулахгүй ижил цаг хугацаанд тухайн газарт зэрэгцэн аялаж болох жуулчдын тооны дээд хязгаар “ хэмээн тодорхойлсон байна.

ЮНЕСКО-ийн Дэлхийн өвд бүртгэлтэй аялал жуулчлалын газрын хяналт : дэлхийн өвд бүртгэлтэй газрын хяналтын гарын авлага (2002) д хүчин чадлыг бодит буюу физикийн, хүрээлэн буй орчны, нийгэм соёлын хэмээн 3 төрөлд хуваан тодорхойлсон байна.

Хүснэгт 2.1.3 ЮНЕСКО-ийн аялал жуулчлалын хүчин чадлын тодорхойлолт

Төрөл	тайлбар, агуулга
Бодит	Зочид буудал, жуулчны баазын хүчин чадал, цэвэр ус, цахилгаан, дулаан хангамж гм.
Хүрээлэн буй орчны	Тогтвортой хөгжлийн зарчмыг хангасан байгалийн даац, аялал жуулчлалын бүсийн ашиглалт, түүний нөлөөлөх байдалд биологийн төрөл зүйлийн эсэргүүцэх чанар болон уян хатан чанар хоорондын өөрчлөлтийг таамаглах төвөгтэй.
Нийгэм, соёлын	Сэтгэл зүйн буюу нийгэм соёлын хувьд жуулчдын тоо сэтгэл ханамжийг бууруулахааргүй хэмжээнд байх.

Эх сурвалж : Managing Tourism at World Heritage Sites: a Practical Manual for World Heritage Site Managers By Arthur Pedersen, UNESCO World Heritage Centre (2002)

Аялал жуулчлалын хүчин чадал буюу даацын тооцоог ТХГН-ийн менежментэд ашиглан, жуулчдад зориулсан аливаа дэд бүтцийг энэхүү тооцоонд тулгуурлан хамгийн оновчтой, байгаль орчинд ээлтэй, цомхон, өндөр хязгаарлалттай төлөвлөн хөгжүүлж, хяналт зохицуулалтыг чанд гүйцэтгэх шаардлагатай билээ.

Манай улсад ТХГН-ын Менежментийн төлөвлөгөөнд аялал жуулчлалын даацыг тооцоолсон судалгаа хийгдэж байсан. Тухайлбал, БОАЖЯ-тай хамтран НҮБХХ, ДДБХС-ийн санхүүжилтээр 2015-2017 онд хэрэгжсэн Тусгай хамгаалалтуудын газруудын сүлжээг бэхжүүлэх нь төслийн дэмжлэгээр боловсруулсан Их Нартын Байгалийн Нөөц Газрын “Менежментийн төлөвлөгөө”-нд тухайн газрын аялал жуулчлалын даац, хүчин чадлыг тооцооллыг хийсэн байна.


1980 онд Английн газар зүйн ухааны эрдэмтэн Ричард (Richard.W.Butler) Аялал жуулчлалын бүсийн тойрог буюу Tourism Area Life Cycle (TALC) талаар ойлголтыг гарган, аялал жуулчлалын бүс нутгийн насжилтын моделийг дэвшүүлсэн байна.

Аялал жуулчлалын бүсэд эрэл хайгуулын үе (exploration) → эхэн үе (involment) → хөгжлийн үе (development) → бэхжилтийн үе (consolidation) → зогсонги үе (stagnation) → арчилгаа, тордлогоо (maintenance), уналт, сүйрэлт (decline) эсвэл дахин сэргэлтийн үе (rejuvenation) гэсэн амьдралын тойрог байдаг байна (Зураг.)

Энэхүү TALC онолоор хөгжлийн үе шатанд “бүтээн байгуулалт нь орон нутагт тааламжтай хэлбэрээр явагдахгүй”, бэхжих үе шатанд “аялал жуулчлалын салбарт оролцоогүй нутгийн иргэдийн эсэргүүцэл, бухимдалтай тулгарна” гэжээ.

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлэхэд хөгжлийн үеэс дараагийн бэхжих үе шат руу шилжих явц хамгийн чухал үе гэж үзэж байна.

Өнөөг хүртэл гадаадын жуулчид бараг очдоггүй байсан газарт автозам тавигдсанаар жуулчны автобустай жуулчид их хэмжээгээр очдог болж, нутгийн иргэдийн амьдралд нөлөөлж эхлэх нь энэхүү тойргийн эрэл хайгуулын үе, эхэн үеийн асуудал юм. Нөгөөтэйгүүр хөгжсөн аялал жуулчлалын бүс нутагт байгаль орчны бохирдол, хүрээлэн буй орчны үзэмж алдагдах, хэт их хошуурсан хөгжлөөс тухайн газар нутгийн жинхэнэ үнэ цэнэ алдагдан аялал жуулчлалын үндсэн бүтээгдэхүүн болох үзэмж төрх буурах үзэгдэл зогсонги үе шатанд харагддаг. Иймэрхүү маягаар хөгжлийн үе шат бүрийн тулгамдах асуудлыг урьдчилан тооцоолон, төлөвлөлт хийх шаардлагатай нь харагдаж байна.



Зураг 2.1.2 R.Butler Tourism Area Life Cycle (TALC) онол

Хүснэгт 2.1.4 Аялал жуулчлалын бүс нутгийн хөгжлийн үе шат

Үе шат	Агуулга
Эрэл хайгуулын үе (Exploration)	Бүс нутгийн онцлог, үзэмжид татагдсан жуулчид хувиараа тухайн нутгаар аялана. Орон нутагт аялал жуулчлалын хөгжөөгүй, жуулчдад зориулсан зочид буудал байхгүй. Орон нутгийн дэн буудал, оршин суугчдын гэрт хоноглох бөгөөд энэ нь жуулчдад Жуулчид ирснээр байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөө үүсэхгүй, орон нутгийн эдийн засагт онц ач холбогдолгүй.
Эхэн үе (Involvement)	<u>Жуулчид тоо нэмэгдэн тогтмолжиж ирснээр</u> нутгийн иргэд, хувийн хэвшил аялал жуулчлалын салбарт оролцож эхлэнэ. Жуулчдыг татах сурталчилгаа явуулж, аялал жуулчлалын зах зээл эхлэлээ тавина. Жуулчны улиралтай болж, нутгийн иргэдийн амьдралд

	<p>нөлөөлж эхлэнэ. Тур компаниуд оролцон, тээвэр болон зочид буудлын бүтээн байгуулалтын хүсэлтийг Засгийн газарт тавина.</p>
Хөгжлийн үе (Development)	<p><u>Аялал жуулчлалын нутгийн талаарх сурталчилгаа идэвхитэй явагдан, аялал жуулчлалын зах зээл бодитоор бий болно. Гадны хөрөнгө оруулалт хийгдэн, орчин үеийн_цогцолбор байгууламж баригдан, нутгийн иргэдийн оролцоо хумигдана. Бүтээн байгуулалт орон нутагт тааламжтай хэлбэрээр явагдах баталгаа байхгүй. Бүтээн байгуулалтад Засгийн газрын оролцоо зайлшгүй шаардлагатай болно.</u></p>
Бэхжих үе (Consolidation)	<p>Жуулчдын тоо нэмэгдэх хэдий ч <u>өсөлтийн хувь буурна. Нутгийн иргэдээс жуулчдын тоо нь их байдалд орох магадлалтай. Зар сурталчилгаа, маркетинг өргөн хүрээнд хийгдэн, аялал жуулчлалын зах зээлийг тэлэх</u> <u>Аялал жуулчлалд оролцоогүй нутгийн иргэдийн бүхмидал, эсэргүүцэлтэй тулгарна.</u></p>
Зогсонги үе (Stagnation)	<p><u>Бүс нутагт хүлээн авах боломжтой жуулчдын тооны хязгаарт хүрнэ. Үүнээс үүдсэн байгаль орчин, нийгэм, эдийн засгийн төрөл бүрийн асуудал гарна. Аялал жуулчлалын салбарт тээврийн тав тухтай байдлыг хангах зэрэг жуулчдын тоог бууруулахгүй байх арга хэмжээ авна.</u> Шинэ аялал жуулчлалын бүс нутаг ойр орчинд нэмэгдэн, хуучин бүсийн газрын эзэд байнга өөрчлөгдөнө. Бүс нутгийн байгаль орчин, соёлын нөөцөөс илүүтэй тухайн нутгийн аялал жуулчлалын цогцолбор тухайн нутгийн төсөөлөл болж хувирна.</p>
Уналтын үе (Decline)	<p><u>Шинээр бий болсон жуулчлалын бүс нутагтай өрсөлдөх чадваргүй болж, аялал жуулчлалын зах зээл хумигдана.</u> Жуулчид олноор ирэхгүй ч тээвэр сайн хөгжсөн бол өдрийн аялагч, амралтын өдрийн жуулчид ирнэ. Аялал жуулчлалын цогцолборууд хаагдан, нутгийн иргэдийн ажил эрхлэлт, оролцоо багасна.</p>
Уналтын дараах дахин сэргэлт (rejuvenation)	<p>Уналтын үе шат удаан үргэлжилбэл тухайн бүс нутаг <u>аялал жуулчлалын функцээ алдана.</u> Гэхдээ дахин сэргээх арга хэмжээ авбал хэд хэдэн чиг хандлага байж болно. Казино гм шинэ цогцолбор барих эсвэл шинэ байгалийн нөөц газрыг ашиглан а/ж бүтээгдэхүүн гаргана. Хэд хэдэн чиг хандлага байж болно.</p> <p>А. Дахин сэргэлт амжилттай хийгдвэл шинээр хөгжинө. В. Хяналт зохицуулалтаар нутгийн нөөц баялагийг хамгаалж чадвал А шиг хэмжээнд биш ч хэвийн хэмжээнд хөгжих боломжтой. С. Бүх тал дээр дахин зохицуулалт хийж чадвал жуулчдын тоо тогтмол хэмжээнд байна. D. Бүс нутгийн нөөц баялагийг зохисгүй ашигласан хэвээр, хуучин</p>

	<p>байгууламжийг засаж сайжруулахгүй бол нутгийн өрсөлдөх чадвар буурч, жуулчид эрс буурна. Е. Дайн дажин, халдварт өвчин зэрэг онцгой байдлаас жуулчид алга болж, аялал жуулчлалын бүс нутаг уналтад орно.</p>
--	--

Эх сурвалж: Шизүокагийн их сургуулийн Эдийн засгийн хүрээлэн, Такаюки Ота (2011), “Аялал жуулчлалын бүсийн хөгжлийн тойрог, тулгарах бодлогын асуудал “-д тулгуурлан боловсруулав.

2.2 Судалгааны арга зүй, аргачлал

Энэхүү судалгааг өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх бодлогын судалгаа, нөлөөллийн урьдчилсан үнэлгээг хийх бодлогын шинжилгээ гэсэн 2 үе шатаар боловсруулна. Үүнд :

- бодлогын судалгаа нь (бодит байдлын судалгаа) тус салбарын бодлогын хэрэгжилтийн үйл явцад үүссэн, шийдэх шаардлагатай асуудлыг тодорхойлж, нэгдсэн санал, дүгнэлт зөвлөмж гаргах;
- бодлогын шинжилгээ нь бодлогын судалгааны үр дүнд үндэслэн, бодлогын боломжит хувилбаруудыг тогтоож, тэдгээрийн үр ашиг, хэтийн нөлөөллийг тооцоолон, оновчтой гэж үзсэн хувилбаруудыг санал болгох.

Монгол Улсад хэрэгжсэн, одоо хэрэгжиж буй болон төлөвлөгдөж буй аялал жуулчлалын бодлого, хөтөлбөр, төслийн үр дүн, хэрэгжилтийн үйл явцад үүссэн, хэрэгжилтийн дараах шийдэх шаардлагатай асуудлыг өмнөх судалгаа, шинжилгээний ажлын мэдээллийг эмхтгэн шинжилгээ хийх, оролцогч талуудтай ярилцлага хийх замаар өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт гаргана.

Монгол Улсын хөгжлийн дунд болон урт хугацааны хөгжлийн төлөвлөлтөд үндэслэн, аялал жуулчлалын тогтвортой хөгжлийг эрчимжүүлэх нөөц бололцоо, аялал жуулчлалын хөгжилд харилцан уялдах зам тээвэр, дэд бүтэц, байгаль соёлын өв, хүний нөөц зэрэг хүчин зүйлсэд тулгуурлан PESTLE, SWOT шинжилгээ хийнэ.

Орон зайн төлөвлөлтийн аргаар нийгэм, эдийн засгийн дүн шинжилгээтэй уялдуулан цаашдын аялал жуулчлалын хөгжлийн хувилбарыг олон улсын болон бүсийн хамтын ажиллагааны хүрээг хамруулан, улсын болон аймаг орон нутгийн түвшнээр шийдвэрлэх хувилбаруудыг дэвшүүлнэ.

ГУРАВ. БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ

3.1 Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, журам, тогтоол, эрх зүйн акт болон бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, хоорондын уялдаанд өгөх үнэлгээ

Аялал жуулчлалын салбарын хувьд нийт 14 гаруй хууль, тогтоомж, 1 үндэсний хөтөлбөр, 12 улстай Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр, 11 улстай яамдын хоорондын санамж бичиг, гэрээ хэлэлцээр хийсэн байна.

Үүнээс аялал жуулчлалын салбарын хөгжилд чухал нөлөөтэй хууль тогтоомж дээр хийсэн үнэлэлт, дүгнэлтээс дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 3.1.1 Салбарын хууль, эрхзүйн орчны үнэлэлт

Хууль тогтоомж	Батлагдсан огноо (нэмэлт)	Салбарын бодлогын уялдаа, хуулийн хэрэгжилтэд хийх үнэлгээ
Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль	2015/11/26 (1)	Бодлогын залгамж халаа болон бусад холбогдох салбарын бодлого, төлөвлөлтийн уялдаа холбоог хангах үндсэн эрх зүйн гол акт болж чадсан.
Аялал жуулчлалын тухай хууль	2000 /5/5 (10)	Салбарын хөгжлийг дэмжих, оролцогч талуудын харилцааг зохицуулах зорилтыг хангасан. Хуулийн хэрэгжилтийн хувьд хангалтгүй, ялангуяа аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих хяналт (6.22) сул байгаагаас аялал жуулчлалын хөгжилд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаа явуулахыг хориглож (4.16.1) чадахгүй байна. Түүнчлэн оролцогч талуудын бүрэн эрхийн талаар тусгаснаас хүлээх үүрэг, хариуцлагын талаар дурдагдаагүй. Ялангуяа төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар огт дурдагдаагүй, төр, орон нутаг, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа сул.
Байгаль орчныг хамгаалах тухай хууль	1995/3/30 (23)	Хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдох төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх зохицуулах зорилготой. Аялал жуулчлалын салбар өргөжихийн хирээр байгаль орчны хамгаалал, тэр тусмаа дотоодын аялагчдын экологийн боловсрол, хүмүүжлийн (56 зүйл) талаар түлхүү арга хэмжээ авах шаардлагатай байна.
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай	2012/5/17 (2)	Жуулчны бааз болон аялал жуулчлалын цогцолбор зэрэг байгаль орчны нөлөөллийн үнэлгээ (7 зүйл) хийгдсэн эсэх, хийгдсэн бол хянан магадлагаа (11 зүйл) явагдсан эсэхийг байгаль орчны менежментийн

		<p>төлөвлөгөөнд (9 зүйл) тулгуурлан мониторинг хийх шаардлагатай байна. Хуульд олон нийтийн оролцоо хангах заалт орсон хэдий ч байгаль орчны үнэлгээний асуудалтай холбогдох мэдээллийн ил тод байдлын талаар орхигдуулсан. Түүнчлэн улсын хэмжээнд, бүс нутаг, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх хөгжлийн бодлого, хөтөлбөрийн төлөвлөлтийн үе шатанд байгаль орчны стратеги үнэлгээ (5 зүйл) , байгаль орчны төлөв байдлын болон хуримтлагдах үнэлгээ (6 зүйл) огт хэрэгжээгүй байна. Энэ нь хуулийн 5 зүйлд заагдан нарийвчилсан журам батлагдаагүйтэй холбоотой.</p>
<p>Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай</p>	<p>1995/4/27</p>	<p>Тусгай хамгаалалттай газар нутгийн хуульд заагдсан хязгаарлалтын бүсийн дэглэм, хориглох үйл ажиллагааны хяналт дээр хүний нөөц, төсөв хөрөнгө хангалтгүйн улмаас бүрэн хэрэгжиж чаддаггүй.</p> <p>Түүнчлэн улс төрийн дарамт, нөлөөгөөр газар олгох, газар ашиглах зөвшөөрөл олгох, зориулалтын бус барилга байгууламж барих явдал газар авсаар байна.</p>
<p>Тусгай хамгаалалтын газар аялал жуулчлал явуулах журам</p>	<p>Байгаль орчны сайдын 2002 оны 117 тушаал</p> <p>Хавсралт 1.</p>	<p>Тусгай хамгаалалтын газарт явуулах зөвшөөрлийг судалгаа, төлөвлөлтгүй замбараагүй олгосноор тухайн нутгийн даац хэтрэх, хог хаягдал ихсэх зэрэг байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлээд зогсохгүй, үйлчилгээний чанарыг доголдуулах асуудлыг үүсгэж байна. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дагуу байгаль орчны даацын судалгаа хийхийн дээр аялал жуулчлалын хөтөлбөр, бусад салбар болон орон нутгийн төлөвлөлттэй уялдуулан үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай.</p>
<p>Аялал жуулчлалын байгууллагын ангилал тогтоох журам</p>	<p>БОАЖ сайдын 2009 оны 31 тушаал</p>	<p>Аялал жуулчлалын тухай хуульд аялал жуулчлалын байгууллагын ангилалыг 4.2 зүйлд тур агент, тур оператор гэсэн 2 ангилна гэж тусгасан төдий, ангилал тогтоох журмын заалтын ангилалын тухай дурдагдаагүй. Журмыг шинэчлэн тогтоох шаардлагатай байна.</p>
<p>Дээд зэрэглэлийн зочид буудал, жуулчны баазад зэрэглэл тогтоох журам</p>	<p>Дэд бүтцийн сайдын 2002 оны 150 тушаал</p>	<p>Зэрэглэлийн хүчинтэй байх хугацааг тодорхой дурдаагүй, тодорхой хугацаанд тогтмол үзлэг шалгалт хийн, эрх зүйн актын зөрчил байгаа эсэхийг тодорхойлох хэрэгтэй. 2.2-д дурдсан материалаас гадна байгаль орчинд сөрөг нөлөө багатай, орчин үеийн эко шийдэлтэй зэргийг шалгуур үзүүлэлтэд оруулах хэрэгтэй. Энэхүү журмыг шинэчлэн тогтоох шаардлагатай байна.</p>

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030	Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, тэргүүлэх салбар тодорхойлсон. Бодлогын залгамж халаа, салбар хоорондын уялдааг хангах гол бодлого болсон. Гэсэн хэдий ч байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хуульд заагдсан байгаль орчны стратеги үнэлгээ хийгдээгүй, цаашдын дунд болон богино хугацааны бодлого, төлөвлөлтөд энэ асуудалд анхааран, байгаль орчинд хуримтлагдах нөлөөллийг харгалзаж үзэх шаардлагатай.
---	---

Эх сурвалж: www.Legalinfo.mn-д тулгуурлан боловсруулав.

Улсын хэмжээний урт, дунд, богино хугацааны бодлого төлөвлөлтөд аялал жуулчлалын салбарын хөгжлийн төлөвийг хэрхэн тодорхойлсон талаар авч үзье.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг 2001 онд баталсан бөгөөд одоогийн Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, олон улсын харилцаа тухайн үеийн нөхцөл байдлаас ихээхэн өөрчлөгдөөд байна.

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д Монгол Улс нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв болох зорилт тавьсан. Энэхүү зорилтыг 3 үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

1 үе шат (2016-2020): Байгаль, соёлын өвийн үйлдвэрлэл, үзмэрүүдийн голлох төвүүдэд жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, олон улсын тавцанд Монголын аялал жуулчлалын онцлог дүр төрхийг бүрдүүлэх, байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж гадаадын жуулчдын тоог 1.0 саяд хүргэх.

2 үе шат (2021-2025): Бүсийн хэмжээнд олон улсын аялал жуулчлалын замналд нэгдэх, дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, аялал жуулчлалын олон төрөл, улирлын чанартай аялал жуулчлалыг хөгжүүлэх, Монголын нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын сурталчилгааг тасралтгүй сайжруулах, гадаадын жуулчдын тоог 1.5 саяд хүргэх.

3 үе шат (2026-2030) : Байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж, нүүдлийн соёл, аялал жуулчлалын Монгол брэндийг дэлхийд сурталчлан, аялал жуулчлалаас орох орлогыг нэмэгдүүлэн, гадаадын жуулчдын тоог 2.0 саяд хүргэх хэмээн тус тус тодорхойлсон.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд аялал жуулчлалын салбарыг аж үйлдвэрийн тэргүүлэх салбарын нэг болгон тодорхойлсон нь энэхүү салбарыг хөгжүүлэх томоохон алхам болсон гэж хэлж болно.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т Аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг бүс нутгийн хэмжээнд дээшлүүлж, эрх зүйн

таатай орчинг бүрдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилт тавьсан.

1. Аялал жуулчлалыг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, олон улсын аялал жуулчлалын сүлжээнд нэгдэх, бүтээгдэхүүн, дэд бүтцийг хөгжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах цогц бодлого хэрэгжүүлнэ.

2. Үндэсний зан заншил, уламжлал, түүх, соёл, унаган байгаль, нүүдэлчин ахуйг түшиглэсэн аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, нийслэл, аймаг, бүс нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалын дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

3. “Бурхан халдун”, “Хорго-Тэрх”, “Хамарын хийд”, “Отгонтэнгэр”, “Хар-Ус”, “Хөвсгөл”, “Хархорин” зэрэг байгалийн үзэсгэлэнт, өвөрмөц тогтоц бүхий газар нутгийг түшиглэсэн түүхэн болон төрөлжсөн аялал жуулчлалын төв, цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын хөрөнгө оруулалтаар байгуулахыг бодлогоор дэмжинэ.

4. Монгол Улсын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг гадаад улс оронд сурталчлах, маркетингийн үйл ажиллагааг төрөөс дэмжиж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг сайжруулж, гадаад жуулчдын тоог нэмэгдүүлж, хил дээр олгодог цахим виз, визийн дэвшилтэт төрлүүдийг бий болгоно.

5. Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу байгальд ээлтэй зогсоол, үйлчилгээний төвүүдийг олон улсын стандартад нийцүүлэн байгуулахыг дэмжинэ.

6. Олон улсын аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага, туршлага, стандартыг нэвтрүүлэх, нутагшуулах, олон талт төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий судалгаа шинжилгээний орон тооны бус зөвлөл, нэгжийг байгуулна.

Түүнчлэн 2018 оны батлагдсан **“Гурван тулгуурт хөгжлийн бодлого”**-д “аялал жуулчлалын дэд бүтэц, өрсөлдөх чадварыг бүс нутгийн хэмжээнд дээшлүүлж, тухайн орон нутгийн онцлогт тулгуурласан иргэдийн оролцоотой тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх” зорилт тавигдсан байна.

Дээрх улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогод аялал жуулчлалын салбарыг байгаль орчин, ногоон хөгжлийн бодлоготой уялдуулан эдийн засгийн өсөлт, тогтвортой хөгжлийг дэмжих тэргүүлэх салбар болгох зорилт тавьсан нь салбарын цаашдын хөгжил болон бусад аж үйлдвэрийн салбартай нягт уялдуулан хөгжүүлэх таатай нөхцөл бүрэлдсэн байна гэж хэлж болно.

“Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т аялал жуулчлалыг өөрийн орны өвөрмөц онцлог болон олон улсын жишиг, чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлэх, эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгон улмаар олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж, стратегийн зорилтуудыг дэвшүүлэн, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тогтоож, нарийвчилсан төлөвлөгөөг гарган, нэгдүгээр үе шат буюу эрчимтэй хөгжлийн үе

2016-2020 он, хоёрдугаар үе шат буюу тогтвортой хөгжлийн үе 2021-2025 он хүртэл хоёр үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Энэхүү үндэсний хөтөлбөрийг авч үзэхэд өнөөгийн аялал жуулчлалын салбарын тулгамдаж буй томоохон асуудал болох эрс тэс цаг уурын байдлаас үүдсэн улирлын онцлог, аялал жуулчлалын бүтээгдэхүүний төрөлжилт хангалтгүй, бүтээгдэхүүний үнэ өндөр, жуулчин тээвэрлэх, хүлээн авах хүчин чадал бага, мэргэжлийн ажиллах хүчин дутмаг, салбарын сургалт, судалгааны чанар хангалтгүй, статистик бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангүй, жуулчдыг татахад чиглэсэн маркетинг, гадаад сурталчилгааны ажил хангалтгүй, үйлчилгээний стандарт, аюулгүй байдал хангагдаагүй зэрэг асуудлуудыг шийдвэрлэхээр 6 үндсэн зорилт тавьсан байна. Үүнд,

- Зорилт 1. Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг сайжруулж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх
- Зорилт 2. Аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлж, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг дэмжих, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг боловсронгуй болгох
- Зорилт 3. Аялал жуулчлалын салбарын судалгаа, мэдээллийн системийг хөгжүүлэх, жуулчдад зориулсан мэдээллийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх
- Зорилт 4. Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн хөгжил болон чадавхийг дээшлүүлэх
- Зорилт 5. Аялал жуулчлалын салбарын гадаад хамтын ажиллагаа, маркетинг, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх
- Зорилт 6. Дотоодын аялал жуулчлалыг дэмжих, аялах соёлыг түгээн дэлгэрүүлэх

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ 1) үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөр буюу үндэсний аюулгүй байдал, тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн хөгжлийн бодлоготой нийцсэн байх, 2) Монгол орны байгалийн унаган төрхийг хадгалах, орчны бохирдлыг багасгах, экологийн тэнцвэрт байдал, хүний эрүүл, аюулгүй орчинд аялах нөхцлийг хангах, орон нутгийн иргэдийн амьдрах орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар зохион байгуулах, 3) төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурлах, иргэд олон нийтийн оролцоог дэмжих, салбар дундын болон төв, орон нутгийн байгууллагын үйл ажиллагааны уялдааг хангах, 4) аялал жуулчлалын салбарт дэвшилтэт техник, технологи, тэргүүн туршлагыг ашиглах зарчим баримтлахаар тусгасан байна.

Үндэсний хөтөлбөрийн үндсэн зорилтыг авч үзэхэд тулгамдаж буй асуудлуудыг жигд хамруулж тусгаж чадсан бөгөөд хэрэгжүүлэх зарчмын хувьд ч оновчтой, агуулгын хувьд тогтвортой аялал жуулчлалыг дэмжих чиг хандлагатай гэж үзэж болно. Энэхүү үндэсний хөтөлбөр Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлагдахаас өмнө хэрэгжиж эхэлсэн хэдий ч зорилт, агуулгын

хувьд нийцэж байгаа, зорилтот жил дуусаагүй байгаа хэдий ч нэмэлт тодотгол хийх шаардлагатай. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хувьд хэт дэлгэрэнгүй хэрэгжүүлэх үе шатыг тодорхойлсон хэдий ч дэс дараалал ойлгомжгүй буюу хэрэгжих хугацаа урт, хариуцах байгууллага болон хамтран оролцогчдыг тодорхойлсон хэдий ч оролцогч талуудын үүрэг хариуцлагыг тодорхой зааж өгөөгүй, мөн жуулчдын тооноос өөр хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тогтоогүй байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хариуцагч яам, орон нутгийн удирдлага жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд илүү дэлгэрэнгүй тусгахаас гадна хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ, мониторинг хийн дараа дараагийн үйл ажиллагаандаа тусгах шаардлагатай. Түүнчлэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэх үйл ажиллагааны эрэмбэ, тэргүүлэх дарааллыг уян хатан тогтоох шаардлагатай. Салбарын яамны тухайд холбогдох яам, тамгын газартай хамтран жуулчин хүлээн авах чадварыг нэмэгдүүлэх, тээврийн үнэ тарифийн зохистой бодлого боловсруулах, гадаад хамтын ажиллагаа, маркетинг сурталчилгааны ажлыг идэвхи санаачлага гарган ажиллаж байгаа.

Аялал жуулчлалын гол чиглэл, хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлалын чиглэлийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн баталсан байна. Улсын хэмжээний аялал жуулчлалын чиглэлүүдийг бодлогын бусад баримт бичигт заасны дагуу “Аялал жуулчлалын гол чиглэл”, “Цайны зам”, “Торгоны зам”, “Их түмэн гол” болон бусад хил дамнасан аялал жуулчлал хөгжүүлэх чиглэлүүдийг “Хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлалын чиглэл”, орон нутгийн аялал жуулчлалын чиглэлүүдийг “Аймаг, нийслэлийн аялал жуулчлалын цэг” гэж томъёолсон байна.

Эдгээр чиглэлийг тогтоохдоо идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг 20 гаруй аялал жуулчлалын компани, мэргэжлийн холбоод, орон нутгийн удирдлагуудаас санал авч хэлэлцүүлэн шийдсэн байгаа нь сайшаалтай. Цаашид аялал жуулчлал хөгжих нөөц бололцоотой гол чиглэл дээр тулгуурлан байгаль орчны төлөв байдал, даац, нийгэм соёлын бусад хүчин зүйл, улсын болон бүсчилсэн хөгжлийн чиг хандлага, дэд бүтэц болон бусад салбарын хөгжилтэй уялдуулан хөгжлийн эрэмбийг тодорхойлох шаардлагатай.

Гол чиглэлийн дагуу аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжил, жуулчны аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлнэ. Шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж, гадаадын зээл, тусламжид хамруулах, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгаж байхаар шийдвэрлэсэн байна.

Аялал жуулчлалын салбарын холбогдох хууль тогтоомжоос гадна бусад аж үйлдвэрийн салбар, аж ахуйн нэгжийг үйл ажиллагааг дэмжих хөтөлбөрийн талаар авч үзлээ. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны мөрийн хөтөлбөр-т “Дотоодын үйлдвэрлэлийг гааль, татварын бодлогоор дэмжинэ” гэсэн заалт тусгагдсан бөгөөд энэхүү ажлын хүрээнд 3 гол татварын өөрчлөлт хийсэн байна. Үүнд, 1) Бүсийн хөнгөлөлтийн татвар, 2) Жилийн орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд 1 хувийн орлогын албан татвар ногдуулах, 3) Жижиг, дунд үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гаалийн албан татвараас чөлөөлөх асуудал тусгагдсан байна.

Аймаг, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 550 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар татварт ногдох орлогын албан татварыг чөлөөлөхөөр болсон ба 2017 оны 01-р сарын 01-ний өдрөөс хууль хэрэгжиж эхэлсэн. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд оруулсан жилийн борлуулалтын орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд ногдуулах татварыг 90 хувиар хөнгөлөх зохицуулалтыг тусгаж өөрчлөлт хийсэн ба доорх дөрвөн салбарыг хамруулахаар тусгасан.

1. Хүнсний үйлдвэрлэл
2. Оёдол, хувцас нэхмэлийн үйлдвэрлэл
3. Барилгын материалын үйлдвэрлэл
4. Газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл

Эдгээр салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн жилийн орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй албан татвар төлөгчийн үндсэн үйл ажиллагааны орлогод 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд 1 хувиар орлогын албан татвар ногдуулахаар буюу ногдуулсан татварыг 90 хувиар хөнгөлөхөөр болсон байна. Засгийн газрын 2017 оны 168 дугаар тогтоолын дагуу 2019 он хүртэл жижиг, дунд үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг Гаалийн албан татвараас чөлөөлдөг.

Гэтэл энэхүү татварын хөнгөлөлт аялал жуулчлалын салбар хамаарахгүй байгаа бөгөөд Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд аж үйлдвэрийн тэргүүлэх салбар хэмээн тусгагдан, цаашид хөгжлийн нөөц боломжтой тэр дундаа экспортын чиглэлийн салбарыг орхигдуулж болохгүй. Үүнээс гадна саяхан батлагдсан Монгол экспорт хөтөлбөрт мөн аялал жуулчлалын салбарын татварын хөнгөлөлт болон бусад хөшүүргээр дэмжих асуудал огт хөндөгдөөгүй байна.

10 сарын нд Гадаад хэргийн яамнаас зохион байгуулагдсан Экспортыг дэмжих семинарт Аялал жуулчлалын салбарыг экспортын чухал салбар хэмээн оролцогч талууд хүлээн зөвшөөрч, төрөөс экспортыг нэмэгдүүлэх тал дээр анхаарах асуудал болон цаашдын хамтын ажиллагааны талаар хэлэлцэн нэгдсэн ойлголтод хүрсэн нь нэгэн томоохон алхам болсон гэж үзэж байна.

3.2 Тухайн салбарын бүсчилсэн хөгжлийн түүхэн хандлага, өөрчлөлт, өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ

1992 оноос аялал жуулчлалын бүсчлэлийн тухай ойлголт дэлгэрч тэр үеийн Дэд бүтцийн хөгжлийн яамны Хүн амын нутагшил, хот байгуулалтын товчоо Украины Барилга хот байгуулалтын газартай хамтран “Амралт сувилал-Аялал жуулчлалыг хөгжүүлэх мужлал”-ыг тогтоосон.

1995 онд орон нутгийн онцлогийг харуулахуйц Орхон Хархорины, Хөвсгөл орчмын, Говийн, Дорнод Монголын, Өндөр уулын буюу Монгол Алтайн, Хэнтийн, Нийслэл хот орчмын гэсэн 7 бүсийг ялган тогтоожээ. 2005 оноос Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан Хангайн, Баруун, Дорнод, Төвийн бүсүүдэд дэд хөтөлбөр боловсруулан дагаж мөрдөх болсон.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг 2001 онд баталсан бөгөөд одоогийн Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, олон улсын харилцаа тухайн үеийн нөхцөл байдлаас ихээхэн өөрчлөгдөөд байна.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд үндэслэн боловсруулсан Монгол Улсын Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүсийн хөгжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжих хугацаа (нэгдүгээр үе шат-2006-2010 он, хоёрдугаар үе шат-2011-2015 он) дууссан.

Энэхүү үзэл баримтлалд бүсүүдийн байгаль, түүхий эдийн нөөц, оюуны чадавхийг харгалзан **баруун бүсэд**: бэлчээрийн мал аж ахуй, усалгаатай тариалан, жижиг, дунд боловсруулах үйлдвэрийг; **хангайн бүсэд**: бэлчээрийн мал аж ахуй, газар тариалан, **аялал жуулчлал**, амралт, сувилал, жижиг дунд үйлдвэр, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр; мод боловсруулах үйлдвэрийг; **төвийн бүсэд**: бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, жижиг, дунд үйлдвэр, **аялал жуулчлал**, **амралт сувиллын үйлчилгээ**, оюуны багтаамж ихтэй бусад үйлдвэрлэл, үйлчилгээг; **зүүн бүсэд**: уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, эрчимжсэн газар тариалан, мал аж ахуй, жижиг, дунд үйлдвэр, **аялал жуулчлалыг**; Улаанбаатарын бүсэд: оюуны багтаамж ихтэй бүх төрлийн үйлдвэр, үйлчилгээ, олон улсын банк санхүүгийн сүлжээг тус тус тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлнэ. Мөн байгаль орчныг хамгаалах хүрээнд:

- а. нийгмийн хөгжлийг байгаль орчны даац чадавхтай тэнцэлтэй уялдуулахад чухал ач холбогдол бүхий бүсийн болон бүс нутгийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
- б. уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, байгалийн гамшгийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгахтай холбогдсон хяналт, мэдээлэл, тусламжийн бүс нутгийн сүлжээ бүрдүүлэх;
- в. байгалийн баялгийг нөхөн сэргээх, хүн амын амьдрах орчны аюулгүй байдлыг хангахтай холбогдсон аймаг, сум дундын ач холбогдол бүхий

- нийтлэг арга хэмжээг санхүүжүүлэх нэмэлт эх үүсвэрийг бий болгох асуудлыг судлан шийдвэрлэх;
- г. бүс нутгийн байгалийн баялгийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, нөхөн сэргээх, амьдрах орчинд хал багатай дэвшилтэт арга технологи-нэвтрүүлэх, шилжүүлэх үйл ажиллагааг дэмжин урамшуулах;
 - д. тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг бүс нутаг, хот, тосгоны хөгжлийн чиг хандлагатай уялдуулан боловсронгуй болгох;
 - е. бүсийн хүрээнд байгалийн баялгийн нөөц ашигласны эцсийн үр өгөөжийг бүс нутаг бүрийн байгалийн нөөцийн хүрэлцээ, газрын үржил шим, зах зээлийн байрлалаас хамааралгүйгээр тухайн бүсийн аймаг, сумд адил тэнцүү хүртэх орлого хуваарилалтын зохистой тогтолцоог бүрдүүлэх;
 - ж. бүс нутгийн хөгжлийн асуудлыг байгаль орчны даац, нөөц баялгийн экологи-эдийн засгийн үнэлгээ, төлбөр, тооцооны үндсэн дээр шийдвэрлэх чадвар бүхий бүсийн байгаль орчны төлөвлөлт, удирдлагын бие даасан тогтолцоог бүрдүүлэх;
- з. бүсийн хүрээнд тодорхой газар нутгийг гадаадын сонирхогч улс орон, гадаадын хөрөнгө оруулагчдад гэрээний үндсэн дээр урт хугацаагаар түрээслэн ашиглуулж, байгаль орчин, хөгжлийн асуудлыг иж бүрэн шийдвэрлэх нөхцөлийг хангах зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан бүс тус бүрийн хөгжлийн бодлого боловсруулагдсан байна. Үүнд, аялал жуулчлалын салбарын тэргүүлэх зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, гарах үр дүнг 2 үе шатаар төлөвлөсөн. Дэлгэрэнгүйг дараах хүснэгтэд нэгтгэн харуулав.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд бүс тус бүрийн хөгжлийн хөтөлбөрт аялал жуулчлалын хөгжлийн бодлогыг тодорхойлсон. Өмнө дурдсанчлан тухайн бүс нутгийн аялал жуулчлалын нөөц бололцоог оновчтой тодорхойлон, тэргүүлэх зорилтод хүрэхийн тулд хэрэгжүүлэх үйл ажиллагааг боловсруулсан байна. Бүс нутгийн нөөц бололцоо, үнэт чанар цаашилбал аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нарийн тодорхойлж чадсан нь сайшаалтай. Гэсэн хэдий ч бодлогын хэрэгжүүлэх механизм тодорхойгүй, тэргүүлэх зорилт хэт ерөнхий бөгөөд зорилтот хугацаанд хэрэгжих боломжгүй өргөн хүрээтэй, бодлогын залгамж чанар хангалтгүй зэргээс бодлого хэрэгжээгүй гэж дүгнэж байна. Тухайлбал, баруун бүсэд аялал жуулчлалыг эдийн засгийн бие даасан салбарын хэмжээнд хүргэж оновчтой хөгжүүлнэ, төвийн бүсийн ДНБ-д аялал жуулчлалын салбарын эзлэх хувийн жинг тууштай өсгөнө гэсэн тэргүүлэх зорилт тус тус тавьсан байна. Иймэрхүү ерөнхий зорилтыг бүсийн хэмжээнд аялал жуулчлалын салбарын алсын хараа болгохын сацуу зорилтот жилийн хугацаанд бусад холбогдох салбарын төлөвлөлт, төсөв хөрөнгө, хүний нөөц зэрэгтэй холбон оновчтой тодорхойлох шаардлагатай.

Монгол улсын хувьд аялал жуулчлалын салбар өөрийн гэсэн өвөрмөц соёл, ёс заншил, амьдралын хэв маягтай. Хэдийгээр өргөн уудам нутагт түүх, соёлын дурсгалт газар ихтэй ч дэд бүтэц, мэргэжлийн үйлчилгээ, харилцаа холбоо, хөрөнгө оруулалт, улирлын нөлөөллөөс гарч өндөр түвшинд хөгжиж чадахгүй байна. 2017 оны байдлаар аялал жуулчлалын салбар ДНБ-ний 3.1%-ийг бүрдүүлж, жилд 471,094 орчим жуулчин хүлээж авч байна. Энэ салбарт 270 гаруй тур оператор компани, 499 зочид буудал, 375 гаруй жуулчны бааз үйл ажиллагаа явуулж, нийт 54,000 хүн тус салбарт ажиллаж байна.



Эх сурвалж: БОАЖЯ

Зураг 3.2.1. Жуулчдын тоо



Эх сурвалж: БОАЖЯ

Зураг 3.2.2 Жуулчдын тоо, орлого

Хүснэгт 3.2.2 Жуулчдын тоо, салбарын орлого (2016, 2017 оны харьцуулсан мэдээ)

Монгол улсад ирсэн нийт гадаадын иргэд		2016 он	2017 он	Өмнөх оны мөн үе ялгаа /тоо/	Өмнөх оны мөн үе ялгаа /хувь/
Нийт: Зорчигч		471 239	542 989	71 750	13,21%
Үүнээс: Жуулчин		404 156	471 094	66 938	14,21%
1	АЗИ НОМХОН ДАЛАЙ	231 350	269 615	38 265	14,19%
2	ЕВРОП	150 528	177 279	26 751	15,09%
3	АМЕРИК	20 462	22 216	1 754	7,90%
4	АФРИК	709	828	119	14,37%
5	ОЙРХИ ДОРНОД	1 107	1 156	49	4,24%

Жуулчид голлох зах зээлийг орноор


1	БНХАУ	131 312	144 070	12 758	8,9%
2	ОХУ	84 065	106 935	22 870	21,4%
3	БНСУ	57 587	74 985	17 398	23,2%
4	Япон	19 985	22 582	2 597	11,5%
5	АНУ	15 859	16 684	825	4,9%
6	Казакстан	13 370	14 234	864	6,1%
7	Герман	9 709	10 586	877	8,3%
8	Франц	9 035	10 044	1 009	10,0%
9	Австрали	5 631	6 689	1 058	15,8%
10	Их Британи	6 161	6 012	-149	-2,5%
11	Канад	3 052	3 434	382	11,1%
12	Нидерланд	2 872	3 099	227	7,3%
13	Турк	2 209	2 189	-20	-0,9%
14	Энэтхэг	1 713	1 888	175	9,3%
15	Украйн	1 470	1 309	-161	-12,3%
16	Бусад	40 126	46 354	6 228	13,4%

Аялал жуулчлалын салбарын орлого

	Ам.доллар	312 873 514	400 791 920	87 918 406	21,9%
--	-----------	-------------	-------------	------------	-------

Эх сурвалж: БОАЖЯ

Дэлхийн Эдийн Засгийн Форумаас хийгдсэн дэлхийн улс, орнуудын аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын судалгаагаар манай улс 2015 онд 141 орноос 99-нд, 2017 онд 136 орноос 102-р байранд орсон байна. Нийт үнэлгээ 3.3 оноо (нийт 7 оноо) авсан байгаагаас шалгуур үзүүлэлт тус бүрээр авч үзэхэд, бизнесийн орчин 4.4 оноо, аюулгүй байдал 5.7 оноо, эрүүл ахуй 5.8 оноо, хүний нөөц 4.5 оноо, цахилгаан холбоо 4.0 оноо, салбарын тэргүүлэх байдал 4.0 оноо, олон улсад ил тод байдал (агаарын тээврийн хамтын ажиллагаа, худалдааны гэрээ гм) 1.9 оноо, үнийн өрсөлдөөн 5.7 оноо, хүрээлэн буй орчны тогтвортой байдал 3.4 оноо, агаарын тээвэр 2.2 оноо, зам тээвэр, дэд бүтэц 2.1 оноо, аялал



Эх сурвалж: World Economic Forum, Travel & Tourism Competitiveness Index Ranking, 2017

Зураг 3.2.3 Монгол улсын аялал жуулчлалын салбарын үнэлгээ, 2017 он

жуулчлалын үйлчилгээ 2.7 оноо, байгалийн нөөц 2.7 оноо, соёлын өв болон бизнес аялал 1.8 оноо хэмээн тус тус үнэлэгдсэн байна.

Дээрх үнэлгээнээс харахад манай улсын аялал жуулчлалын салбарын үнэлгээ нэлээн доогуур байгаа төдийгүй, салбарын давуу тал болох байгалийн нөөц, соёлын өвийн үнэлгээ харьцангуй доогуур үнэлгээ авсан байна. Энэ нь аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрөл бага, дэлхий нийтэд танигдсан байдалтай хамааралтай. Өөрөөр хэлбэл, жуулчдад зориулсан мэдээллийн чанар, маркетингийн сурталчилгаа хангалтгүй байгаатай холбоотой гэж үзэж байна. Хүрээлэн буй орчны тогтвортой байдал 3.4 оноогоор үнэлэгдсэн байгаа нь цаашид аялал жуулчлалын салбарын тогтвортой байдалд шууд нөлөөлөх хүчин зүйл тул ихээхэн анхаарал хандуулах хэрэгтэй. Ялангуяа агаарын бохирдол, хог хаягдал зэрэг байгаль орчны бохирдлын асуудлыг нэн даруй шийдэхгүй бол аялал жуулчлалын салбарт ихээхэн сөрөг үр нөлөө үзүүлж байна. Түүнчлэн агаарын тээвэр болон дэд бүтцийг сайжруулахгүйгээр жуулчдын хүлээн авах хүчин чадал нэмэгдэх боломжгүй нь ойлгомжтой билээ.

Монголбанкнаас Монгол улсад аялж буй гадаадын жуулчдын зардлын түүвэр судалгааг 2011, 2015 онд гүйцэтгэсэн байна. Энэхүү судалгааны 2015 оны тайлангаас үзэхэд гадаадын жуулчид Монголд дунджаар 14 хонох хугацаандаа 1,744 ам.долларыг зарцуулж байна. Тухайлбал, хувийн аялагчид 1,526 ам.доллар, багц аялагчид 2,383 ам.долларыг тус тус зарцуулдаг байна. Багц аялалын нийт зардлаас гадаадын компанид ногдох ашгийг Монголбанкны 2011 оны судалгааны дагуу 30%-иар тооцон хасахад манай улсад үлдэх хэсэг нь 2,033 ам.доллар байна.

Хувийн аялагчдын зарцуулсан зардлын бүтцийг үзвэл нийт зардлын дунджаар 30%-ийг зочид буудалд, 24%-ийг ресторан, хоолны газарт, 20%-ийг бараа

худалдан авалт авахад зарцуулсан байна. Харин багц аялагчдын хувьд нийт аялагчдын хувьд нийт зардлынхаа 72%-ийг жуулчлалын компанид төлсөн байна.

Монголбанкнаас 2011 онд гүйцэтгэсэн судалгааны үр дүнтэй харьцуулбал гадаадын жуулчдын Монгол Улсад аялахдаа зарцуулсан дундаж зардлын хэмжээ 2015 онд дунджаар 31%-иар өссөн байх бөгөөд энэ нь өнгөрсөн 4 жилийн инфляцийн өсөлттэй холбоотой юм. Тухайлбал, жуулчид хамгийн их ирдэг 7-р сард жилийн инфляци дунджаар 11% байсан ба үүнээс зочид буудал, нийтийн хоол 12%, тээврийн үйлчилгээ 7%, амралт, чөлөөт цаг, соёлын үйлчилгээ 2%, бусад үйлчилгээ 11%-иар тус тус өссөн байна.

Жуулчдын дийлэнхи буюу 76% нь Монголын уламжлалт зан заншил, соёл болон үзэсгэлэнт байгаль, зэрлэг ан амьтанд татагдан хүрэлцэн ирсэн бөгөөд манай улсын аялал жуулчлалын үйлчилгээг 13% нь маш сайн, 46% нь сайн, 20% нь хангалттай, 17% нь дунд, 4% нь муу гэж үнэлээд, улмаар нийт жуулчдын 76% нь дахин ирнэ гэсэн хариултыг өгсөн байна.

Үүнээс харахад, Монгол улсыг зорьж ирсэн жуулчдын сэтгэл ханамж харьцангуй сайн байгаа бөгөөд дахин ирэх хүсэлтэй жуулчид дийлэнхи байгаа нь салбарын хөгжлийн бодлого, төр хувийн хэвшил, иргэдийн оролцоо, хамтын ажиллагааг оновчтой зохицуулах замаар салбарын хөгжлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэн, салбарын эдийн засгийн үр нөлөө, олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэх бүрэн боломжтой гэж хэлж болно.

Дэлхийн Аялал жуулчлалын байгууллагын салбарын үнэлгээ, шинжилгээ хийх аргачлалын дагуу салбарын өнөөгийн байдлыг дараах 4 үндсэн үзүүлэлтийн дагуу тодорхойлно. Үүнд,

1. Аялал жуулчлалын байгууллага (Tour operator)
2. Зочид буудал (Hotel)
3. Жуулчдын зорих газар (Destination)
4. Холбогдох байгууллага (Institution)

1) Аялал жуулчлалын байгууллага (тур оператор)

Аялал жуулчлалын тухай хуульд “аялал жуулчлалын байгууллага” гэж аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бүрдүүлэх, сурталчлах, худалдах, худалдан авах, аялал жуулчлалын багц буюу тухайлсан үйлчилгээг зохион байгуулж байгаа ашгийн төлөөх хуулийн этгээд хэмээн томъёолсон.

Монгол улсад аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулах бүртгэлтэй нийт 1400 гаруй компани байдгаас 2017 оны эцсийн байдлаар 270 гаруй аж ахуйн нэгж идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг байна. Эдгээр аж ахуйн нэгжүүд Монголын аялал жуулчлалын холбооны гишүүнчлэлтэй, салбарын тулгамдсан

асуудлыг мэргэжлийн холбоодоор дамжуулан Засгийн газар, холбогдох яам, тамгын газарт санал тавин, хамтран ажилладаг байна.

Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн хувьд БОАЖ-ын сайдын 2009 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн тушаалаар батлагдсан “Аялал жуулчлалын байгууллагын ангилал тогтоох журам”-ын дагуу ангилал тогтоолгон, ангилалд заагдсан чиглэлийн дагуу үйл ажиллагаа явуулна.

Ангиллын гэрчилгээг нэг жилийн хугацаатай олгох ба үйл ажиллагаа хэрхэн явуулж байгаад мэргэжлийн хяналтын улсын байцаагч хяналт тавьж, зөрчил илэрсэн тохиолдолд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ гэж журамд заагдсан байгаа. Энэхүү ангиллын гэрчилгээг Аялал жуулчлалын холбоо олгодог бөгөөд гэрчилгээ олгох нөхцөл, шаардлагыг дахин шинэчлэх хэрэгцээтэй болоод байна. Өнөөг хүртэл салбарын хөгжлийг дэмжих үүднээс аж ахуйн нэгжид тавих шалгуурт өндөр шаардлага тавигддаггүй, бүрдүүлэх бичиг баримтын хувьд өмнөх жилд үйлчилсэн жуулчдын тоо, санхүү, эдийн засгийн үзүүлэлт, бизнес төлөвлөгөө, бүтээгдэхүүн үйлчилгээний баталгаат байдлыг хангах, жуулчдын эрх ашгийг хамгаалах үүднээс жуулчинтай байгуулах гэрээний төсөл, аялалын хөтөлбөр, багц үнийн судалгаа, түрээсийн гэрээ эсвэл үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар, даатгалын байгууллагатай хийсэн гэрээ шаардагддаг. Өмнөх жилийн бизнес төлөвлөгөөний биелэлт хангалтгүй байх нь элбэг байдаг бөгөөд ангиллын гэрчилгээ авсан 1400 аж ахуйн нэгж байгаагаас тогтвортой үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж 270 байх зэргээр мэргэжлийн бус оролцогч их байгаа нь аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг үнэгүйдүүлэх, үйлчилгээний чанар болон салбарын нэр хүндэд сөргөөр нөлөөлж байна.

Аж ахуйн нэгжүүдийн хувьд шинээр аж ахуйн нэгжийн бүртгэл хийлгэх үедээ үйл ажиллагааны чиглэл дээрээ аялал жуулчлал гэж тэмдэглүүлдэг төдий, үйлчлүүлэгч жуулчид виз авах зэрэг ангиллын гэрчилгээг зайлшгүй авах шаардлага үүсэхгүй бол ангиллын гэрчилгээгүй үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж олон байдаг.

Энэхүү тур операторын ангилал болон аялал жуулчлалын стандартыг шинэчлэх шаардлагатай байгаа төдийгүй салбарын холбогдох мэдээлэл, статистикийн үнэн зөв тоо баримтыг бүрдүүлэх ажилтай уялдуулах шаардлагатай.

Тур оператор компаниудын бизнесийн үр ашиг жилээс жилд буурч, компаниуд маань давжаарч 500-1000 жуулчин хүлээн авдаг компанийн тоо 30-аас хэтрэхгүй, 500 хүртэл жуулчин хүлээн авдаг компани 50-иас илүүгүй байгаагийн гадна үлдсэн 400 гаруй компани нь улсад бараг татвар төлдөггүй хувиараа аж ахуй эрхлэгчид гэж хэлж болно³. Мэргэжлийн бус хэт олон компани үйл ажиллагаа явуулж буйгаас гадна, тур операторууд нэгдмэл бодлогогүй, хамтын ажиллагаа хангалтгүй байна. Гадаад зах зээлд аялалын компаниуд бүтээгдэхүүний үнийг 1-2 жилийн өмнө

³ МҮХАҮТ, Аялал жуулчлалын зөвлөлтэй хийсэн ярилцлагаас

зарладаг, Монголын үйлчилгээний байгууллагууд дотоодын үйлчилгээний үнийг 5-6 сарын өмнө өгдөг тул аялалын компаниуд алдагдалд ордог байна.

Аялал жуулчлал хөгжүүлэхэд агаарын тээврийн бодлого нэн чухал бөгөөд түүний нисэх чиглэл, нислэгийн давтамж, цагийн хуваарь, үнийн уян хатан бодлого аяллын компаниудтай хамтарч гадаад зах зээлд хийх маркетинг түүний үйлчилгээний чанар зэргээс жуулчдын тоо шууд хамааралтай билээ.

Монголын аялал жуулчлалын компаниудаас бусад орны аяллын компани PACKAGE буюу багц аяллыг худалдаалдаг харин манайд зөвхөн LAND буюу нислэгийн үнэ ороогүй аяллыг худалдаалж байна. Өөрөөр хэлбэл ихэнх орны агаарын тээврийн компаниуд аяллын компаниуддаа комисс өгөн өөрийн билетээ үндэсний компаниудаараа худалдуулж зах зээлийн үнэ хямдруулах боломжийг бүрдүүлж хамтарч ажилладаг.

Гадаад руу аялах аялагчдын тоо жилийн жилд нэмэгдэж байгаа хэдий ч хамгийн хямдаар аялна гэсэн массын ойлголт ая тух муутай, аюулгүй ажиллагааны эрсдэл өндөр тур операторуудыг сонгож байна⁴. Дотоодын аялал ч эрчимтэй хөгжихийн хирээр үүнийг дагасан хог хаягдал, дуу шуугианы асуудал газар авч байгаа учир аялагчдын боловсрол, соёлыг дээшлүүлэх тодорхой ажлуудыг хийх шаардлагатай. Аялагчдын эрх үүргийг хуульчлах шаардлагатай болж байна.

Тулгамдаж буй асуудал

Аялал жуулчлалын байгууллагын ангилалыг шинэчлэн, тухайн ангилалд зориулсан төрийн дэмжлэг, татаасд хамруулах шаардлагатай байна. Мэргэжлийн чанартай үйлчилгээ явуулдаг тур операторуудыг дэмжин, улирлын чанартай мэргэжлийн бус үйл ажиллагаа явуулж, улсад татвар төлдөггүй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих хэрэгтэй. Ингэхийн тулд мэргэшсэн хүний нөөцтэй байх шаардлагатай бөгөөд мэргэжлийн зэрэг, үнэмлэх олгох систем нэвтрүүлэн, аялал жуулчлалын ангилал олгохтой шууд уялдуулах хэрэгцээ гарж ирж байна. Хүний нөөцийн асуудал хүндрэлтэй байгаа нь улирлын хамааралтай холбогдохоос гадна мэргэжлийн бус байгууллага зөвхөн гадаад хэлтэй, оюутан сурагч нарыг цагаар авч ажиллуулдагтай холбоотой.

Статистик тоо баримтыг үнэн зөв гаргаснаар салбарын судалгаа, бодлого төлөвлөлтөд эерэг нөлөө үзүүлэх нь дамжиггүй. Салбарын оролцогчдын хамтын ажиллагаа, үүрэг хариуцлагт тодорхой тусган, тогтмол тоо мэдээлэл солилцон ажиллах шаардлагатай байна.

2) Зочид буудал, жуулчны бааз

Аялал жуулчлалын тухай хуульд “жуулчны үйлчилгээний байгууллага” гэж зочид буудал, жуулчны бааз, амралт сувилал, тээвэр, холбоо, үзвэрийн зэрэг үйлчилгээг жуулчинд үзүүлж байгаа байгууллага хэмээн томъёолсон байна.

⁴ МҮХАҮТ, Аялал жуулчлалын зөвлөлтэй хийсэн ярилцлагаас

Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас (ДАЖБ) гаргасан тодорхойлолтоор “тогтоосон тооны зочны өрөөтэй, эдгээр нь нэгдсэн удирдлагаар хангагддаг, цагаан хэрэглэл солих, зочны болон ариун цэврийн өрөөг цэвэр байлгах хамгийн анхан шатны шаардлагыг хангахаас эхлээд олон нэр төрлийн иж бүрэн үйлчилгээ үзүүлдэг, үйлчилгээний нэр төрөл, чанар, тавилга хэрэгсэл, тоноглолын түвшингээс хамаарч тодорхой ангилал зэрэглэлд хамрагддаг газрыг зочид буудал гэнэ” (Энхнаран.Б, 2015).

Манай орны хувьд дугаараар зэрэглэх систем хэрэглэгдэж байснаа 1998 оноос шинэ стандарт батлагдсанаар “Од” системээр зэрэглэх болсон. Дэлхийн улс орнуудад зочид буудлыг үйлчилгээний түвшингийн үзүүлэлтээр ангилахдаа зэрэглэлийн системийг ашигладаг. Зочид буудлын зэрэглэл тогтоох олон шалгуур үзүүлэлт байдаг боловч эдгээрээс хамгийн гол нь зочны тав тухтай байдлыг хангах үзүүлэлтийн түвшин юм⁵.

Зочид буудал, жуулчны баазуудын хувьд 2017 оны байдлаар улсын хэмжээнд 64 зэрэглэлтэй зочид буудал, жуулчны бааз, үүнээс Улаанбаатар хотод 57 зочид буудал, орон нутагт 7 байна (Хүснэгт 3.2.4) .

Хүснэгт 3.2.3 Зэрэглэлтэй зочид буудлын тоо

	Зэрэглэл	Байршил, тоо
1	5 одтой зочид буудал	Улаанбаатар хотод 4
2	4 одтой зочид буудал	Улаанбаатар хотод 6
3	3 одтой зочид буудал	УБ хотод 24, орон нутагт 2
4	2 одтой зочид буудал	УБ хотод 21, орон нутагт 2
5	1 одтой зочид буудал	УБ хотод 13, орон нутагт 3
Нийт		УБ хотод 57, орон нутагт 7

Эх сурвалж: Монголын Зочид буудлуудын Холбоо

2007 оноос дэн буудлын стандарттай болж MNS 4738;2007 стандарт, 2008 онд зочид буудлын стандартыг шинэчилж MNS 4588;2008, Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага MNS 5927;2008 стандартыг тус тус баталсан байна.

Жуулчны баазын тухайд Жуулчны баазын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага MNS 4934:2002 стандартын норматив ишлэл, нийтлэг шаардлага тавигддаг. Уг стандартаар Жуулчны бааз Аялал жуулчлалын бүс нутагт жуулчдыг

⁵ Хабдул НАЗЫМ, Дотоодын зочид буудлын үйлчилгээний өргөлдөх чадварыг нэмэгдүүлэх арга замууд, 2018

тав тухтай амраах, зугаацуулах, аялал жуулчлалын бүтээгдэхүүнтэй танилцуулах зорилго бүхий үйлчилгээний цогцолбор хэмээн тодорхойлсон байна.

Жуулчны баазыг хоёр зэрэглэлээр ангилж, цэцэг (эдельвайс буюу цагаан уул) ээр ялгаж тэмдэглэнэ. Зэрэглэл ахих тутам стандартын шаардлага, үйлчилгээний чанарын түвшин дээшилж, цэцгийн тоо нэмэгдэнэ. Зочид буудал, жуулчны бааз бусад байршлын хэрэгсэлд ангилал, зэрэглэл тогтоох комиссын “Үйлчилгээний чанарын зэрэглэл тогтооход баримтлах аргачлал”-ыг баримтална. Зэрэглэл тогтооход барилга байгууламж, галын аюулгүй байдал, эрүүл ахуй, инженерийн байгууламж, техникийн байдал, эдэлбэр газар, хүний нөөцийн хөгжилд тавих шаардлага болон үйлчилгээний тогтсон шаардлагыг хангасан эсэхийг харгалзана.

Энэхүү стандартад жуулчны бааз нь нэр, хаягтай, зочны байр, олон нийтийн буюу мэдээллийн байр, хоолны газар, ариун цэврийн болон бие засах газар, олон улс болон хот хоорондтой харилцах харилцаа холбооны хэрэгсэлтэй, баар, албан буюу ажилчдын байр, тусгай шүүгээ тавиуртай хүнсний барааны төрөлжсөн агуулах, угаалгын газар, амралт, тоглоомын талбай, сүүдрэвч, мэдээллийн самбар, хатуу хучилтан талбай бүхий тээврийн хэрэгслийн зогсоолтой байна.

Мөн жуулчны бааз руу очих замын дагуу жуулчны баазын нэр, эмблем, үйлчилгээний төрөл, хаяг бүхий замын тэмдгийг “Замын тэмдгүүд, Ерөнхий техникийн шаардлага MNS 4597:98” стандартын дагуу хийж байрлуулсан байна.

Түүнчлэн дээрх стандарт заагдсан MNS 4588:2008 Аялал жуулчлалын үйлчилгээ, зочид буудлын ангилал зэрэглэл техникийн шаардлага, MNS 4244:94 Галын аюулгүй байдал MNS 900:92 Ундны усны эрүүл ахуйн шаардлага MNS 4946:2000 Хоолны газрын үйлчилгээ MNS 4597:98 Замын тэмдгүүд, Ерөнхий техникийн шаардлага Галын аюулгүйн дүрэм БНББ 2.01-03-92, БНБД 2.01.02-85 Барилгын норм ба дүрэм 2.08.02-89 гэх мэт стандарт норматив ишлэлүүдийг баримтална .

Эдгээр стандартын хэрэгжилт, хяналтын механизм хангалтгүй, орон нутгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн Хяналтын газар гүйцэтгэлийн хяналт шалгалт хийдэг.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний зөвлөмжид дурдсаны дагуу хүрээлэн буй орчинг хамгаалж, нөхөн сэргээх, ус агаар хөрсийг бохирдуулахгүй байх шаардлагатай. МҮХАҮТ-ын даргын 2012 оны 1 сарын 16ны өдрийн 18 тоот тушаалаар “Ногоон буудал” эко шошго хэрэглэх эрх олгох журам батлагдсан байна. Энэхүү эко шошго нь байгальд ээлтэй үйлчилгээний менежмент нэвтрүүлж буйг гэрчлэх тэмдэг бөгөөд зочид буудал, зочлох үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд олгоно. Тухайн эко шошго хэрэглэх хүсэлт гаргасан аж ахуйн нэгжүүд өөрийн хувьд хамгийн бололцоотой 6 шалгуурыг хангаснаар нэг, 8 шалгуур хангаснаар хоёр, 10 шалгуур хангаснаар гурав, 12 шалгуур хангаснаар дөрөв, 14 шалгуур хангаснаар таван “Ногоон буудал” эко шошго хэрэглэх эрхтэй болно. Тухайн шошгоны үйл ажиллагаа, төлөвлөгөөний хэрэгжилтин байдлыг хагас жилд нэг удаа МҮХАҮТын

Ногоон зочид буудлын зөвлөл ба Цэвэр хөгжил, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих газраас шалгаж зөвлөгөө өгнө. Түүнчлэн жил бүр Ногоон буудал үзэсгэлэн яармаг зохион байгуулж, мөн цахим хуудсаар дамжуулж Ногоон буудал эко шошго хэрэглэх эрх авсан байгууллагуудын үйл ажиллагааг сурталчилах, ногоон буудлуудын сүлжээг байгуулах, аргачлал, туршлагыг дэлгэрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр дээрх журамд тусгагдсан байна. Одоогоор энэхүү шошгыг авсан аж ахуйн нэгж цөөхөн байгаа, хувийн хэвшлийн иймэрхүү санаачлагыг хууль эрч зүйн хэрэгжилттэй уялдуулан сурталчлах, хэрэгжүүлсэн байгууллагын бодит урамшуулал, татаас зэргийг бодлогоор дэмжин ажиллах шаардлагатай байна.

Хүснэгт 3.2.4 Монгол улсын зочид буудал, жуулчны баазын тоо

№		Зочид буудал	Дэн буудал	Амралтын газар	Рашаан сувилал	Жуулчны бааз	Гэр буудал	Нийт
	Улаанбаатар хот	210	322	30	6	234	40	842
1	Чингэлтэй	38	22	6				66
2	Хан-Уул	26	9	7	3	6		51
3	Сонгинохайрхан	15	69	10				94
4	Баянзүрх	29	86					115
5	Баянгол	62	91					153
6	Сүхбаатар	37	45	7		89		178
7	Налайх	3			3	139	40	185
8	Багахангай							0
9	Багануур	0			0	0	0	0
	Баруун бүс	31	14	17	9	21	18	110
1	Баян-Өлгий	6	3	1	2	8	2	22
2	Говь-Алтай	3	3	3	3	2		14
3	Завхан	3	6	6			10	25
4	Увс	7	2	3	3	8	4	27
5	Ховд	12		4	1	3	2	22
	Хангайн бүс	76	58	15	111	133	207	600
6	Архангай	10	2	3		26	9	50
7	Баянхонгор	8	25	3	5	3	20	64
8	Булган	17			86		17	120
9	Өвөрхангай	7		6	3	30	31	77
10	Хөвсгөл	6	14		17	74	130	241
11	Орхон	28	17	3				48
	Төвийн бүс	168	37	63	32	131	71	502
12	Дорноговь	17			3	7	19	46
13	Дундговь	5	9		1	15	4	34
14	Өмнөговь	61	10	4		25	48	148
15	Сэлэнгэ	53		16	3	10		82
16	Төв	3		37	23	73		136

17	Дархан-Уул	27	17	6	2			52
18	Говьсүмбэр	2	1			1		4
	Зүүн бүс	29	22	10	24	27	13	125
19	Дорнод	8	19	7	1	1	7	43
20	Сүхбаатар	10	3	2	1	4		20
21	Хэнтий	11		1	22	22	6	62
	Нийт	514	453	135	182	546	349	2179

Эх сурвалж: Судалгааны баг

Тулгамдаж буй асуудал

Зочид буудлын салбарын хувьд хүний нөөцийн асуудал нэн тэргүүнд тулгамдаж буй асуудал болоод байна. Их дээд сургуулиудад зочлохуйн ухааны хүний нөөц бэлддэг хэдий ч жил ирэх тусам элсэгч оюутны тоо эрс буурахын дээр зочид буудлын үйл ажиллагаа олон нийтэд сайн танигдаагүй, нэр хүнд төдийлөн сайнгүй байдаг тул бэлтгэгдсэн ажиллагсдын ажиллах нөхцөл хангалтгүй, тогтвор суурьшилтай ажиллагсад цөөн байдаг байна.

Түүнчлэн аялал жуулчлалын байгууллагын хувьд НӨАТ-аас чөлөөлөгддөг, зочид буудлуудын хувьд НӨАТ төлөгч тул үнийн уян хатан байдал дээр тур оператортай зөрөлдөх асуудал гардаг. Зочид буудал дээр гадаад валютаар төлбөр хийх, валют солих үйл ажиллагаа эрхлэхийг хориглосноор үйлчлүүлэгч нарт хүндрэл учруулахаас⁶ гадна тэр хэмжээгээрээ орлогыг бууруулах нөхцөл болж байна.

Жуулчдын баазууд нэг дор хэт олноороо бөөгнөрсөн тосгон маягийн хэлбэрт шилжиж байгаа нь хүрээлэн буй орчны бохирдол, байгалийн үзэмжит байдалд сөрөг нөлөө үзүүлж байна. Улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг тул байнгын ажиллах хүчин байхгүй, үйлчилгээний тухай ойлголт бага. Мөн хотоос зайдуу баазууд ч хүнс хангамжийн бүх материал (мах, сүү, өндөг, ногоо гэх мэт) хангаж байгаа нь хоолны чанар, хүнсний аюулгүй байдалд нөлөөлж, зардлыг нэмэгдүүлж байна. Жуулчны бааз болон орон нутгийн иргэд, малчид, нутгийн удирдлага хоорондын хамтын ажиллагаа хангалтгүйгээс орон нутгийн хөгжилд аялал жуулчлалын салбараас бодит хувь нэмэр оруулж чадахгүй байна⁷.

Түүнчлэн зочид буудал болон жуулчны баазын статистик тоо баримт хангалтгүй байна. Орон нутгаас авсан зочид буудал, жуулчны баазын тоо нь буудлын зэрэглэл, статус нь тодорхой бус байгаагийн дээр Статистикийн үндэсний газраас гаргасан тоо баримттай зөрдөг.

Эдгээр асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан зочид буудал, жуулчны баазын зэрэглэл тогтоох журам болон стандартыг шинэчлэх шаардлагатай. Ялангуяа жуулчны баазуудын хувьд байгаль хамгаалах, цэвэр үйлдвэрлэлийг хөгжүүлэх,

⁶ Монголын Зочид буудлуудын Холбоотой хийсэн ярилцлагаас

⁷ МҮХАҮТ, Аялал жуулчлалын зөвлөлтэй хийсэн ярилцлагаас


байгальд ээлтэй үйлдвэрлэл үйлчилгээ явуулах явдал дутагдалтай. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний зөвлөмжид дурдсаны дагуу хүрээлэн буй орчинг хамгаалж, нөхөн сэргээх, ус агаар хөрсийг бохирдуулахгүй байх шаардлагыг хэрхэн хангах талаар нэгдсэн төлөвлөлт, мэргэжлийн туслалцаа, хяналт байхгүй байна. Наад захын бохир соруулах машинтай жуулчны бааз байхгүй гэхэд хэлсдэхгүй.

Мөн зочид буудлууд ISO стандартуудыг бенчмаркинг хийж үйлчилгээний чанарын стандартуудыг хэрэгжүүлэх боломжийг судлах, цаашдаа энэ талын судалгаа хийх бүрэн боломжтой юм. Тухайлбал ISO10001 хэрэглэгчийн сэтгэл ханамж, ISO 10002 хэрэглэгчийн сэтгэл ханамж, санал гомдлыг шийдвэрлэх, ISO10003 хэрэглэгчийн сэтгэл ханамж, маргааныг шийдвэрлэх, ISO10004 хэрэглэгчийн сэтгэл ханамж, хяналт үнэлгээний зааварчилгаа гэсэн шатчилж хэрэглэгчийн сэтгэл ханамжийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн хоорондоо уялдаа бүхий стандартуудийг өөрийн байгууллагадаа тохируулан шатчилан хэрэгжүүлэх арга замыг судлах шаардлага мөн харагдаж байна.

3) Жуулчдын зорих газар

1992 оноос аялал жуулчлалын бүсчлэлийн тухай ойлголт дэлгэрч тэр үеийн Дэд бүтцийн хөгжлийн яамны Хүн амын нутагшил, хот байгуулалтын товчоо Украины Барилга хот байгуулалтын газартай хамтран “Амралт сувилал-Аялал жуулчлалыг хөгжүүлэх мужлал”-ыг тогтоосон.

1995 онд орон нутгийн онцлогийг харуулахуйц Орхон Хархорины, Хөвсгөл орчмын, Говийн, Дорнод Монголын, Өндөр уулын буюу Монгол Алтайн, Хэнтийн, Нийслэл хот орчмын гэсэн 7 бүсийг ялган тогтоожээ. 2005 оноос Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан Хангайн, Баруун, Дорнод, Төвийн бүсүүдэд дэд хөтөлбөр боловсруулан дагаж мөрдөх болсон. Сүүлийн жилүүдэд Говийн бүсийг нэмж аялал жуулчлалын 6 бүсэд ангилдаг болсон байна.



Эх сурвалж: БОАЖЯ

Зураг 3.2.4 Аялал жуулчлалын бүсчлэл

Манай улсын хувьд аялал жуулчлалын гол бүтээгдэхүүн, маркетинг нь онгон дагшин байгалийн үзэсгэлэн, нүүдлийн соёл ахуй дээр оршиж байгаа. Энэ утгаараа аялал жуулчлалын голлох чиглэл нь Тусгай хамгаалалтын газар нутаг (цаашид ТХГН) дагуу хөгжиж ирсэн бөгөөд Монголд ирж буй арван жуулчин тутмын найм нь аль нэгэн ТХГН-аар зорчсон байдаг⁸. Сүүлийн үед ТХГН-ийн хамгааллыг сайжруулахад байнгын тогтвортой ашиглалтын менежмент бүхий аялал жуулчлалыг хөгжүүлэх үзэл баримтлалыг олон улсад баримталж байна.

Олон Улсын Байгаль Хамгаалах Холбоо (ОУБХХ)-оос ТХГН-уудад тогтвортой аялал жуулчлалын менежментийг хэрэгжүүлэх замаар аялал жуулчлалыг хөгжүүлэх нь байгаль орчин, нийгэм, эдийн засагт эерэг нөлөөтэй болохыг дурджээ⁹.

Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 18% буюу нийт 28 сая га газар нутаг ТХГН-т бүртгэгдсэн байдаг. 1991 онд ЗГ-аас “Тусгай хамгаалалттай газрын дүрэм” батлан, тусгай хамгаалалттай горим, дэглэмийг тодорхойлж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийг 4 ангилалд оруулсан нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нэгдсэн сүлжээг бүрдүүлэх эхлэл болсон юм. 1997 онд “Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай” Монгол улсын хуулиуд шинээр гарч улмаар 1995 онд дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрын нийтлэг болон тусгай горимыг Засгийн газар, 1998 онд “Тусгай хамгаалалттай газар

⁸ Дэлхийн банк, 2011. Монголын аялал жуулчлалын салбар ба эдийн засгийн нөлөөлөл

⁹ Eagles, P.F.J., McCool, S.F and Haynes, 2002

нутгийн үндэсний хөтөлбөр"-ийг УИХ батлан гаргаж мөрдүүлснээр тусгай хамгаалалттай газар нутгийн талаархи эрх зүйн үндэс үндсэндээ бүрдээд байна гэж үзэж болно. Өнөөдөр Төрийн бодлого, хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх хүрээнд 30 орчим дүрэм, журам, заавар эрх бүхий байгууллагуудаар батлагдан хэрэгжиж байна.

Нийт 99 ТХГН байгаагаас Дархан цаазат газар 20 буюу нийт хамгаалалттай газар нутгийн 48,21%, Байгалийн цогцолборт газар 22 буюу нийт хамгаалалттай газар нутгийн 42,16% , Байгалийн нөөц газар 19 буюу нийт хамгаалалттай газар нутгийн 9,16%, Дурсгалт газар 8 буюу нийт хамгаалалттай газар нутгийн 0,47%-г эзэлдэг.Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтыг 24 хамгаалалтын захиргаа, зарим байгалийн дурсгалт болон нөөц газруудыг харьяа аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар хариуцаж үйл ажиллагаа явуулдаг.

Эдгээрээс гадна олон улсын ач холбогдолтой бүхий ус намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (RAMSAR, 11 газар) болон Шувуудад чухал газар (Important Bird Area, 70 газар), Дэлхийн шим мандлын нөөц газар (Biosphere Reserve, 6 газар) гэх зэргээр байгалийн үзэсгэлэнт асар их баялагтай. Түүнчлэн Юнескогийн дэлхийн өвийн конвенцид нэгдсэн (World Heritage, 4 газар) байдаг нь Увс нуурын байгалийн ай сав газар (байгалийн өв), Орхоны хөндийн соёлын дурсгалт газар (соёлын өв), Монгол Алтайн нурууны хадны сүг зургийн цогцолбор (соёлын өв), Бурхан Халдун уулын тахилгат газар (соёлын өв) юм. ЮНЕСКО-ийн дэлхийн өвд дээрхээс гадна Наадам болон Монгол ардын уламжлалт бүжиг, бие биелгээ, тууль, үндэсний цуур хөгжим, либэ гэх мэт 7 биет бус соёлын өв санд бүртгэгдсэн байна. Дэлхийн Эдийн Засгийн Форумас гаргасан аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын үнэлгээнд энэхүү үзүүлэлт хамгийн өндөр үнэлгээ авсан байна (136 орноос 8 байр, 2017).

2002 онд Байгаль орчны сайдын 117 дугаар тушаалаар Тусгай хамгаалалттай газар нутаг аялал жуулчлал явуулах тухай журам батлагдсан. Тус журамд ТХГН-т явагдах аялал жуулчлал нь тухайн ТХГН-ийн унаган төрх, экологийн даацыг алдагдуулахгүй байх нөхцөл шаардлагыг бүрэн хангасан, байгаль орчинд сөрөг нөлөөгүй хэлбэрээр явагдана гэж заагдсан. ТХГН-т явагдах аялал жуулчлал нь байгаль орчны болон аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөл,зохицуулалт, нэгдсэн хяналтын дор явагдана. ТХГН-т байнга байрлаж, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд БОС-ын 218 тоот тушаалаар "Тусгай хамгаалалттай газар нутаг дэвсгэрт газар ашиглах зөвшөөрөл олгох журам "-нд заасан нөхцөл болзлын дагуу БОАЖЯ-ны холбогдох газраас "ТХГН-т газар ашиглах гэрчилгээ"-г олгоно гэж заасан байна. Түүнчлэн газар ашиглах талаарх тухайн ТХГН-ийн хамгаалалтын захиргаа, сум, дүүргийн Засаг дарга, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын байгуулсан гурвалсан гэрээг баталж, биелэлтэд хяналт тавих, тухайн ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан газар ашиглалтын чиглэлийн дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийг үндэслэн Тусгай хамгаалалттай газар нутаг дэвсгэрт газар ашиглах Гэрчилгээ олгох, хугацааг нь сунгах эрхтэй. Аймаг, сум, дүүргийн Засаг дарга нь Байгалийн нөөц газар (БНГ), Дурсгалт газар

(ДГ)-ын аялал жуулчлал эрхлэх үйл ажиллагаанд хяналт тавих, БНГ, ДГ-т аялал жуулчлал эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагаас энэ журам болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд үйл ажиллагааг нь түр зогсоох үүрэг эрхтэй хэмээн тус тус заагдсан байна.

Гэтэл бодит байдал дээр дээрх журам бүрэн дүүрэн хэрэгжигдэхгүй байгаа нь нүдний өмнө ил байна. Ялангуяа Улаанбаатар хот орчмын ТХГН-т аялал жуулчлал эрхэлж буй жуулчны баазууд байгалийн унаган төрхийг алдагдуулсан барилга байгууламж байгуулан, хог хаягдал, хөрс, усны бохирдол нэмэгдүүлэн байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байна. Түүнчлэн аялал жуулчлалын зориулалтаар зөвшөөрөл авсан газарт орон сууц барих зэргээр ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй газруудад бизнесийн зорилгоор газар олгох зэрэг асуудал байсаар байна. БОАЖЯ-аас саяхан Горхи Тэрэлжийн ТХГН-т шинээр газар олгохгүй шийдвэр гаргасан байна. Мөн Хөвсгөл нуурын байгалийн цогцолбор газарт өвөлжөө, хаваржааны зориулалтаар иргэдэд газар олгосноор малтай иргэд ихээр суурьшиж нуурын экосистемийн тэнцвэрт байдал алдагдахад хүрээд байгаа тул нуурын хамгааллын менежментийн хэвийн үйл ажиллагааг хангах, аж ахуйн нэгжийн газар ашиглахтай холбоотой үйл ажиллагааг цэгцлэх, газрын нэгдсэн мэдээллийн сангийн нэгдсэн тогтолцоог холбоотой газар ашиглах эрхийг түр зогсоосон байна. Цаашид даацын судалгаанд үндэслэсэн ашиглалтын менежмент, хяналт мониторингийн ажлыг улам сайжруулах шаардлагатай байна.

БОАЖЯ болон Германы хамтын ажиллагааны GIZ байгууллага, KFW банкны хамтын ажиллагааны төслөөр Хорго Тэрхийн цагаан нуур БНГ, Орхоны хөндийн БЦГ, Отгонтэнгэр БЦГ, Тарвагатайн нурууны БЦГ-уудын 2017-2021 он хүртэлх аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөөг боловсруулсан байна. Эдгээр БЦГ-уудын аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ, маркетингийн үйл ажиллагааг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт, хяналт үнэлгээний аргачлал, санал зөвлөмжийг гаргасан байна.

“Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” /УИХ, 2016/ 2.3.1-т “... Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 50-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авах”, “Ногоон хөгжлийн бодлого” /УИХ, 2014/ 3.2.1-т “байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, цэнгэг усны нөөц, гол, мөрний урсац бүрэлдэх эхийн 60-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 2020 онд нийт нутаг дэвсгэрийн 25 хувь хүргэх”, Улсын Их Хурлын 1998 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр”-ийн 3.4-т “Байгалийн унаган төрхийг хадгалах, экологийн тэнцлийг хангах, байгалийн баялгийг арвижуулах, байгаль, түүх, соёлын өвийг хамгаалах зорилгоор байгалийн бүс, бүслүүрийн үндсэн шинж, иж бүрдлийг төлөөлсөн, экологийн онцгой ач холбогдол бүхий газар нутгаар тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, нийт улсын нутаг дэвсгэрийн 30-аас доошгүй хувьд хүргэнэ”, Ус үндэсний хөтөлбөр”-т “Гол мөрний урсац бүрэлдэх эхийн 60 хувьд хамаарах

газрын хилийг нарийвчлан тогтоож, улсын болон орон нутгийн хамгаалалтад авна”, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр /УИХ, 2016/-ийн 4.2.1-т “Байгалийн унаган төрхөө хадгалсан газар, цэнгэг усны нөөц, томоохон гол мөрний урсац бүрэлдэх эхийн 50-аас доошгүй хувийг улсын тусгай хамгаалалтад авна” хэмээн тодорхойлсон төрийн бодлогын баримт бичгийн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор 22 газрыг улсын тусгай хамгаалалтад авахаар “Зарим газар нутгийн улсын тусгай хамгаалалтад авах тухай” Улсын Их хурлын тогтоолын төслийг боловсруулан, УИХ-аар дэмжигдсэн байна. Эдгээр 22 газар нь 9 аймгийн 29 сумын нутаг дэвсгэрийг хамарч байгаа юм. Эдгээр газрыг Улсын тусгай хамгаалалтад авснаар талбайн хэмжээ 3.2 сая га-аар буюу нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь 2.1%-р нэмэгдэх юм байна.

Цаашид аялал жуулчлалын 6 бүс нутаг болон дээрх ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөтэй уялдуулан аялал жуулчлалын бүсчилсэн хөгжлийн бодлого боловсруулах шаардлагатай.

Одоогийн аялал жуулчлалын бүсүүдийг TALC онол болон Такаюки Отагийн (2011) хөгжлийн бүс нутагт тулгарах асуудлын шинжилгээний дагуу хөгжлийн үе шатыг тодорхойлж, цаашдын хөгжлийн нөхцөл буюу хэрэгжүүлэх арга хэмжээг санал болгож байна.

Хөшигийн хөндийн хувьд одоогоор аялал жуулчлал хөгжөөгүй байгаа хэдий ч Олон улсын нисэх буудал ашиглалтад орсноор хурдны зам болон ложистикийн төв байгуулагдана. Нисэх онгоцны буудлаас шууд жуулчдын зорих газар луу явах хувилбар төсөөлөгдөж байгаагаас гадна айрпорт сити дагасан жуулчдад зориулсан үйлчилгээ, мэдээллийн төв, аялалын бүтээгдэхүүн хөгжүүлсэнээр цаашид шинэ аялал жуулчлалын кластерийн бүс болох өндөр бололцоотой. Хөшигийн хөндийн бүсийг түшиглэн уламжлалт байгалийн аялал жуулчлалаас гадна бизнес аялал, ХАА аялал, шашны аялал гэх мэтээр төрөлжүүлэн хөгжүүлэхээс гадна Төв болон Хангайн бүсийн гол холбогч болно.

Зүүн бүсийн хувьд бүсийн хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан аялал жуулчлалын цогцолбор байгуулах төслүүд бодитоор эхлээд байна. Үүнд, “Мянганы суут хүн-Их эзэн Чингис хаан” түүхэн аялал жуулчлалын цогцолбор: Чингис хааны мэндэлсэн өлгий нутаг, Амар мөрний эх, Онон голын сав газрын зүрхэн хэсэг буюу Дадал сумын Дэлүүн болдог овооны өөдөөс харсан Бага Яргайт уулын энгэрт “Мянганы суут их хүн эзэн богд Чингис хаан” цогцолбор баригдана. Төсөл 2019-2024 онд бүрэн хэрэгжиж дуусах бөгөөд АХБ-ны 19 сая ам.доллар буюу 50 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдахаар төлөвлөгдөж байгаа.

Цогцолбор нь Чингис хааны цээж баримал хэлбэрийн томоохон барилга байх бөгөөд дагалдуулан 230 автобус болон суудлын машины хүчин чадалтай авто зогсоол, Дадал сумын төвөөс цогцолбор хүртэл 2.6 км хатуу хучилттай зам, 3.5 км цахилгааны шугам, үзэсгэлэн ба уулзалт зөвлөгөөн зохион байгуулагдах хурлын

танхим, утасгүй интернет орчин, мэдээллийн төвүүд, ариун цэврийн эко байгууламж 30 гаруй, хог хаягдлын дахин боловсруулах төв, саарал ус цэвэршүүлэх байгууламж зэргийг барьж байгуулахаар зураг төслийн ажлууд хийгдэж байна. Цогцолборт 25-30 хүний байнгын ажлын байр байхаас гадна Дадал суманд 9000 хүн ам суурьшиж, жилд хамгийн багадаа 90 мянган жуулчин ирж очих урсгал үүснэ хэмээн тооцоолж байгаа юм байна.

Эдгээр цогцолборын бүтээн байгуулалтын хувьд оролцогч талуудын хамтын ажиллагаа тэр дундаа орон нутгийн дэмжлэг, оролцоо туйлын чухал бөгөөд хүний нөөц бүрдүүлэх, тогтмол үйл ажиллагааг хангах, маркетинг, менежментийг хэн хариуцах хийх зэргийг нарийн шалгуур үзүүлэлттэй төлөвлөж, гүйцэтгэлийн үнэлгээг тогтмол хийн, үйл ажиллагааны төлөвлөгөөг тодотгон хэрэгжүүлэх хэрэгтэй. Учир нь томоохон бүтээн байгуулалтыг олон улсын өндөр хүүтэй зээлээр бариад, эхний хэдэн жил дотоод, гадаадын жуулчид ирэх хэдий ч энэхүү жуулчдын тоог тогтмол хэмжээнд өсгөх маркетинг, менежмент хийх шаардлага урган гарна. Ялангуяа хурлын танхимыг жилийн туршид ашиглагдах эсэх, автозамын болон олон улсын онгоцны буудлын бүтээн байгуулалтын ажлууд цаг хугацааны хувьд уялдах эсэхээс цогцолборын үйл ажиллагаа шууд хамаарна. Шаардагдах хүний нөөцийг одооноос бэлдэж эхлэх шаардлагатайгаас гадна орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, орон нутагт оруулах эдийн засгийн үр өгөөж, цаашдын урсгал зардал болон засвар үйлчилгээний зардал зэргийг тооцсон зорих газрын хөгжлийн үе шатыг нарийн тодорхойлох хэрэгтэй болов уу. Эдгээрээс гадна аялал жуулчлалын цогцолбор нь байгалийн унаган төрх үзэмжийг алдагдуулахгүй байх үндсэн зарчмыг аливаа бүтээн байгуулалтад баримтлах хэрэгтэй. Байгалийн онгон төрх, олон мянган жилийн түүх соёлын үнэ цэнэ гэдэг эргэн нөхөн сэргээгдэхгүй үнэт баялаг гэдгийг бодолцон, БОНБУ-г хуулийн дагуу гүйцэтгэх нь зүйтэй.

Баруун бүсийн хувьд дэлхийн шим мандлын нөөц газрын сүлжээнд хамрагдсан байгалийн үзэсгэлэн, олон үндэстний түүх соёлын өв зэрэг аялал жуулчлалын нөөц ихтэй бүс юм. Алтай Таван богд, Цамбагарав, Мөнх хайрхан, Цагаан дэглий, Түргэний нуруу, Хархираа зэрэг өндөр уулс, Увс нуур, Хар Ус нуур, Тэс Тургэн, Хархираа зэрэг нуур, голын ай сав газар зэрэг байгалийн бүс бүслүүрийг нэг дор агуулсан үзэсгэлэнт байгальтай. Үүндээ түшиглэн уулын аялал, загасзлах, завиар аялах, ховор амьтан, усны шувууд харах зэрэг тусгай сонирхлын аялалыг төрөлжүүлэн хөгжүүлэх нөөц бололцоо ихтэй, энэ бүсэд ихэвчлэн 2 долоо хоноогоос дээш хугацаанд аялдаг Европ, Америкийн жуулчид ихээр ирдэг. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хөгжлийн зам хөтөлбөрт Хар-Ус нуурын аялал жуулчлалын цогцолбор байгуулах төлөвлөгөө орсон байгаа. Одоогоор нарийвчилсан төлөвлөлт, судалгаа хийгдээгүй байна.

Төвийн бүсийн тухайд аялал жуулчлалын дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн гэж хэлж болох ч, үйлчилгээний стандартын хувьд хангалттай бус гэж хэлж болно. Аялал жуулчлалын дэд бүтэц болон маркетингаа сайжруулснаар MICE болон

бизнес аялал, хил орчмын болон хил дамнасан аялал хөгжүүлэх бүрэн боломжтой. Босоо тэнхлэгийн төмөр зам, авто зам болон хөндлөн тэнхлэгийн автозам огтолцож буйгаас гадна ХАА, хөнгөн аж үйлдвэр хөгжүүлэх нөөц бололцоо өндөр бүс юм. Энэ утгаараа ХАА аялал жуулчлал хөгжүүлэх, жуулчдад зориулсан зам дагуух байгууламж байгуулан орон нутгийн эдийн засаг, иргэдийн амьжиргаанд шууд нөлөөлөх бүрэн бололцоотой гэж үзэж байна. Түүнчлэн аж үйлдвэрийн томохон 2 хотод түшиглэн ирээдүйн үйлдвэрийн аялал, бизнес аялал хөгжүүлэх, Алтанбулаг худалдааны чөлөөт бүс төвтэй хил орчмын болон хил дамнасан аялал хөгжүүлж болно.

Говийн бүсийн хувьд эх газрын говийн унаган төрх, ан амьтан, ургамал, байгалийн ховор үзэгдэл, байгалийн тогтоц, палентологийн олдвор зэрэг аялал жуулчлалын нөөц ихтэй бүс билээ. Хамрын хийд, Хүслийн уул, Өвгөн суварга, Луутын цав, Дэмчогийн хийд, Эрээтийн хийд, Цогзолын хийд зэрэг Буддын шашны түүх, зан заншлыг харуулсан домог хууч ихтэй тул шашны аялал, соёлын аялал жуулчлал хөгжүүлэх нөөц бололцоо ихтэй. Замын-Үүдийн худалдааны чөлөөт бүс, Гашуунсухайт зэрэг боомтууд дээр түшиглэсэн хил орчмын болон хил дамнасан аялал мөн хөгжих боломжтой.

Хангайн бүс нь Хөвсгөл нуурын үзэсгэлэнт байгаль, ан амьтан, Орхоны хөндийн үзэсгэлэнт байгаль бүхий түүх соёлын ховор дурсгал, эртний хот балгасын туурь, хөшөө зэрэг нөөц баялгаар арвин.

Хүснэгт 3.2.5 Аялал жуулчлалын ивент арга хэмжээ

12 сар	1 сар	2 сар
		<ul style="list-style-type: none"> • Шинийн нэгний нар харах • Мөнгөлөг шагшуурга - цас мөсний баяр • Улаанбаатарын өвлийн наадам • Нүүдэлчдийн өвөл - Цагаан сарын баяр
3 сар	4 сар	5 сар
<ul style="list-style-type: none"> • Хөвсгөлийн мөсний баяр • Түмэн тэмээний баяр • Аялал жуулчлалын үзэсгэлэн яармаг • Наурызын баяр • Хаврын Бүргэдийн баяр – 2018 		<ul style="list-style-type: none"> • Дэлхийн нүүдлийн шувуудын өдөр • Хангинахын Шагайн тойром • Сайханы сарлаг - наадам (Өмнөговь)
6 сар	7 сар	8 сар
<ul style="list-style-type: none"> • Улаанбаатар марафон - Олон улсын гүйлт • Улаанбаатур - Үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэн яармаг • Тогорууны баяр • Нүүдэлчин наадам 	<ul style="list-style-type: none"> • Цаатан наадам • Дээлтэй Монгол – наадам • Монгол төрийн их наадам • Адуучин – наадам • Элсний фестиваль • Эр бор харцага - эртний Монгол наадам 	<ul style="list-style-type: none"> • Баруун Монгол ардын язгуур урлагийн наадам • Баргажин - 2018 олон улсын наадам • 99 бяцхан баатарын аялал – наадам • Адууны баяр (Өвөрхангай)

	<ul style="list-style-type: none"> • Сарлагийн баяр (Өвөрхангай) • Алтаргана – наадам • Сарлагийн наадгай (Баянхонгор) • Нүүдэлчин наадам 	<ul style="list-style-type: none"> • Үндэсний тоглоомын баяр • Mongolia bike challenge • Нүүдэлчин наадам
9 сар	10 сар	11 сар
<ul style="list-style-type: none"> • Нүүдэлчдийн өдөр – наадам • Бүргэдчидийн баяр • Говийн олон улсын марафон гүйлт • Нүүдэлчин наадам 	<ul style="list-style-type: none"> • Бүргэдчидийн баяр 	

4) Аялал жуулчлалын холбогдох байгууллага

Ерөнхий сайдын дэргэдэх аялал жуулчлалын зөвлөл

Аялал жуулчлалын тухай хуульд заагдсанаар Ерөнхий сайдын дэргэд аялал жуулчлалын зөвлөл байгуулагдсан байдаг хэдий ч тодорхой үйл ажиллагаа явуулаагүй байдалтай байна. Цаашид шийдвэр гаргах үйл явцад энэхүү зөвлөл ахлан, зөвхөн салбарын хүрээнд бус олон талын оролцогч, бусад салбарын бодлого, төлөвлөлт болон бусад асуудлыг харгалзан өргөн хүрээнд хэлэлцэх хэрэгтэй.

БОАЖЯ-ны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газар

БОАЖЯ-ны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газар нь аялал жуулчлалын салбарын бодлого боловсруулах, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, төсөл, хөтөлбөр боловсруулж зохицуулах үүргийг хүлээн ажилладаг.

Энэ үндсэн үүргийн хүрээнд аялал жуулчлалын талаарх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийг боловсруулах ажлыг зохион байгуулах, зохицуулах, аялал жуулчлалын байгууллага, аж ахуйн нэгжийн менежментийг сайжруулах, аялал жуулчлалын мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчийг мэдээллээр хангах, аялал жуулчлалын талаар нутгийн захиргааны байгууллага, мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллага, иргэдийг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Энэ нэгжийн үйл ажиллагаа нь сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн даргад Засгийн газрын бодлогын хэрэгжилтийг хангахтай холбогдсон шийдвэр боловсруулан гаргахад дэмжлэг үзүүлэх, сайдад мэргэшлийн зөвлөгөө, шаардлагатай мэдээлэл, шуурхай үйлчилгээ, бүх талын дэмжлэг үзүүлэх замаар хэрэгжинэ. Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга, аялал жуулчлалын байгууллага, аж ахуйн нэгж байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, аялал жуулчлалын чиглэлээр дотоод, гадаадын байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэд байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд

оролцох гол түнш нь яамд, нутгийн захиргааны байгууллага, холбогдох бусад газар, мэргэжлийн холбоод, салбарын аж ахуйн нэгжүүд байна¹⁰.

Аялал жуулчлалын хөгжлийн төв

Аялал жуулчлалын хөгжлийн төв 2017 оны 1 сарын 4-ны өдөр байгуулагдсан Төрийн өмчит үйлдвэрийн газар юм. 17 хүний бүрэлдэхүүнтэй байхаар батлагдсан ч үйл ажиллагаа жигдрээгүй, одоогоор 3 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус төв БНСУ-ын Аялал жуулчлалын агентлагтай (Korea Tourism Organization: КТО) салбарын хүний нөөцийн хөгжил дээр хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийх, сургалтын хөтөлбөр боловсруулах, статистик аргачлал сайжруулах, Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө боловсруулах дээр хамтран ажиллахаар төлөвлөж байна.

Цаашид үйл ажиллагааны чиглэл, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэн, бодлого төлөвлөлтийн хэрэгжилт, хяналт, оролцогч талуудын хамтын ажиллагааны зохицуулалтыг хариуцуулан ажиллуулах боломжтой.

Монголын аялал жуулчлалын холбоо

Монголын аялал жуулчлалын холбоо нь 1992 онд байгуулагдсан. Одоогийн байдлаар 150 гишүүнтэй. Мөн 2018 онд энэхүү холбооны дэргэд Жуулчны баазуудын зөвлөл байгуулагдсан бөгөөд холбооны гишүүн болох саналаа гаргасан жуулчдын бааз олон байна. Аялал жуулчлалын холбоо нь гишүүддээ үйлчилдэг ТББ бөгөөд төрийн байгууллага болон хувийн хэвшлийн гүүр болон ажилладаг.

Үндсэн үйл ажиллагаа нь аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжид ангиллын гэрчилгээ олгох, мэргэжлийн сургалт семинар зохион байгуулах, олон улсын болон улсын хэмжээний аялал жуулчлалын үзэсгэлэн зохион байгуулах, төрийн бодлого, хууль эрх зүйн боловсруулалт, шинэчлэлтэд хувийн хэвшлийн дуу хоолойг хүргэж ажилладаг.

Түүнчлэн аялал жуулчлалын стандарт шинэчлэх ажлын хэсэгт Аялал жуулчлалын холбоо орж, аж ахуйн нэгжийг төлөөлөн санал хүсэлтээ тусгуулж ажиллаж байна.

Монголын Зочид буудлуудын Холбоо

Монголын Зочид буудлуудын Холбоо нь 1997 онд анх байгуулагдсан. Гишүүнчлэлийн хувьд үндсэн 45 гишүүн (үүнээс орон нутгийн 2) , оролцогч гишүүн 200, дэмжигч 100 гишүүнтэй. Гишүүддээ үйлчилдэг ТББ-ын статустай. Салбарын үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаанд мэргэжлийн чиглэлээр зөвлөгөө өгөх, үйлчилгээний ажилтнуудыг мэргэшүүлэх, мэргэжил эзэмшүүлэх сургалт, семинар зохион байгуулах, оролцогч талуудтай хамтран ажиллах, боловсролын

¹⁰ БОАЖЯ-ны цахим хуудас, www.mne.mn

байгууллагуудыг дэмжих, салбарын бодлого, хууль эрх зүйн шинэчлэлийн боловсруулалт, зочид буудлуудын зэрэглэл тогтоох комисс, стандартын техникийн хороонд төлөөлөн оролцдог.

Мэргэжлийн холбооны үндсэн чиг үүргийн хүрээнд гишүүдийн эрх ашгийг хамгаалах, хууль эрх зүйн хүрээнд тулгарч буй асуудлуудыг нөлөөллийн үйлчилгээний дагуу санал бодлыг тусгах, төрөөс гарч буй бодлого чиглэл, хууль эрхзүйн тогтолцоонд үнэлгээ хийх баг ажиллуулж, салбарын бизнес эрхлэгчдийн өмгөөллийн үйл ажиллагаанд арбитрын үүрэгтэй оролцож, зөвшилцөлд хүрэх эрх зүйн орчинг бүрдүүлэхэд хамтран ажилладаг байна.

Холбогдох салбарын бодлоготой уялдуулах

Аялал жуулчлалын салбарын хувьд байгаль орчин, зам тээвэр, дэд бүтэц, орон нутгийн бодлого чухал ач холбогдолтой.

Ялангуяа агаарын тээврийн бодлого аялал жуулчлалын салбарын хөгжилд шууд нөлөөлдөг нэн чухал оролцогч билээ. Агаарын тээврийн нисэх чиглэл, нислэгийн давтамж, цагийн хуваарь, үнийн уян хатан бодлого аяллын компаниудтай хамтарч гадаад зах зээлд хийх маркетинг түүний үйлчилгээний чанар зэргээс жуулчдын тоо шууд хамааралтай гэж хэлж болно.

Монголын аялал жуулчлалын компаниудаас бусад орны аяллын компани PACKAGE буюу багц аяллыг худалдаалдаг харин манайд зөвхөн LAND буюу нислэгийн үнэ ороогүй аяллыг худалдаалж байна. Өөрөөр хэлбэл ихэнх орны агаарын тээврийн компаниуд аяллын компаниуддаа комисс өгөн өөрийн билетээ үндэсний компаниудаараа худалдуулж зах зээлийн үнэ хямдруулах боломжийг бүрдүүлж хамтарч ажилладаг. Эдгээр асуудлыг зохицуулахад агаарын тээврийн либералчлал чухал үүрэг гүйцэтгэнэ. Энэ оны 6 сард Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого батлах тухал тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолыг ЗТХЯ-аас УИХ-ын даргад өргөн барьсан байна. Энэхүү өөрчлөлтөд дараах асуудал тусгагдсан байна.

Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал ашиглалтад орсноор зээлийн хөрөнгөөр баригдсан нисэх буудлын ашиглалтыг сайжруулахын тулд агаарын харилцааг либералчлах шаардлага зүй ёсоор гарч ирж байгаа бөгөөд энэ нь Монгол Улсын Засгийн газрын хүлээх үүрэг юм. Агаарын харилцааны үе шаттай либералчлалын бодлогыг хэрэгжүүлэх, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн агаарын тээврийн үйлчилгээг тэлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, олон улсын нислэгийн үнэ, тарифыг бууруулахад чиглэсэн бодлогын шийдвэр гарган хэрэгжүүлэх зорилгоор дээрх бодлогод өөрчлөлт оруулах тогтоолын төслийг боловсруулжээ.

“Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын 3.8, 3.9 дэх заалтыг “Агаарын харилцаанд чөлөөт өрсөлдөөнийг дэмжиж, нислэгийн давтамжийг суудлын багтаамжтай уялдуулан үе шаттай нэмэгдүүлэх зарчмаар

олон улсын нислэгийн шугамыг хуваарилах, агаарын тээврийг эдийн засгийн хувьд зохицуулах чиглэл баримтлах”, “Гадаад улсаас Монгол Улс руу хуваарьт нислэг үйлдэх тээвэрлэгчийн тухайд үндэсний компанийн өрсөлдөх чадварыг харгалзан, ижил тэнцүү орчинд өрсөлдөх бодлого баримтлах”-аар өөрчлөн найруулахаар тусгасан байна.


Үнэхээр агаарын тээврийг либералчилж, чөлөөт өрсөлдөөнийг дэмжиж чадвал гаднаас ирэх жуулчдын урсгалыг татах хүчин зүйл болно. Энэ жил Чингис хаан олон улсын нисэх буудал 1200 мянган зорчигчдод үйлчилсэн. Шинэ олон улсын нисэх онгоцны буудал ашиглалтад орсноор ойрын 3-аас 5 жилд гурван сая зорчигчдод үйлчлэх хүчин чадалтай болно. Түүнчлэн одоогийн нисэх буудал нисэх зурвас зөвхөн нэг талаасаа буух, хөөрөх зурвастай бол шинэ нисэх буудал хоёр талаасаа бууж, хөөрөх зурвастай болно. Мөн Улаанбаатар хотоос Олон улсын шинэ нисэх буудал холбосон хурдны замыг 2018 оны 10 дугаар сард бүрэн ашиглалтад оруулахаараар төлөвлөж ажиллаж байна. Хурдны зам ашиглалтад орсноор 20-25 минутад олон улсын нисэх буудалд хүрэх боломжтой болно.

Үүнээс гадна эдийн засгийн чөлөөт бүс болон 100 мянган хүнтэй нисэх буудлын дагуул хот буюу Айрпорт сити байгуулах төлөвлөгөөтэй. Шинэ олон улсын нисэх буудал болон айрпорт ситид түшиглэсэн аялал жуулчлалын шинэ бүсийг хөгжүүлэх боломжтой.

Төрөөс Иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогод Агаарын харилцаа, агаарын тээвэр, аялал жуулчлалын болон агаарын тээврийн салбарын бодлогын уялдаа холбоог хангах ажлын чиглэл орсон байгаа бөгөөд бодлогын тодотгол хийх ажлын дэд хэсэгт БОАЖЯ-ны АЖБХГ-аас орж ажилласан.

Агаарын тээврийн зорчигчийн тоо 2017 оны ХБГ-ээр 1,161,543 байсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 138,498 зорчигчоор буюу 14 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ЗОРЧИГЧ



Эх сурвалж : ЗТХЯ


Зураг 3.2.6 Агаарын тээврийн зорчигчийн үзүүлэлт

2017 оны 3 дугаар улирлын байдлаар олон улсын нийт 18 чиглэлд 728,718 зорчигч тээвэрлэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16 хувиар буюу 101,090

зорчигчоор өссөн үзүүлэлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад олон улсад Улаанбаатар-Улаан-Үүд-Улаанбаатар чиглэл нэмэгдсэн байна.


Төмөр замын хувьд 2016 оны 12 дугаар сарын байдлаар зорчигчийн тоо 194.0 мянга болж, орлого 35.6 тэрбум төгрөг болж, 15.0 (29.6%) тэрбум төгрөгөөр буурчээ. Төмөр замын зорчигч тээвэрлэлтийг нэмэгдүүлэхийн тулд онлайнаар захиалга нэвтрүүлсэн байна. Цаашид зорчигчдод ая тухтай, ачааны аюулгүй байдлыг ханган саадгүй тээвэрлэхийн тулд босоо тэнхлэгийн гол замын цариг болон дохиоллын системийг шинэчлэх, огцом эргэлттэй хэсгүүдийн зайг засаж шахах, вагоныг шинэчлэх, тогтмол бөгөөд хурд сайтай болгохын тулд вагоны үйл ажиллагааны хяналтын системийг сайжруулах зэрэг ажил зайлшгүй шаардлагатай юм байна.

Олон улсын зорчигчийн тоо - Чиглэл тус бүрээр



Эх сурвалж : ЗТХЯ

Зураг 3.2.7 Агаарын тээврийн олон улсын зорчигчийн тоо



Эх сурвалж: ЗТХЯ

Зураг 3.2.8 Төмөр зам болон агаарын тээврийн зорчигчийн тоо

2011 онд хийгдсэн Монгол Улсын агаарын харилцааны либералчлалын үр нөлөөний тухай судалгаагаар (ЭЗБӨЧСТ) либералчлалыг хэрэгжүүлснээс хойш 2-3 жилийн дараа олон улсын нислэг 112 хувиар өснө. Монгол Улс бусад улс оронтой харилцаа холбоо сайжирч, Европ, Хойд Америк зэрэг томоохон зах зээлд агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг болно; Зорчигчийн тийзний үнэ дунджаар 42 хувиар буурч, зорчигчид 121 сая ам.доллар хэмнэнэ; Олон улсын ачаа тээврийг 62 хувиар, орон нутгийн зорчигчийн тоог 43-87 хувь хүртэл нэмэгдүүлнэ гэжээ.

Жил тутам 117,000 олон улсын зорчигч шинээр нэмэгдэж, 94 сая ам.долларыг эдийн засагт оруулна. Иргэний нисэх, аялал жуулчлал, эдийн засгийн бусад салбарт 21540 байнгын ажлын байр бий болгож, нийт хөдөлмөр эрхлэлтийг 2.1 хувиар өсгөнө. Жил тутам зуу орчим сая ам.доллар эдийн засагт орох нь Монгол Улсын ДНБ-ийг 2.5 хувиар нэмэгдүүлэх боломжтой гэжээ. Монгол улс агаарын тээврээ яаралтай чөлөөлөх шаардлагатай нь тод томруун харагдаж байна.



Эх сурвалж: ЗТХЯ

Зураг 3.2.8 Авто замын салбарын төлөвлөлт

А Булган Үенч Ховд чиглэлийн 60 км хатуу хучилттай авто зам.

Б Өлгийн Ховд чиглэлийн 189.7 км хатуу хучилттай авто зам. 4 багц ажил. Хэрэгжих хугацаа 2015-2018

В Дархан Улаанбаатарчиглэлийн 220 км хатуу хучилттай авто замын их засвар, шинэчлэлт
Г Дорнод аймгийн Хэрлэн сум Хавиргын боомт чиглэлийн авто замаас Эрээнцэв боомт хүртэлх 160 км авто зам
Д Дорнод аймгийн Хэрлэн сум Хавиргын боомт чиглэлийн 125.5 км хатуу хучилттай авто зам
Е Баруун Урт Бичигт чиглэлийн 272 км хатуу хучилттай авто зам.
Ё Баруун Урт Чойбалсан чиглэлийн 200 км хатуу хучилттай авто зам.

Зам дагуух үйлчилгээний цогцолборын хувьд 2014 онд Зам, тээврийн яамны Авто замын хяналт, эрдэм шинжилгээ, судалгааны төвөөс авто замын дагуух үйлчилгээний цогцолбор, ангилал, ерөнхий шаардлагын стандарт төсөл боловсруулсан. Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2016 оны 4 дүгээр сарын 28ны өдрийн 18 дугаар тогтоолоор батлагдсан байна. Үүнээс гадна 2017 оны 11 сарын 24-нд Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу авто замыг төлөвлөх нь сэдвээр хэлэлцүүлэг, семинарыг ЗТХЯ, БОАЖЯ, Азийн дэд бүтцийн судалгааны хүрээлэнтэй хамтран зохион байгуулан дараах зөвлөмжийг гаргасан байна. Үүнд:

1. Аялал жуулчлалын гол чиглэлээс тэргүүлэх чиглэлийг тодорхойлон тус чиглэлийн дагуу зам болон авто зогсоол, замын гарцын барилгын ажлын төлөвлөгөө, зам дагуух үйл ажиллагааны төлөвлөлтийг шийдэхэд БОАЖЯ, ЗТХЯ-тай хамтран ажиллах ;
2. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр олон улсын стандарт шаардлагад нийцсэн Зам дагуух үйлчилгээний цогцолборыг барьж байгуулан аялал жуулчлалыг хөгжүүлэн, орон нутгийн эдийн засагт хувь нэмэр оруулан, тогтвортой хөгжлийг хангахад хамтран ажиллах;
3. Монгол Улсын улсын чанартай авто замын сүлжээний дагуух замын тэмдэг, тэмдэглэгээг сайжруулах, замын зурвас газар дахь байгууламжуудын төлөвлөлтийг оновчтой болгох, одоо байгаа шаардлага хангахгүй болон зөвшөөрөлгүй барилга, байгууламжуудыг хууль эрх зүйн хүрээнд арга хэмжээ авч шийдвэрлэх;
4. Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуух тусгай хамгаалалтай газар нутагт аяллын замыг хөгжүүлэх судалгаа хийж, аюулгүй, ая тухтай аялах боломжийг бүрдүүлэх төлөвлөлтийн санал, зөвлөмж боловсруулах;
5. БОАЖЯ-тай хамтран тусгай хамгаалалттай газар нутаг дахь газар зүйн мэдээллийн санг бүрдүүлэх;
6. Аялал жуулчлалын 1:1000000 (ханын зураг монгол, англи хэл дээр) болон 1:2000000 (эвхмэл – монгол, англи, орос, герман, япон, солонгос, хятад хэлүүд дээр) масштаб бүхий газрын зургийг боловсруулах;
7. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнт болон суурин төхөөрөмжүүдэд суурилуулах зорилгоор онлайн болон онлайн бус орчинд ажиллах байршил

тогтоох аялал жуулчлалын маршрутын мэдээлэл бүхий программ хангамж боловсруулах;

8. “Монгол Улсын авто замын үндэсний атлас”, “Монгол Улсын авто замын сүлжээ ба аяллын товхимол”, “Монгол Улсын авто замын сүлжээ” 1: 1 000 000 масштаб-тай газрын зураг зэрэг бүтээлүүдэд санал, шүүмжийг тусган, хянан тохиолдуулж, хэвлэн олшруулж, олны хүртээл болгох.

Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуух Зам дагуух үйлчилгээний цогцолборын хувьд аялал жуулчлалын хөгжил төдийгүй, орон нутгийн эдийн засагт хувь нэмэр оруулан, тогтвортой хөгжлийг хангах чухал үүрэгтэй.

ЖАЙКА-ийн Монгол улсын Бүсчилсэн хөгжлийн нэгдсэн судалгааны тайланд Японы Мичино эки зам дагуух үйлчилгээний цогцолборын Монгол хувилбарыг санал болгосон байна. Энэхүү зам дагуух үйлчилгээний цогцолбор нь түр амрах зориулалтын цогцолбороос гадна орон нутгийн хөгжлийг дэмжих байгууламж бөгөөд 1) явуулын зорчигч, аялагчид “түр амран буудаллах”, 2) орон нутгийн иргэдэд зориулсан “мэдээлэл түгээх, солилцох”, 3) зам дагуух үйлчилгээний цогцолборт түшиглэн тухайн орон нутгийн иргэд хоорондын хамтын ажиллагааг дэмжих “орон нутгийн хамтын ажиллагаа” гэсэн 3 үндсэн үүрэгтэй.

Монгол улсын хувьд өргөн уудам нутаг дэвсгэртэй тул холын замын ачаа тээвэрлэлтэд зайлшгүй шаардлагатай авто засвар, терминал, хяналтын цэг, ХАА гаралтай бүтээгдэхүүний логистик хаб төв, шуудан ачаа хүргэлтийн төв, борлуулалтын төв зэрэг үйлчилгээг төвлөрүүлж хөгжүүлэх хэрэгтэй. Хэрэгжүүлэхийн тулд ХАА-н гаралтай бүтээгдэхүүний өртгийн сүлжээ бүрдүүлэх, ХАА-н үйлдвэрлэл, технологийн парк зэрэг холбогдох бодлого, хөтөлбөртэй уялдуулахаас гадна төр хувийн хэвлийн түншлэл, тэр дундаа орон нутгийн иргэдийн оролцоог хангах асуудал чухал. Мичино экигийн менежментийн талаар Япон улсын жишээг Хавсралт хэсэгт тодорхой дурдсан болно.

3.3 Салбарын хөгжлийн цаашдын чиг хандлага

Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас олон улсын аялал жуулчлалыг 6-н бүс нутгийн ангилан тогтоосон. Үүнд: Европын бүс нутаг Америкийн бүс нутаг Африкийн бүс нутаг Зүүн Ази болон Номхон Далайн бүс нутаг Өмнөд Азийн бүс нутаг Ойрхи Дорнодын бүс нутаг зэргээр ангилсан. Орчин үед дэлхий дахины хөгжлийн ерөнхий чиг хандлага нь зохистой хэрэглээг төлөвшүүлэх, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг хөгжүүлэх, улс орнуудын өөр өөрийн өвөрмөц шинж төрх, баялагаа хадгалах замаар улам бүр даяаршлагдаж байна. Тус байгууллагаас гаргасан урт хугацааны урьдчилсан мэдээгээр 2030 он гэхэд олон улсын жуулчдын тоо 1.8 тэрбумд хүрч, дэлхийн хэмжээгээр жилд дунджаар 3.3 хувиар өсч, үүний үр дүнд олон улсын аялал жуулчлалын зах зээлд жил бүр 43 сая жуулчин шинээр нэмэгдэнэ гэж судалгаа гаргажээ. Харин ирэх 20 жилд нэг өдөрт дундажаар 5 сая орчим хүн амралт, зугаалга, бизнес, гэр бүл, найз нөхдийндөө

зочлох зорилгоор олон улсын аялал хийх юм байна. Салбарын өсөлт нь эдийн засаг, нийгмийн төрөл бүрийн төсөл, хөтөлбөрүүд, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг дэмжих зэрэг олон зүйлд эерэгээр нөлөөлж, маш их шинэ боломжуудыг бий болгоно гэж Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын ерөнхий нарийн бичгийн дарга Талеб Рифай онцлон дурьджээ. 2015 оноос олон улсын аялагчдын тоо 2030 он гэхэд даруй 58 хувиар өснө гэж судлаачид таамаглаж байна.

Хойд Америкийн бүсийн аялал жуулчлалын өсөлт хамгийн удаан байна гэж таамагласан байна. Мөн 2030 он гэхэд Зүүн Хойд Ази дэлхийн хамгийн олон хүн аяладаг дэд бүс нутаг болно гэжээ. Үүнийг дагаад манай оронд ирэх жуулчдын тоо өсч болох юм. Түүнчлэн 2020 гэхэд нийт жуулчдын тоо 1995 онтой харьцуулахад 3 дахин нэмэгдэж 1.6 тэрбумд хүрэх хандлагатайг дээрх судалгаанд мөн дурьджээ. Аялалын чиглэлээс харвал Ази, Номхон далайн орнуудаар аялах жуулчдын тоо нэмэгдэх хандлагатай байгаа аж.


Үүнээс харахад манай улсад ирэх жуулчдын тоо эрс нэмэгдэх боломж өндөр бий. Сүүлийн арван жилд Монгол улс нь адал явдлын жуулчдын аялал жуулчлахыг хүсдэг газрын нэг болсон бөгөөд адал явдал, спорт аялал, явган аялал, ууланд авирах, загасчлах, ан хийх, шувуу ажиглах зэрэг тусгай сонирхолын аяллын төрлүүдээрээ гадаадын зах зээлд нэр хүндтэй болж байна. 2012-2014 онд үйл ажиллагаа явуулсан Спорт, Соёл, Аялал Жуулчлалын Яам нь аялал жуулчлалын бодлогыг энэ чиглэлээр тодорхойлж шувуу ажиглах, динозаврын өлгий нутгаар аялах зэргээр төрөлжүүлэн хөгжүүлэхээр зорьж байв. Монгол улс нь Цармын бүргэд, Ёл шувуу, бусад төрөл зүйлийн махчин шувуу гэх мэт жигүүртэн амьтдын төрөл зүйлээрээ баялаг бөгөөд Өрөвтас, Мөнгөлөг Цахлай, Релик Цахлай зэрэг усны шувуудаараа алдартай. Яамны зүгээс Монгол оронд тусгай сонирхолын аялал жуулчлалыг хөгжүүлэн адал явдлын, палеонтологи судлал, шувуу ажиглах, ургамал цэцэг судлах, соёлын болон түүхийн, нүүдэлчин аж амьдрал болон шашны зэрэг чиглэлээр тус тусад нь хөгжүүлэх бүрэн боломжтой гэж үзсэн. Монгол улсад нийт 50 гаруй ховор төрөл зүйлийн загас үрждэг 2000 нуур байдаг. Ан сонирхогчид болон загасчид манай улсад ирж өөрсдийн хувийн рекордоо эвдэх тун их сонирхолтой байдаг.

Манай улсын хувьд аялал жуулчлалын хөгжил, өрсөлдөх чадварыг зөвхөн нөхцөл, нөөц, бүтээгдэхүүн үйлчилгээ, тур оператор байгууллагын чадамж, гадаад сурталчилгаа зэргээр тодорхойлох нь хангалтгүй билээ.

Иймд аялал жуулчлалын үндсэн чиглэлийг тодорхойлох замаар замаар Засгийн газраас урт, дунд хугацаанд баримтлах салбарын бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, хөгжлийн тогтолцоог бэхжүүлэх суурь, судалгааны ажлыг нэн тэргүүнд эхлүүлсэн. Үүнд Засгийн газраас анх удаа аялал жуулчлалын үндсэн чиглэл (маршрут)-ийг тогтоох суурь судалгааны ажлыг хийж, хөрөнгө оруулалт, дэд бүтцийг барьж байгуулах, жуулчны аюулгүй ая тухтай аялах нөхцлийг бүрдүүлж

төрөөс аялал жуулчлалын талаар баримтлах урд, дунд хугацааны бодлого, төлөвлөлтийг боловсруулах нөхцлийг бүрдүүлэхээр зорьсон байна.

Монгол улсын аялал жуулчлалын гол бүс нутагт жуулчдын урсгалыг ихээр бий болгож буй жуулчны зах зээл бол дотоодын аялагчид юм. Сүүлийн жилүүдэд шинээр авто зам баригдаж авто машин эзэмшигчдийн тоо ихсэн өрхийн дундаж орлого өссөнтэй холбоотойгоор зах зээлийн хэсэг нэг хэсэг болох дотоодын аялагчдын тоо нэмэгдэх болсон.




Эх сурвалж: БОАЖЯ

Зураг 3.3.1 Монгол улсын аялал жуулчлалын чиглэл

Жуулчдад зориулсан нүүдлийн ахуйг харуулсан баяр ёслол, арга хэмжээ (event) жуулчны бус улирлуудад зохион байгуулах нь жуулчны улирлыг уртасгах, жуулчны нэмэгдүүлэх гол арга хэрэгсэл юм. Одоогоор хамгийн алдартай арга хэмжээ бол үндэсний тусгаар тогтнолыг тунхаглан тэмдэглэдэг “Баяр Наадам” юм. Улаанбаатар хотод жил бүрийн 7 сард зохиогддог төрийн наадмын нээлтийн тасалбар нь олдоц муу, хүн ихтэй, хэт арилжааны шинж чанартай болдог. Иймд сүүлийн үед гадаадын жуулчид аймаг, сумын наадмыг сонирхох хандлагатай болж байна. Мөн улсын баяр наадмыг 7 хоног болгох санал гарч хэлэлцэгдэж байна. Наадмаас гадна бусад төрлийн баяр, арга хэмжээ сүүлийн үед зохион байгуулагдах болсон. Жишээ нь: Баян-Өлгий аймагт зохион байгуулагддаг Бүргэдийн Баяр, Хөвсгөл аймгийн Мөсний Баяр, Өмнөговь аймгийн Тэмээний Баяр зэргийг дурьдаж болно. Эдгээр арга хэмжээ нь жуулчдад нүүдэлчин амьдрал, уламжлалт хэв маягтай танилцах боломжоор хангахаас гадна орон нутгийн иргэдийг аялал жуулчлалын үйл ажиллагаанд татан оролцуулах боломж олгодог.

Манай улсын хувьд 2 том зах зээлтэй зэрэгцэж оршдог давуу талаа ашиглан, хил орчмын дэд бүтцийг сайжруулах ажлыг эрчимжүүлэх нь зүйтэй. ОХУ, БНХАУ-ын талаас хилийн бүсэд аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хамтран ажиллах санал тавьдаг байна. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд Монгол улсын эдийн засгийг бүхэлд нь Зүүн бүсийн нутгаар дамжуулан Зүүн болон Зүүн хойд Азийн орнуудтай хоршин хөгжүүлэх гол чиглэл болгох, Баруун бүсээр дамжуулан БНХАУ, ОХУ, Казакстан, Европын Холбооны Улс, Төв Ази, Дундад Ази,




Эх сурвалж: БОАЖЯ

Зураг 3.3.2 Хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлалын чиглэл

Ойрхи Дорнодын орнуудын худалдаа, эдийн засгийн сүлжээнд холбогдох, Хангайн болон Төвийн бүсийг ОХУ, БНХАУ-ын зах зээлийн багтаамжинд түшиглэн Ази, Европыг холбосон хөгжлийн замтай уялдуулах гарцыг илрүүлж, бүс нутгийг холбон зохицуулах чиглэлээр ажиллах, Зүүн хойд Азийн орнуудын хувьд Монголын Зүүн бүсийн Чойбалсан, Сүмбэр, Нөмрөгийн чиглэлээр Номхон далайн бүс нутгийн орнуудтай холбох тээврийн коридорыг бий болгох асуудлыг чухалчилж оруулсан.

Үүний дагуу Монгол улс, БНХАУ, ОХУ-ын “Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх Монголын талын Үндэсний ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд энэ оны 8 сард БНХАУ-ын ӨМАЗО-ын Эрээн хотод 10 дахь удаагийн Хятад, Монгол, Оросын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны чуулга уулзалт, 9 сард гурван улсын Тинк танк холбооны форум Улаанбаатар хотод зохион байгуулагдсан. Тус форумын хуралдаанаар зам тээврийн нэгдмэл системийн хамтын ажиллагаа, эрчим хүч ба нөөц ашиглалтаас гадна аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагаа хил дагуух болон хил

дамнасан аялал жуулчлалын хамтын ажиллагааны ач холбогдлыг онцлон тэмдэглэсэн билээ.



Эх сурвалж : ЗТХЯ

Зураг 3.3.3 Монгол, Хятад, ОХУ-ын Эдийн засгийн корридорын төсөл

2017 онд зохион байгуулагдсан Монгол, Орос, Хятадын хамтарсан “Цайны зам”-ын олон улсын холбооны хурлын үеэр аялал жуулчлалын бүтээгдэхүүн сурталчлах бизнес аялал зохион байгуулагдаж, гурван улсын аялал жуулчлалын аж ахуйн нэгж хоорондоо хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна.

Мөн 2018 оны 7 дугаар сард гурван улсын Аялал жуулчлалын сайд нарын гуравдугаар хуралдаан Улаанбаатар хотод зохион байгуулагдан аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагааны цаашдын хөгжлийн талаар хэлэлцсэн байна. Талууд хамтын ажиллагааны үндсэн чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна.

- Томоохон хотуудад гурван улсын аялал жуулчлалын мэдээллийн төвийг туршилтаар байгуулах боломжийг эрэлхийлэх
- Орон нутгийн аялал жуулчлалын хүрээнд хөрөнгө оруулалт, зочид буудал, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, тодорхой зорилго бүхий соёлын, аялал жуулчлалын арга хэмжээг зохион байгуулахыг дэмжих

- “Цайны зам” олон улсын аялал жуулчлал бренд бий болгох ажлыг үргэлжүүлэх

Түүнчлэн Засгийн газраас аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх ажлын хүрээнд Хэнтий аймгийн Дадал сумын нутагт “Мянганы суут хүн-Их эзэн Чингис хаан” түүхэн аялал жуулчлалын цогцолбор байгуулах, Хөвсгөл нуурын БЦГ-т “Нутгийн иргэдийн амжиргааг дээшлүүлэх, орчны доройтлыг бууруулах, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх”, “Ганга, Өгий нуурын экосистемийг хамгаалах-Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх”, аялал жуулчлалын гол зам, чиглэлийн дагуу түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолборууд байгуулах, Улаанбаатар хотод албан, бизнес аялал жуулчлалыг хөгжүүлэх зэрэг олон ажлуудыг эхлүүлээд байгаа юм.

Мөн аялал жуулчлалын үндсэн чиглэл болон “Цайны зам”, “Торгоны зам”, “Их түмэн гол” зэрэг бусад хил дамнасан аялал жуулчлал хөгжүүлэх чиглэлүүдийг тодорхойлсон. Эдгээр чиглэлүүд дэхь хилийн боомтын үйл ажиллагааг идэвхижүүлэхэд хил орчмын аялал жуулчлалын талаарх төрөөс баримтлах бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөрш улсуудтай хилийн дэглэмийн гэрээг шинэчлэх, визийн хөнгөлөлт буюу E-visa бүрдүүлэлтийг холбогдох яамд авч хэлэлцэж байгаа.

Эдгээрээс гадна Монгол Улсад аялал жуулчлалын статистик мэдээллийг тооцоолох “Tourism Satellite Account” буюу Аялал жуулчлалын тусгай дансны аргачлалыг нэвтрүүлэх, аялал жуулчлалын тандалт судалгааны төв – “UNWTO Sustainable Tourism Observatory Center” байгуулахад хамтран ажиллах, гар утсанд суурилсан ухаалаг аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ зэрэг аялал жуулчлалын дижитал технологийг нэвтрүүлэх болон бусад асуудлуудаар санал солилцон ажиллаж байна¹¹.

Томоохон бүтээн байгуулалтын хувьд Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт (2018-2021) аялал жуулчлалын салбарын 1) Тогтвортой аялал жуулчлалыг дэмжих төсөл, 2) Аялал жуулчлалын голлох чиглэлийн авто зам дагуу түр буудаллах, үйлчилгээний цогцолбор, 3) Аялал жуулчлалын “Ногоон морь” төсөл гэсэн 3 төсөл орсон байна. Түүнээс гадна холбогдох бусад салбараас Зүүн өмнөд Говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл, Бүс нутгийн хилийн үйлчилгээг сайжруулах төсөл (АХБ-ны хөнгөлөлттэй зээл) болон Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх 2 дахь шатны төсөл зэрэг хэд хэдэн орон нутгийн хатуу хучилттай автозамын төслүүд орсон байна.

Салбарын яамнаас орон нутгийн 6 нисэх онгоцны буудлыг олон улсын статустай болгон жуулчдын тээвэрлэлтийн болон жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх стратеги баримталж байгаа бөгөөд өнөөг хүртэл Төв болон Хангайн бүсэд төвлөрч ирсэн жуулчдын урсгалыг Зүүн болон Баруун бүс рүү шилжүүлж, жуулчдын зорих газрыг хөгжүүлэх бололцоотой болно. Орон нутгуудын хувьд

¹¹ БОАЖЯ-ны Аялал Жуулчлалын Бодлого Зохицуулалтын газартай хийсэн ярилцлагаас

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон бусад бодлогын бичиг баримтад тулгуурлан аймгийн хөгжлийн хөтөлбөр, аялал жуулчлал хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулан ажиллаж байна.

21 аймгийн хөгжлийн хөтөлбөрөөс харахад бүх аймаг аялал жуулчлалыг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх, бие даасан салбарын хэмжээнд хөгжүүлэх зорилт тавьсан байна. Аймгуудын аялал жуулчлалын ерөнхий төлөвлөгөө болон дэд хөтөлбөрүүдэд өөрийн орон нутгийн аялал жуулчлалын нөөцөд тулгуурлан хөгжлийн зорилт, чиг хандлагаа тодорхойлохын зэрэгцээ аялалын маршрутыг хэд хэдэн хувилбараар боловсруулсан байна.

Энэ оны 11 сарын 23-нд БОАЖ-ын сайд аялал жуулчлалын нэгдсэн цахим платформын бүтээгдэхүүнийг шинээр гаргаж ирсэн “Chamelion Strategies” компанитай хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурсан байна. Зөвхөн Монгол гэдэг платформиос гадна “Торгоны зам”, “Цайны зам”, “Их Түмэн гол санаачилга” төсөл, Төв Азийн орнууд гэх утгаараа Монгол улс илүү олон чиглэлээр сурталчилгаагаа хийх боломжийг бүрдүүлсэн ухаалаг онлайн платформуыг бий болгон 2019 оны гуравдугаар сарын 30-ны өдөр албан ёсоор нээхээр ажиллаж байгаа юм байна. Түүнчлэн Монгол Улсад цахим дээр суурилж хийгдэж байгаа бүх гадаад, дотоодын захиалга, хайлтуудыг үндэслээд аль зах зээлээс Монгол Улсыг илүү сонирхож байгаад бид маркетингаа чиглүүлэх, аль зах зээл багасч байгаа, юуг хайж байгаа түүнд нь таарсан үйлчилгээ, бүтээгдэхүүнийг бий болгох тал дээр технологийн дэвшлийг ашиглан анализ хийж, датанд суурилсан төлөвлөлт хийх ажлыг эхлүүлэхээр дэлхийд аялал жуулчлалаар тэргүүлэгч “Amadeus” компанитай хамтарч ажиллах санамж бичиг байгуулсан байна. Түүнчлэн Airbnb болон What3words компанитай мөн хамтын ажиллагаагаа эхлүүлээд байгаа бөгөөд Airbnb платформ болон what3words буюу 3 үгт хаягжилтийн байршил тодорхойлох технологийг нэгтгэн хаяг нь тодорхойгүй эсвэл улирлаас хамааран нүүдэллэж байдаг нүүдэлчдийг аялал, жуулчлалын салбарт оролцуулах боломж бүрдүүлж байгаа юм байна. Энэхүү технологийг гар утсан дээрээ суулган үнэгүй ашиглах боломжтой байдаг ба хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж буй үйлчилгээ, аялал жуулчлалын байгууллагуудад томоохон дэмжлэг болно.

Орон нутагт жуулчдыг хүлээн авах чадавхийг нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжлийг үр дүнтэй дэмжих, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд зөвхөн нэг аймгийн төлөвлөлт хангалтгүй нь тодорхой билээ. Тухайн бүс нутгийн онцлог, ойролцоох аймаг, сумдын хамтын ажиллагааг хангах бололцоотой бүсчилсэн хөгжлийн төлөвлөгөө зайлшгүй шаардлагатай болоод байна. Төлөвлөгөөг боловсруулахдаа тэргүүлэх чиглэлийг сайтар тодорхойлон, бүс нутгийн хамтарсан нэгдсэн чиг хандлагыг тусгах, хэрэгжүүлэх механизмыг тодорхой тусгах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг тусган үнэлгээг тогтмолжуулах шаардлагатай.

Өнөөг хүртэл тулгамдаж буй асуудлыг тодруулан, бодлого төлөвлөлтөд жигд тусгасаар ирсэн хэдий ч хэрэгжилт хангалтгүй байгаа нь эдгээр асуудалтай холбоотой гэж дүгнэж байна. Түүнчлэн байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын урьдчилан сайтар судлах, БОНБУ-ний хэрэгжүүлэх төлөвлөгөөний хяналт,

мониторинг үнэлгээг тогтмол хугацаанд явуулах ажлыг жуулчдын зорих газрын менежментийн үйл ажиллагаанд тусгах асуудал чухал.

Хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хөрш улсуудын бодлого тааламжтай нөхцөл бий болгож байна. ОХУ-ын Аялал жуулчлалын агентлаг Цайны замуудын дахин сэргэлт тулах цэг бодлого баримталж байгаа. Хөвсгөл болон Байгаль нуурыг холбосон аялал жуулчлалын маршрут хөгжүүлэх, Шинжаан Уйгар хүртэлх Монголын нутгаар дамжуулан автозам барих төсөл, Улаан-Үдээс Эрхүү хүртэл, Ханхаас Эрхүү хүртэл 2 зам солбилцолоос гадна Эрхүүгийн шинэ замын төслийг Цайны замтай уялдуулан хэрэгжүүлж байгаа.

БНХАУ-ын хувьд Эрээн хотод жилд 1 сая гаруй жуулчид ирдэг (1 сая 70 мянга, 2017 оны байдлаар), хилийн худалдаа, хил орчмын аялал жуулчлалд ихээхэн анхаарал хандуулж Манжуурыг аялал жуулчлалын туршилтын бүс болгосон. Сүүлийн жилүүдэд авто машины аялал эрчимтэй хөгжиж байна.

2005 онд манай Зам тээвэр, аялал жуулчлалын яам, Үндэсний аялал жуулчлалын байгууллага жуулчидаа бүлгээр аялуулах санамж бичгийг БНХАУ-тай зурсан. БНХАУ-ын жуулчдыг 2015 оноос Замын-Үүд, Бичигтийн боомтоороо хил орчмын аялал жуулчлалын үнэмлэхээр нэвтрүүлж эхэлсэн. Ингээд тэр жилдээ Замын-Үүд 2014 оноос 2.5 дахин илүү буюу 13914 хятад жуулчин авч байсан байна.

Дээрхээс үзэхэд манай улсад хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой хэдий ч хил орчмын сум суурингууд жуулчид хүлээн авах чадваргүй тул эхний ээлжинд Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Дорноговь аймгийн Замын-Үүд, Сүмбэр суманд хил орчмын аялал жуулчлал хөгжүүлэх туршилтын бүс байгуулах нь зүйтэй гэж үзэж байна. Алтанбулаг болон Замын-Үүд суманд Худалдааны чөлөөт бүсийн төсөлтэй уялдуулан хөгжүүлэх бүрэн боломжтой. Сүмбэр сумын хувьд хил залгадаг Хянган аймгийн Рашаан хотод том аялал жуулчлалын цогцолбор оршдог бөгөөд жилд 3 сая жуулчин хүлээн авдагаас ихэнх нь төлбөрийн чадвартай хятад жуулчид байдаг байна. Үүний тулд хилийн боомтын нэвтрүүлэлтийг сайжруулах, визийн асуудлыг хөнгөвчлөх хэрэгцээтэй. Аялал жуулчлалын бүтээгдэхүүний хувьд хил орчмын аялагчид нүүдэлчин ахуйг сонирхдог оос гадна Монголын мах, махан бүтээгдэхүүн, сүү, зөгийн бал, ноос ноолууран бүтээгдэхүүнийг сонирхдог байна. Эхний ээлжинд Сүмбэр суманд худалдааны төв байгуулан, нутгийн ХАА гаралтай бүтээгдэхүүн болон үндэсний үйлдвэрлэлийн олон төрлийн бараа борлуулах боломжийг нэмэгдүүлэх боломжтой.

3.4 Бодлогын залгамж чанарт хийсэн шинжилгээ

2004 он хүртэл Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байсан Аялал жуулчлалын газар 2004 оноос 2008 он хүртэл Зам тээвэр, аялал жуулчлалын яаманд, 2008 оноос 2012 онд БОАЖЯ, 2012 оноос 2015 он хүртэл Соёл, спорт аялал

жуулчлалын яам, 2015 оноос хойш БОНХАЖЯ, БОАЖЯ-д харъяалагдаж байна. Энэ хугацаанд Засгийн газар удаа 5 өөрчлөгдөн, салбарын харъяалагдах яам 4 удаа солигдсон байна. Мөн энэ хугацаанд Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга 5 удаа солигдон, газрын мэргэжилтэний халаа сэлгээ их явагдсан нь засаглалын залгамж чанар алдагдахад хүрсэн гэж болно. Соёл, спорт, аялал жуулчлалын яам гэсэн бүтэцтэй байхад аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаа идэвхитэй байсантай холбогдуулан энэ бүтэц зөв гэх судлаачид байдаг, түүнчлэн Зам тээвэр, аялал жуулчлалын яамны бүтэц зөв гэх саналтай судлаачид ч байдаг. Үүн дээр Монгол улсын аялал жуулчлал байгаль орчны нөөц тэр дундаа ТХГН-ийн нөөц дээр тулгуурладагаас гадна цаашид тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх тэргүүлэх зорилт тавьсан өнөө үед одоогийн буюу БОАЖЯ-ны харъяалал хамгийн оновчтой гэж үзэж байна.

ДӨРӨВ. САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

4.1 Салбарт тулгамдаж байгаа асуудал, хүндрэл, бэрхшээлийг тодорхойлох, түүнийг шийдвэрлэх арга зам

Аялал жуулчлалын үндэсний хөтөлбөрт салбарын тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааг жигд тусгасан хэдий ч “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” болон одоо хэрэгжиж буй бусад салбарын бодлоготой уялдуулан нэмэлт тодотгол хийх шаардлагатай. Түүнчлэн аялал жуулчлалын салбарын урт болон дунд хугацааны бодлого, төлөвлөлтийг хөрөнгө оруулалтын хөтөлбөр, орон нутгийн хөгжлийн төлөвлөлттэй уялдуулах хэрэгцээ тулгарч байна. Улсын хэмжээнд аялал жуулчлалын талаар баримтлах нэгдсэн хөгжлийн чиг хандлагаа тодорхойлон, нэгдсэн бодлогоор хангах, хүний нөөц бэлдэх ажлыг нэн даруй эхлүүлэх хэрэгтэй байна.

Аялал жуулчлалын салбарын тулгамдаж буй асуудал болон шийдвэрлэх арга замыг доорхийн дагуу нэгтгэн харуулав.

❖ Салбарын бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийн механизм сул байна.

Шийдвэрлэх арга зам

- Бодлого, төлөвлөлтийн хэрэгжилт, хяналтыг хэрэгжүүлэх агентлаг байгуулах шаардлагатай байна. БОАЖЯ-ны Аялал жуулчлалын газар нийт 7 ажилтантай, бодлого төлөвлөлт боловсруулах, салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, төсөл хөтөлбөрийн зохицуулалт хийх үүрэгтэй. Хэрэгжилт, хяналт, оролцогч талуудтай үр дүнтэй хамтын ажиллагаа явуулахад хүний нөөц, хүчин чадал хүрэлцээгүй байгаа. Шинээр байгуулагдсан Аялал жуулчлалын хөгжлийн төвийн чиг үүргийг нэмэгдүүлэн хэрэгжилтийн механизмыг тодорхой, хэрэгжилтийн үнэлгээг тогтмол хийдэг тогтолцоо бий болгох шаардлагатай гэж үзэж байна.
- Салбарын статистик, судалгаа, мэдээллийн платформыг бий болгосноор бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг хянах, засаж сайжруулах бололцоо

нэмэгдэнэ. Мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсоноор төсөл, хөтөлбөрийн давхцал, гүйцэтгэлийн хяналтыг давхар зохицуулах боломжтой. БОАЖЯ сурталчилгаа, маркетингийн нэгдсэн цахим платформ, цахим технологиудыг нэвтрүүлэх ажил эхлүүлээд байгаа нь сайшаалтай бөгөөд уг платформд салбарын холбогдох судалгаа, шинжилгээ, бодлого төлөвлөлтийн мэдээлэл тусгагдвал нэгдсэн цогц мэдээллийн сан бүрэлдэнэ.

- Салбарын төсөв санхүүжилтийг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрөөс гадна байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжил, аж үйлдвэрийн төрөлжилт, экспорт, ЖДҮ-ийг дэмжих сан зэрэг олон талын эх үүсвэрээс оновчтой зохицуулах боломжийг судлах хэрэгтэй.
- Тусгай Хамгаалалттай Газар Нутгийн байгаль хамгаалах үйл ажиллагаа буюу Орчны бүсийн менежментийг сайжруулах ажлыг аялал жуулчлалын төлөвлөлттэй уялдуулах шаардлага байгаа. Үүнд аялал жуулчлалын бүсийн газар зохион байгуулалт, байгаль хамгааллын бодлогыг мөн хамруулна.
- Орон нутгийн захиргаа, ТХГН-ийн захиргаа, тур оператор, хувийн хэвшил, нутгийн иргэд зэрэг оролцогч талуудын хамтын ажиллагааг тодорхойлж, бэхжүүлэх ажлыг нэгдсэн зохион байгуулалттай хэрэгжүүлэх шаардлага бий болж байна. ТХГН-ийн үйл ажиллагааны ерөнхий төлөвлөлтийн дэд хөтөлбөр болон Аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөө боловсруулсан хэд хэдэн газар бий. Тухайлбал, Орхон Хархорин БЦГ, Хөвсгөл нуурын БЦГ, Онон Балжийн ДЦГ, Говь гурван сайханы БЦГ зэрэг газрууд үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

❖ **Салбарын хууль, журам,стандартын хэрэгжилт сул байна.**

Шийдвэрлэх арга зам

- Аялал жуулчлалын тухай хуульд Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын зөвлөмжийн дагуу тодотгол хийх шаардлагатай байна. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль батлагдсанаар салбар хоорондын бодлогын уялдааг тодорхой тусгасан. Ангилал, стандартын шинэчлэл, өнөө үеийн өртгийн сүлжээнд суурилсан цахим мэдээллийн платформ зэрэг шинээр зохицуулалт шаардлагатай асуудлыг тусган, хэрэгжилтийг чангатгах хэрэгцээ үүсч байна.
- Аялал жуулчлалын байгууллагын ангилал, зэрэглэлийн шалгуурыг өндөрсгөхийн хамт ач холбогдол, давуу талыг нэмэгдүүлэх замаар мэргэжлийн бус тоглогчдыг цэгцлэх цаг нь болсон. Салбарын хүний нөөц дутагдалтай, шинээр элсэгчдийн тоо цөөрч байгаагаас салбарын хүний нөөцийн үнэ цэнийг өндөрсгөх үүднээс мэргэжлийн зэрэглэл олгох тогтолцоог нэвтрүүлэх нь зүйтэй. Түүнчлэн аялал жуулчлалын байгууллагын ангиллыг олгохдоо мэргэжлийн үнэмлэхтэй ажилтаны тоог хуулиар тогтоон зааж өгөх боломжтой.

- Хэрэгжилтийн механизм, хяналт, мониторингийн тогтолцоог боловсронгуй болгох хэрэгтэй. Өмнө дурдсанчлан оролцогч талуудын үүрэг хариуцлагыг тодорхой тусган, хяналт мониторингийг чангатгах нь зүйтэй.
- Байгаль болон хүрээлэн буй орчны үзэмж төрхийг хадгалах тухай хууль боловсруулан, батлуулах шаардлагатай байна. Ялангуяа ТХГН-ийн үзэсгэлэнт байгальд зохисгүй барилга байгууламж барьж, үзэмж төрхийг алдагдуулж байгаа нь Үзэмж төрхийг хамгаалах тухай ойлголт дутмаг, хууль журмаар зохицуулахаас өөр аргагүй. Жуулчдын зорих газрууд өөрийн нутгийн онцлог, төрхөд тохирсон журам боловсруулах замаар орчны үзэмжийг хамгаалах боломжтой.
- Стандартыг шинэчлэн боловсруулах шаардлагатай (зочид буудал болон жуулчны баазуудад ISO бенчмаркинг хийх тухайлбал, ISO10001 хэрэглэгчийн сэтгэл ханамж)
- Дотоодын аялагчдад чиглэсэн журам гаргах шаардлагатай. Автозамын бүтээн байгуулалт эрчимтэй явагдсанаар дотоодын авто машинаар аялагчдын тоо нэмэгдэхийн зэрэгцээ зорчих газрын хог хаягдал, дуу чимээний асуудал хурцдаж байгаа.

❖ **Аялал жуулчлал эрхлэгчдэд бодлогын дэмжлэг дутагдалтай.**

Шийдвэрлэх арга зам

- Аялал жуулчлалын салбар тогтвортой хөгжлийн тэргүүлэх салбар болохын тулд Экспортыг дэмжих, ЖДҮ-ийг дэмжих хөтөлбөр зэрэгт хамруулан татварын хөнгөлөлт, хөнгөлөлттэй зээлд хамруулах гм нэгдсэн бодлого, дэмжлэгийг нэмэгдүүлэх нь зүйтэй.
- Төр хувийн хэвшлийн түншлэлийн механизм бүрдүүлэх, Ерөнхий сайдын дэргэдэх Аялал жуулчлалын зөвлөлийг идэвхижүүлэх замаар холбогдох салбарын хөгжлийн бодлогыг уялдуулах, салбараас орох орлогыг салбарын хөгжилд оруулах тогтолцоог бий болгох тогтолцоо үгүйлэгдэж байна.
- Аялал жуулчлалын байгууллагууд хэт олширч, бүтээгдэхүүнийг үнэгүйдүүлэх, үйлчилгээний чанарт нөлөөлж буй тул ангиллын шалгуурыг өндөрсгөн, ангилалд тохирсон дэмжлэгийн тогтолцоо бүрдүүлэх боломжтой.
- Хүний нөөцийн бодлого боловсруулах, мэргэжлийн зэрэг, үнэмлэх олгох тогтолцоог бий болгох хэрэгцээ байгаагаас гадна үүнийг аялал жуулчлалын байгууллагын ангилал тогтоох журамтай уялдуулах хэрэгцээтэй гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, аялал жуулчлалын байгууллагын ангилалаас хамааран мэргэжлийн үнэмлэх, зэрэгтэй хүний тоог хуульчлан зааж өгснөөр мэргэжлийн тоглогчдыг зах зээлээс гаргах боломжтой болно.

❖ **Салбарын үйлчилгээний чанар, маркетинг хангалтгүй байна.**

Шийдвэрлэх арга зам :

- Хүний нөөцийг чадавхижуулах урт, дунд хугацааны төлөвлөлт боловсруулан, үе шаттайгаар хэрэгжүүлэх, мэргэжлийн үнэмлэх, зэрэглэлийн тогтолцоо нэвтрүүлэх
- Мэдээллийн платформд түшиглэн, жуулчдад цахимаар болон ухаалаг утасны аппликейшн ашиглан мэдээлэл хүргэх (такси дуудлага, музей болон үзвэр, үйлчилгээний зар, тайлбарыг гадаадын олон хэлээр түгээх)
- Зах зээлийн судалгаанд тулгуурласан, маркетингийн бодлого хэрэгтэй. Зорилтот зах зээлд чиглэсэн оновчтой сурталчилгааг тогтмол явуулах (CNN, National geographic)
- Бусад салбартай хамтарсан олон улсын арга хэмжээг тогтмол зохион байгуулж хэвших (MICE) боломж өндөр байна. Жишээлбэл, жил бүр Хонгконг хотод “Cashmere world” арга хэмжээ зохион байгуулагддаг. Монголын дизайнеруудын холбоо, Ноолуурын холбоо, ноолуурын үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжийн дэмжлэгтэй жил бүр ноолуурын шилдэг загвар шалгаруулах олон улсын тэмцээнийг экспо үзэсгэлэнтэй уялдуулан зохион байгуулах боломжтой (эсвэл, арьс ширний үйлдвэрлэгчдийн экспо байж болно).

❖ **Бодлогын уялдаа, хамтын ажиллагаа сул байна.**

Шийдвэрлэх арга зам :

- Агаарын тээврийг либералчлах, үнийн уян хатан бодлого баримтлах, өрсөлдөөнийг бий болгох, нислэгийн давтамжийг нэмэгдүүлэх, төмөр замын зорчигч тээвэрлэлт өргөтгөх, аялал жуулчлалын бүтээгдэхүүнтэй хослуулах
- Экосистемийн менежментийг сайжруулах (уул уурхай, ой мод, МАА, усны бохирдол, хог хаягдал)
- Жуулчдын аюулгүй байдлыг хангах цогц хөтөлбөр, төлөвлөлт боловсруулан мөрдүүлэх шаардлагатай байна.
- Газар зохион байгуулалт, ашиглалтыг стратегийн дагуу үе шаттай явуулах, бүсчлэл, бүсийн дүрэм журмыг чанд мөрдөх
- Зам дагуух байгууламжийг жуулчдын мэдээллийн төв, орон нутгийн хөгжилтэй уялдуулан хөгжүүлэх, тэргүүлэх байршил чиглэлийг тодорхойлох гм.

4.2 Салбарын хөгжлийн PESTLE, SWOT шинжилгээ

Салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудалд тулгуурлан PESTLE шинжилгээ хийн салбарын макро орчны хүчин зүйлийг тодорхойлсноос гадна SWOT шинжилгээг бүс тус бүрээр болон нийтэд нь дараах байдлаар гүйцэтгэлээ.

Хүснэгт 4.2.1 Аялал жуулчлалын салбарын PESTLE шинжилгээ

Political	<ul style="list-style-type: none"> · Тогтвортой хөгжлийн бодлого · Засаглалын тогтворгүй байдал · Татварын бодлого · Улс төрийн нөлөө
Economic	<ul style="list-style-type: none"> · Эдийн засгийн хямрал · Инфляци · Бизнесийн орчин · Мэргэжлийн бус тоглогч
Social/Cultural	<ul style="list-style-type: none"> · Ажилгүйдлийн түвшин · Жуулчдын аюулгүй байдал · Соёлын өвийн эрсдэл
Technological	<ul style="list-style-type: none"> · Мэдээллийн технологи · Сошиал медиа
Legal	<ul style="list-style-type: none"> · Хууль эрх зүйн орчин · Мөрдөгдөж буй стандартууд
Environment	<ul style="list-style-type: none"> · Экологийн доройтол · Байгальд ээлтэй үйлдвэрлэл · Экологийн боловсрол

Хүснэгт 4.2.2 Баруун бүсийн аялал жуулчлалын SWOT шинжилгээ

ДАВУУ ТАЛ / STRENGTHS	СУЛ ТАЛ / WEAKNESSES
<ul style="list-style-type: none"> · Байгалийн үзэсгэлэнт газар ихтэй · Түүх соёлын нөөц ихтэй · ТХГН ихтэй · ЮНЕСКО-ийн дэлхийн соёлын өв · Олон угсаатны соёлын өв · Ховор амьтан, ургамлын нөөц 	<ul style="list-style-type: none"> · Аялал жуулчлалын дэд бүтэц муу · Үйлчилгээний байгууллага цөөн · Хүний нөөц хангалтгүй · Олон улсын онгоцны буудалгүй · Дотоодын нислэгийн үнэ өндөр
БОЛОМЖ / OPPORTUNITIES	АЮУЛ / THREATS
<ul style="list-style-type: none"> · Хоёр хөрштэй хиллэдэг · Авто замын бүтээн байгуулалт · Тусгай сонирхлын аялал хөгжүүлэх боломж өндөр · Төв Азийн нүүдэлчдийн соёлын төв болох боломжтой · Дотоодын аялагчид өсөлттэй · Худалдааны чөлөөт бүсийн төлөвлөлт 	<ul style="list-style-type: none"> · Өрсөлдөгч зах зээл ихтэй · Стандартын дэд бүтэц муугаас байгаль экологид сөрөг нөлөөтэй · Төлөвлөлтгүй байршуулах хэрэгсэл өсөх магадлалтай

Хүснэгт 4.2.3 Төвийн бүсийн аялал жуулчлалын SWOT шинжилгээ

ДАВУУ ТАЛ STRENGTHS	СУЛ ТАЛ WEAKNESSES
<ul style="list-style-type: none"> · Байгалийн үзэсгэлэнт газар ихтэй · Түүх соёлын нөөц ихтэй · Дэд бүтэц харьцангуй сайн · Харилцаа холбоо сайн · Сүм хийд олонтой · Ховор ургамал амьтаны нөөц · Палентологийн олдвор ихтэй 	<ul style="list-style-type: none"> · Аялал жуулчлалын дэд бүтэц муу · Стандартын үйлчилгээний байгууллага цөөн · Хүний нөөц хангалтгүй
БОЛОМЖ OPPORTUNITIES	АЮУЛ THREATS
<ul style="list-style-type: none"> · Авто замын бүтээн байгуулалт · Буддын шашны төв хөгжүүлэх боломж өндөр · Нүүдэлчин угсаатны төв болох · Дотоодын аялагчид өсөлттэй · Хил орчмын болон хил дамнасан аялал хөгжүүлэх боломжтой 	<ul style="list-style-type: none"> · Өрсөлдөгч зах зээл ихтэй · Стандартын дэд бүтэц муугаас байгаль экологид сөрөг нөлөөтэй · Төлөвлөлтгүй байршуулах хэрэгсэл өсөх магадлалтай · Соёлын өвийн эрсдэл

Хүснэгт 4.2.4 Хангайн бүсийн аялал жуулчлалын SWOT шинжилгээ

ДАВУУ ТАЛ / STRENGTHS	СУЛ ТАЛ / WEAKNESSES
<ul style="list-style-type: none"> · Байгалийн үзэсгэлэнт газар ихтэй · Түүх соёлын нөөц ихтэй · Рашаан сувилал олонтой · Тусгай хамгаалалтын газар ихтэй · Байгалийн сонин тогтоц ихтэй 	<ul style="list-style-type: none"> · Аялал жуулчлалын дэд бүтэц муу · Стандартын үйлчилгээний байгууллага цөөн · Хүний нөөц хангалтгүй ·
БОЛОМЖ / OPPORTUNITIES	АЮУЛ / THREATS
<ul style="list-style-type: none"> · Авто замын бүтээн байгуулалт · Тусгай сонирхлын аялал хөгжүүлэх боломж өндөр · Эртний хотын туурь дээр аялал жуулчлалын төв байгуулах боломжтой · Дотоодын аялагчид өсөлттэй · Эдийн засгийн корридор дагуу байрладаг 	<ul style="list-style-type: none"> · Соёлын өвийн эрсдэл · Стандартын дэд бүтэц муугаас байгаль экологид сөрөг нөлөөтэй · Нутгийн иргэдийн эсэргүүцэл тулгарах магадлалтай · Орон нутгийн эдийн засагт оруулах хувь хэмжээ бага

Хүснэгт 4.2.5 Улаанбаатарын бүсийн аялал жуулчлалын SWOT шинжилгээ

ДАВУУ ТАЛ STRENGTHS	СУЛ ТАЛ WEAKNESSES
<ul style="list-style-type: none"> · Үзвэр үйлчилгээ ихтэй 	<ul style="list-style-type: none"> · Байгаль экологийн доройтол

<ul style="list-style-type: none"> · Аялал жуулчлалын дэд бүтэц сайн · Олон улсын сүлжээний зочид буудал · Үйлчилгээний байгууллага ихтэй 	<ul style="list-style-type: none"> · Автозамын түгжрэл · Хотжилтоос үүдсэн хүрээлэн буй орчны асуудал · Соёлын өвийн доройтол · Түүхэн барилга байгууламж, музейн доройтол
БОЛОМЖ OPPORTUNIES	АЮУЛ THREATS
<ul style="list-style-type: none"> · Шинэ нисэх буудлын бүтээн байгуулалт · MICE, Бизнес аялал хөгжүүлэх боломж өндөр · Нүүдэлчдийн соёлын төв болох боломжтой 	<ul style="list-style-type: none"> · Хотжилтоос үүдсэн хүрээлэн буй орчны асуудал · Соёлын өвийн эрсдэл · Стандартын дэд бүтэц муугаас байгаль экологид сөрөг нөлөөтэй · Хотжилтоос үүдэх орчны бохирдол

Хүснэгт 4.2.6 Зүүн бүсийн аялал жуулчлалын SWOT шинжилгээ

ДАВУУ ТАЛ STRENGTHS	СУЛ ТАЛ WEAKNESSES
<ul style="list-style-type: none"> · Байгалийн үзэсгэлэнт газар ихтэй · Түүх соёлын нөөц ихтэй · Хүннүгийн үеийн архелогийн олдвор · Чингис хааны өлгий нутаг · Халхын голын дурсгалт газрууд · Буриад соёлын зан заншил 	<ul style="list-style-type: none"> · Аялал жуулчлалын дэд бүтэц муу · Үйлчилгээний байгууллага цөөн · Хүний нөөц хангалтгүй · Жуулчдын эрүүл ахуй, аюулгүй байдал · Нийгмийн дэд бүтэц ·
БОЛОМЖ / OPPORTUNIES	АЮУЛ /THREATS
<ul style="list-style-type: none"> · Олон улсын онгоцны буудал · Авто замын бүтээн байгуулалт · Тусгай сонирхлын аялал хөгжүүлэх боломж өндөр · Дотоодын аялагчид өсөлттэй · Хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлал хөгжих боломжтой 	<ul style="list-style-type: none"> · Байгалийн үзэмжид сөрөг нөлөөлөл · Соёлын өвийн эрсдэл · Стандартын дэд бүтэц муугаас байгаль экологид сөрөг нөлөөтэй · Хог хаягдлын асуудал · Нутгийн иргэдийн эсэргүүцэл тулгарах магадлалтай · Орон нутгийн эдийн засагт оруулах хувь хэмжээ бага

Хүснэгт. 4.2.7 Баруун бүсийн аялал жуулчлалын SWOT шинжилгээ

ДАВУУ ТАЛ STRENGTHS	СУЛ ТАЛ WEAKNESSES
<ul style="list-style-type: none"> · Байгалийн үзэсгэлэнт газар ихтэй · Түүх соёлын нөөц ихтэй 	<ul style="list-style-type: none"> · Аялал жуулчлалын дэд бүтэц муу · Үйлчилгээний байгууллага цөөн

<ul style="list-style-type: none"> · Тусгай хамгаалалтын газар ихтэй · Олон угсаатны өлгий нутаг · Хоёр хөрштэй хиллэдэг · Ховор амьтан ургамал · Байгалийн олон төрлийн бүс бүслүүр 	<ul style="list-style-type: none"> · Хүний нөөц хангалтгүй · Жуулчдын аюулгүй байдал · Тээврийн зардал өндөр ·
БОЛОМЖ OPPORTUNIES	АЮУЛ THREATS
<ul style="list-style-type: none"> · Байгалийн нөөц ихтэй · Авто замын бүтээн байгуулалт · Олон угсаатны соёлын төв болгон хөгжүүлэх · Дотоодын аялагчид өсөлттэй · Худалдааны чөлөөт бүсийн төлөвлөлт · Хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлал хөгжих боломжтой · Бизнес аялал хөгжүүлэх боломжтой 	<ul style="list-style-type: none"> · Соёлын өвийн эрсдэл · Стандартын дэд бүтэц муугаас байгаль экологид сөрөг нөлөөтэй · Нутгийн иргэдийн эсэргүүцэл тулгарах магадлалтай · Орон нутгийн эдийн засагт оруулах хувь хэмжээ бага

Хүснэгт. 4.2.8 Говийн бүсийн аялал жуулчлалын SWOT шинжилгээ

ДАВУУ ТАЛ STRENGTHS	СУЛ ТАЛ WEAKNESSES
<ul style="list-style-type: none"> · Байгалийн үзэсгэлэнт газар ихтэй · Түүх соёлын нөөц ихтэй · Тусгай хамгаалалтын газар ихтэй · Дэлхийд танигдсан байгалийн бүс · Урд хөрштэй хиллэдэг · 	<ul style="list-style-type: none"> · Аялал жуулчлалын дэд бүтэц муу · Үйлчилгээний байгууллага цөөн · Хүний нөөц хангалтгүй · Жуулчдын аюулгүй байдал · Тээврийн зардал өндөр ·
БОЛОМЖ / OPPORTUNIES	АЮУЛ /THREATS
<ul style="list-style-type: none"> · Байгалийн нөөц ихтэй · Авто замын бүтээн байгуулалт · Тусгай сонирхлын аялал хөгжүүлэх боломж өндөр · Худалдааны чөлөөт бүсийн төлөвлөлт · Хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлал хөгжих боломжтой 	<ul style="list-style-type: none"> · Соёлын өвийн эрсдэл · Стандартын дэд бүтэц муугаас байгаль экологид сөрөг нөлөөтэй · Нутгийн иргэдийн эсэргүүцэл тулгарах магадлалтай · Орон нутгийн эдийн засагт оруулах хувь хэмжээ бага

4.3 Дүгнэлт, санал зөвлөмж

Дэлхий нийтэд аялал жуулчлалын салбар тогтвортой өсөн, аялал жуулчлалын бүтээгдэхүүн 4 хувиар өсч, 2030 он гэхэд жуулчдын тоо 1.8 тэрбумд хүрэх ба Зүүн хойд Ази хамгийн жуулчид аялдаг бүс болох төлөвтэй байна. Дэлхийн аялал жуулчлалын холбооны / WTTC / шинжээчид ойрын 10 жилд аялагч жуулчдын хөлд дарагдах орнуудыг нэрлэхэд эхний тав дотор Монгол Улсыг оруулжээ. Ингэснээр Монгол Улсын ДНБ-д аялал жуулчлалаас орох хувь хэмжээ 6,3 хувьд хүрнэ гэж тооцоолсон байна.

Даяаршлын нөхцөлд дэлхийн улсууд, түүний дотор хоёр хөрш орон болох ОХУ, БНХАУ-ын геополитик, геоэдийн засгийн чиг хандлага мэдэгдэхүйц өөрчлөгдөж, ОХУ нь Зүүн хойд Ази, Номхон далайн орнуудтай хамтын ажиллагаагаа идэвхжүүлэхийг зорих боллоо. БНХАУ нь Ази, Европыг холбож байсан торгоны замын худалдаа, эдийн засгийн харилцааг үндэслэн “Нэг бүс - Нэг зам” санаачлагыг дэвшүүлж, энэ чиглэлд татагдаж байсан бүх орон, түүний дотор Хятад-Монгол-Орос гурван улсын хооронд эдийн засгийн корридор байгуулах хөтөлбөрийг батламжилж, хэрэгжүүлэхээр тохиролцоод байна. Олон улсын энэхүү чиг хандлагыг харгалзан Монгол улсад аялал жуулчлалыг нэгдсэн бодлого, зорилттой уялдуулан хөгжүүлэх хэрэгцээ урган гараад байгаа билээ.

Засгийн газраас 2016 онд батлагдсан “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-д аялал жуулчлалыг тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх, нүүдэлчин соёл, аялал жуулчлалын олон улсын төв болох зорилго тавигдсан байгаа. Манай орны хувьд байгаль экологийн эмзэг системтэй тул Олон улсын байгаль хамгаалах холбоо (ОУБХХ)-оос зөвлөмж болгож буй тогтвортой аялал жуулчлалын үндсэн зарчмыг баримтлах нь зүйтэй. Энэхүү зарчим нь эко аялал жуулчлалыг дэмжин байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх аялал жуулчлалын эерэг нөлөөг нэмэгдүүлэхийг зорьдог бөгөөд эдгээрийн тэнцвэрт байдлаар тодорхойлогддог.

Уг зарчим дээр суурилсан **нэгдсэн бодлого, төлөвлөлт** боловсруулахын зэрэгцээ аймаг тус бүрийн аялал жуулчлалын ерөнхий төлөвлөгөөг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан, тухайн бүс болон аялал жуулчлалын кластераар хөгжүүлэх бодит оновчтой төлөвлөлтийг санал дэвшүүлэх шаардлагатай байна.

Нэгдсэн бодлого, төлөвлөлтөд ядуурлыг бууруулах, орон нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх асуудлыг төлөвлөлтөд тодорхой тусган, оролцогч талуудын хамтын ажиллагааг жигд хангах хэрэгжилтийн механизм бүрдүүлэх шаардлагатай.

Мөн шинээр **Хүрээлэн буй орчны үзэмж төрхийг хамгаалах тухай хууль** боловсруулан, батлуулах шаардлага өндөр байна. Ингэснээр байгалийн үзэсгэлэнт газар буюу жуулчдын зорих газрын үзэмж төрхийг хадгалах, тухайн бүс нутгийн онцлогт тохирсон бүтээн байгуулалт хийх боломж бүрдэнэ. Түүнчлэн бүс нутаг хоорондын ялгарал, бренд бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд эерэгээр нөлөөлнө.

Эдгээртэй уялдуулан нийт орон нутгийн иргэд болон жуулчдад байгаль орчны боловсрол олгох, мэдлэгийг дээшлүүлэх улс орон даяар компани ажлыг зохион байгуулан, оролцогч талуудыг нэгдсэн ойлголттой болгох нь зүйтэй.

Мөн цаашдын салбарын урт болон дунд хугацааны төлөвлөлтөд **олон улсын чиг хандлага** тэр дундаа хөрш зэргэлдээ орнуудын хандлага, хамтын ажиллагааг тусган уялдуулах шаардлага урган гарч байна. Үүнд юуны түрүүнд зорилтот зах зээлийн судалгаа хийх хил орчмын, хил дамнасан аялал жуулчлалын туршилтын бүсийг нэн даруй байгуулах хэрэгтэй. Үүнтэй холбогдуулан хил орчмын сумдын жуулчид хүлээн авах чадавхийг тодорхойлон, эрэлтэд суурилсан нийлүүлэлт буюу

жуулчид хүлээн авах зочид буудал, жуулчны бааз, бараа үйлчилгээг тухайн орон нутгийн онцлогийг тусган бусад салбарын хөгжилтэй уялдуулан хөгжүүлэх шаардлагатай. Эхний ээлжинд Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Дорноговь аймгийн Замын-Үүд, Сүмбэр суманд хил орчмын аялал жуулчлал хөгжүүлэх туршилтын бүс байгуулах нь зүйтэй.

Хүний нөөцийн дутагдал нийт салбарын хэмжээнд тулгамдсан асуудал хэвээр байгаа. Их дээд сургууль төдийгүй МСҮТ дээр мэргэжлийн ажилтанг чанартай бэлдэхээс гадна салбарын нэр хүнд, мэргэжлийн хөтөч, зочлохуйн ухааны үнэ цэнийг нийтэд таниулах, өсгөх хэрэгцээтэй байна. Хамгийн гол нь салбарын мэргэжилтэнг тогтвор суурьшилтай ажиллуулахын тулд мэргэжлийн зэрэглэл, үнэмлэх олгох тогтолцоог шинээр нэвтрүүлэх шаардлагатай байна. Энэхүү тогтолцоо нь ангилал олгох тогтолцоотой шууд уялдсан байхаар зохицуулалт хийх нь чухал. Өөрөөр хэлбэл, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж ангиллын гэрчилгээ авахдаа мэргэжлийн зэрэглэлтэй хэдэн ажилтантай, мэргэжлийн үнэмлэхтэй хэдэн ажилтантай байх зэргийг тодорхой журмаар зохицуулахаас гадна зэрэглэл чадварт тохирсон цалин, урамшууллын зэрэг дагалдах асуудлуудад хуулийн зохицуулалт хийх хэрэгцээ үүсэх болов уу.

Засаглалын тогтвортой байдал өнөөг хүртэл үгүйлэгдэж ирсэн нь бодлого төлөвлөлтийн залгамж байдалд нөлөөлж ирсэн. 2015 онд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, 2016 онд Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 тус тус батлагдсанаар бодлого төлөвлөлтийг урт болон дунд хугацаагаар төлөвлөн, аливаа Засгийн газар, улс төрийн намын нөлөөнд авталгүй төлөвлөлтийн дагуу хэрэгжүүлэх боломж бүрдээд байгаа. Түүнчлэн дээрх хууль болон дагалдах журам, урт хугацааны бодлого батлагдсанаар аливаа бодлого төлөвлөлт болон улсын хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, хөтөлбөрийн хууль эрх зүйн үндэслэл, техник эдийн засгийн тооцооллоос гадна бусад бодлого төлөвлөлт, салбарын уялдааг хангасан эсэх, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгдсэн эсэхийг нарийн харгалзан тусгах эрх зүйн үндэслэл баталгаажсан.

Аялал жуулчлалын тухай хуульд Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын зөвлөмжийн дагуу тодотгол хийх шаардлагатай байна. Ангилал, стандартын шинэчлэл, өнөө үеийн өртгийн сүлжээнд суурилсан цахим мэдээллийн платформ зэрэг шинээр зохицуулалт шаардлагатай асуудлыг тусган, хэрэгжилтийг чангатгах хэрэгцээ үүсч байна.

Эдгээртэй уялдуулан аялал жуулчлалын салбарын урт хугацааны бодлого болох **Аялал жуулчлалын үндэсний хөтөлбөрийг** шинэчлэн тодотгох хугацаа нь болсон гэж дүгнэж байна. Салбар хоорондын хамтын ажиллагаа, уялдааг тусган, хэрэгжилтийн механизмыг тодорхойлох нь зүйтэй.

ТАВ. ХӨГЖИЛ, БАЙРШЛЫН ОРОН ЗАЙН АНАЛИЗ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗУРАГЛАЛ

5.1. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, журам, тогтоол, эрх зүйн акт болон бодлогын баримт бичгүүдэд туссан байршилтай төсөл арга хэмжээнүүдийн байршлын газрын зураг


Аялал жуулчлалын салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, журам, тогтоол, эрх зүйн акт болон бодлогын баримт бичгүүдэд тодорхой байршил тусгагдсан төслийн байршлыг Зураг 5.1.1 харуулав.

Засгийн газрын 2016- 2020 үйл ажиллагааны хөтөлбөрт Хэнтий аймагт "Бурхан Халдун" аялал жуулчлалын цогцолбор, Архангай аймагт "Хорго-Тэрх" аялал жуулчлалын цогцолбор, Завхан аймагт "Отгонтэнгэр" аялал жуулчлалын цогцолбор, Ховд аймагт "Хар-Ус" аялал жуулчлалын цогцолбор, Хөвсгөл аймагт "Хөвсгөл" аялал жуулчлалын цогцолбор, Өвөрхангай аймагт "Хархорин" аялал жуулчлалын цогцолбор тус тус тусгагдсан байна. Тус хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх Хөгжлийн зам хөтөлбөрт Хэнтий аймагт "Мянганы суут хүн Их Эзэн Чингис хаан түүхэн аялал жуулчлалын үндэсний парк", Төв аймагт "Монголын эзэнт гүрэн аялал жуулчлал, музей, судалгаа, сурталчилгааны цогцолбор", Өвөрхангай аймагт "Дэлхийн өв Орхоны хөндийн аялал жуулчлалын үндэсний парк" байгуулах, Архангай аймагт "Өгий нуурын экосистемийн тэнцвэрийг хадгалах, хамгаалах, аялал жуулчлалын цогцолбор" байгуулах, Хөвсгөл аймагт "Байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын цогцолбор" байгуулах, Улаанбаатар хотод "Буянт-Ухаа аялал жуулчлалын цогцолбор" байгуулах төслүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан байна.



**БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУССАН ТӨСӨЛ
АРГА ХЭМЖЭЭНИЙ БАЙРШИЛ**

МАСШТАБ 1:6 000 000




★ Төсөл, арга хэмжээ
— Аялал жуулчлалын үндсэн чиглэл

Зураг 5.1.1 Бодлогын бичиг баримтад тусгагдсан төслийн байршил

Эдгээрээс гадна Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан салбарын төслүүдийг дараах хүснэгтэд нэгтгэн харуулав.


№	Төслийн нэр	Санхүүжилтийн хугацаа (оноор)	Төсөвт өртөг (сая төг)	Гүйцэтгэл (сая төг)	2018-2021 (сая төг)	Санхүүжилтийн хуваарь				Шилжих (сая төг)	Санхүүжилтийн эх үүсвэр	Төслийн үндэслэл (Тайлбар)
						2018 (сая төг)	2019 (сая төг)	2020 (сая төг)	2021 (сая төг)			
0	1	2	3	4	5=6+7+8+9	6	7	8	9	10=3-4-5	11	12
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд												
47	Тогтвортой аялал жуулчлалыг дэмжих төсөл	2019-2021	95,000.0	-	95,000.0	87.6	15,000.0	40,000.0	39,912.4	-	Гадаад зээл, тусламж (АХБ-ны хөнгөлөлт тэй зээл)	Өрийн удирдлагын тухай хуулийн 18.5.3 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйл, ЗГҮАХХАТ-4.4.1, МУТХҮБ-2.1.2, Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний
48	Аялал жуулчлалын голлох чиглэлийн авто зам дагуу түр буудаллах, үйлчилгээний цогцолбор	2018-2020	53,000.0	-	53,000.0	13,400.0	26,400.0	13,200.0	-	-	Хувийн хэвшил	Өрийн удирдлагын тухай хуулийн 18.5.3 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйл, ЗГҮАХХАТ-4.4.1, МУТХҮБ-2.1.2, Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 2.1, ГТХБ-3.3.2
49	Аялал жуулчлалын "Ногоон морь" төсөл	2018-2021	30,000.0	-	30,000.0	500.0	7,500.0	7,500.0	14,500.0	-	Хувийн хэвшил	Өрийн удирдлагын тухай хуулийн 18.5.3 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйл, ЗГҮАХХАТ-4.4.1, МУТХҮБ-2.1.2, Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 2.1, ГТХБ-3.3.2
Дүн			178,000.0	-	178,000.0	13,987.6	48,900.0	60,700.0	54,412.4	-		



Зураг 5.2.1 Байгалийн болон эко аялал жуулчлалын нөөц

Нийт нутгийн байгаль орчны тохиромжтой байдлын зураглалыг байгалийн бүс бүслүүр, цаг уурын онцлог зэрэг дээр аялал жуулчлал хөгжүүлэхэд зайлшгүй хэрэгцээтэй байгалийн үзэсгэлэнт газар, түүх соёлын өв, рашаан сувилал, амьтан ургамлын аймгийн тархал, аялал жуулчлалын дэд бүтэц зэрэг гадна дотны хэрэгжиж буй төслийн байршил зэрэг шалгуур үзүүлэлтээр аялал жуулчлалын хөгжлийн тохиромжтой байдлыг бүс нутгаар тодорхойлон харуулав.

5.3. Тухайн салбарын хөгжил байршлын нийлүүлэлтийн сүлжээний зураглал (Газрын зургийг заавал ArcGIS программ дээр боловсруулсан байна. Газрын зургийн SHP file-ыг Үндэсний хөгжлийн газарт хүлээлгэн өгнө.)



Эх сурвалж: Соёлын өвийн төв


Зураг 5.3.1 Түүх соёлын өвийн нөөцийн эрсдлийн зураг

Соёлын өвийн төвөөс түүх соёлын өвийн нөөцийн эрсдлийг тооцон давхарлан жинлэх аргаар орон зайн зураглалыг боловсруулсан. Нийт шалгуураар эрсдлийг тооцсон эдгээр үзүүлэлтэд аялал жуулчлалын салбарын үзүүлэлт ороогүй байсан. Энэхүү судалгаагаар дээрх зураглалд аялал жуулчлалын салбарын байршуулах хэрэгсэл, аялал жуулчлалын чиглэл зэргийг оруулан давхарлан зураглаж харуулав.

Соёлын өвийн төвтэй хийсэн уулзалтаас 1)Соёлын биет болон биет бус өвийн газарзүйн мэдээллийн сан хэрэгцээтэй, 2)Одоогийн засаг захиргааны нэгжийн ангилал (21 аймаг, 333 сум) соёлын өвийн хамгаалалтад зохимжгүй, 3) Соёлын өвийн бодит үнэлгээ хийх аргачлал байхгүй гэсэн асуудал дэвшүүлсэн.

Хөгжлийн төслийн аливаа шийдвэр гаргалтад соёлын өвийн эрсдэлийг сайтар харгалзаж үзэхгүй байгаа нь БОНБУ сул байгаатай холбоотой.


Аялал жуулчлал соёлын өвийг эрсдэлд оруулах магадлалтай хэдий ч зөв менежмент нэвтрүүлвэл олон нийт, жуулчдад соёлын өвийн эрсдлийн асуудлыг ил дэлгэн харуулж, хяналт мониторингийг сайжруулах, аялал жуулчлалаас олох орлогыг хамгаалалтад зарцуулах зэрэг эерэг нөлөөтэй. Соёлын аялал жуулчлал хөгжүүлж хойч үедээ бүрэн бүтэн хүлээлгэн өгөх хэрэгцээ, шаардлагыг таниулах боломжтой.



Зураг 5.3.2 Соёлын өвийн эрсдэлд аялал жуулчлалын нөлөөлөх байдал

ТӨРӨЛ	БАЙГАЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ						ТҮҮХ СОЁЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ								ХИЛ ДАГУУХ, ХИЛ ДАМНАСАН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ					ТУСТАЙ СОНИРХЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ						ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ		
	I	II	III	IV	V	VI	I	II	III	IV	V	VI	VII	VIII	I	II	III	IV	V	I	II	III	IV	V	VI	I	II	III
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ТХТН, Байгалийн үзэсгэлэнт газар	Жуулчны зорих газар	Дэд бүтэц, байгууламж	Биологийн төрөл зүйл	Иргэд, орон нутгийн оршин суугчдын арга хэмжээ	Соёлын арга хэмжээ	Соёлын өв	Музей	Түүх	Палеонтолог	Соёлын арга хэмжээ	Дэд бүтэц, байгууламж	Иргэд, орон нутгийн оршин суугчдын зорих газар	Халивны боомт	Хорио орнууд бүс нутгийн бодлого	Дэд бүтэц, байгууламж	Иргэд, орон нутгийн оршин суугчдын зорих газар	Морин аялал	Янгал аялал	Ховор амьтан	Ууныг амрах	Эрхлэхий барих	Од харах аялал	ТХТН, Байгалийн үзэсгэлэнт газар	Эко аялал	Биологийн төрөл зүйл		
Дэлхийн өв, рамсарын гэрээ																												
ДНЦ, БНЦ, БНН, Дүрсэлт газар																												
Соёлын биет, биет бус өв																												
Сүм, хийд, музей																												
Түүх, археолог																												
Рамаан, сувилал																												
Онгооны буудал																												
Авто зам, төмөр зам																												
Зам дагуух байгууламж																												
Зочид буудал, жуулчны бааз																												
Амьтан, ургамал																												
Нутгийн иргэд, будгэм, хоршоо																												
Нутгийн бренд бүтээгдэхүүн																												
Элчлэг арга хэмжээ																												
Үндэсний баяр, наадам																												
Олон улсын арга хэмжээ																												
Халивны боомт																												
Эртний хотын түүрх, хувьчлал, бүтэц																												
Хорио орнууд бүс нутгийн интеграци																												
Байгаль хамгаалах үйл ажиллагаа																												

Зураг 5.3.3 Аялал жуулчлалын байршлын төлөвлөлт



Зураг 5.3.4 Аялал жуулчлалын нягтшиллын зураг

5.4. Салбарын хөгжил байршлын нэмүү өртгийн сүлжээний болон орц, гарцын зураглал(Газрын зургийг заавал ArcGIS программ дээр боловсруулсан байна. Газрын зургийн SHP file-ыг Үндэсний хөгжлийн газарт хүлээлгэн өгнө.)




Зураг 5.4.1 Уламжлалт өртгийн сүлжээ




Зураг 5.4.2 Цахим орчны хөгжил нэмүү өртгийн сүлжээнд нөлөөлөх

Нэмүү өртгийн сүлжээний огтлолцол



Зураг 5.4.3 Нэмүү өртгийн сүлжээний огтлолцлын зураг



Зураг 5.4.2 Хөдөө аж ахуйн аялал жуулчлалын зураг

ХАА, хөнгөн үйлдвэрийн бүсийг аялал жуулчлалтай уялдуулан хөгжүүлэх боломжийг авч үзсэн. ЖАЙКА-аас хэрэгжүүлсэн Бүсчилсэн хөгжлийн суурь судалгаанаас дэвшүүлсэн ногоон хөгжлийн бүс буюу ҮХГ-ын ХААХҮ хөгжүүлэх нөөц бололцоотой бүс дагуу ХАА аялал жуулчлал хөгжих боломжтой бүс үзсэн, аялал жуулчлалын дэд бүтцийг давхцуулж харуулж байна. Эдгээр ХАА бүс болон жуулчны бааз буюу зорих газрын чиглэл дагуу түр буудаллах цэг болон үйлчилгээний цогцолборыг эхний шатанд байрлуулан орон нутгийн ХАА гаралтай бүтээгдэхүүний эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх боломжтой.


5.5. Ирээдүйд хөрөнгө оруулалт хийх тухайн салбарын тэргүүлэх чиглэлүүд

ОРОН ЗАЙН ГОРИМ


Аж үйлдвэрийн бүс	Баруун бүс					Хангайн бүс					Төвийн бүс					Говийн бүс					Зүүн бүс							
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	XIII	XIV	XV	XVI	XVII	XVIII	XIX	XX	XXI	XXII	XXIII	XXIV	XXV	XXVI	XXVII	
Аж үйлдвэрийн дэд бүс	Алтай-Дорнод	Баян-Өлгий-Дархан-Уул	Ховд	Увс	Дорнод-Орхон-Төв	Алтай-Шаргал	Булган-Говь-Алтай	Увс	Ховд	Хангайн	Өвдөг-Хангайн	Эрдэнэтийн	Дархан-Шаргал гол	Алтай-Баян-Өлгий	Улаанбаатар	Харан-Согном-Орхон	Төв	Баян-Өлгий	Мянгол-Овоо	Чойр	Дорнод-Совь	Өмнөд-Совь	Гурвантөгс	Хэнтий-Архангай	Их-Ховд	Баян-Өлгий	Чойр	Сүхбаатар
САЛБАР																												
ХАА-ын салбар																												
Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр																												
Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр																												
Арьс, арьсан бүтээгдэхүүний үйлдвэр																												
Ноос, ноосон бүтээгдэхүүний үйлдвэр																												
Монгол, монгол урлаг бүтээгдэхүүний үйлдвэр																												
Ур тариа, гэжээлийн ургамалын үйлдвэр																												
Төмс, хүнсний ногооны үйлдвэр																												
Жимс, жимсгэнэ, ус утгалам үйлдвэр																												
Байгалийн аялал жуулчлал																												
Эко аялал																												
Түүх соёл																												
Нүүдлийн соёл, аж ахуй																												
Мал аж ахуйн салбар																												
Амьт малчлал																												
Бизнес аялал																												
Эмчлэгдэний аялал																												
ХАА аялал жуулчлал																												
Хил дамжин, хил дагуух аялал жуулчлал																												
Шашны аялал																												
Сургалтын аялал																												
Тусгай сонирхлын аялал																												
ТАНИХ ТЭМДЭГ																												
	Харанго оруулалтыг нэлэр-нэмэл дүүгээх																											
	Харанго оруулалтыг нэмэл дүүгээх																											
	Харанго оруулалтыг зохиистой түвшинд барих																											
	Харанго оруулалтыг хөгжгөрдөх																											

Зураг 5.5.1 Аялал жуулчлалын хөрөнгө оруулалтын чиглэл


5.6. Салбарыг цаашид хөгжүүлэх нөхцөл, нөөц, боломжууд



Зураг 5.5.2 Шашны аялал жуулчлалын зураг



Зураг 5.5.3 Аялал жуулчлалын хөгжлийн байршил



Зураг 5.5.4 Аялал жуулчлалын бүсчлэл

ЗУРГАА. ШИНЖЛЭХ УХААНЫ ТЕХНОЛОГИЙН ЗӨВЛӨЛИЙН БОЛОН ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДЫН ДҮГНЭЛТ, САНАЛ

6.1. Тайланг холбогдох яамны шинжлэх ухаан технологийн зөвлөл болон холбогдох ажлын хэсгүүдээр хэлэлцүүлсэн дүгнэлт, санал

ДОЛОО. БОДЛОГЫН СУДАЛГААНЫ СХЕМ, ХАВСРАЛТУУД

7.1. Ашигласан материалын жагсаалт

1. БОАЖЯ “Аялал жуулчлалын салбарын бодлогын баримт бичиг” 2018 он
2. БОАЖЯ “Монгол улсын аялал жуулчлалын үндсэн чиглэл маршрутыг тогтоох судалгаа” 2018 он
3. Дэлхийн банк, “ Монголын аялал жуулчлалын салбар ба эдийн засгийн нөлөөл” 2011
4. Монголбанк, БОАЖЯ “Монгол улсад аялж буй гадаадын жуулчдын зардлын түүвэр судалгаа” 2011, 2015 он
5. Хабдул НАЗЫМ, “Дотоодын зочид буудлын үйлчилгээний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх арга замууд” 2018 он
6. Шизүокагийн их сургууль Эдийн засгийн хүрээлэн, Такаюки Ота “Аялал жуулчлалын бүсийн хөгжлийн тойрог, тулгарах бодлогын асуудал” (2011)
7. Хабдул НАЗЫМ, Дотоодын зочид буудлын үйлчилгээний өргөлдөх чадварыг нэмэгдүүлэх арга замууд, 2018
8. Аялал жуулчлалын багш, судлаачдын нийгэмлэг “ Аялал жуулчлал судлал I ” 2011
9. Аялал жуулчлалын багш, судлаачдын нийгэмлэг “ Аялал жуулчлал судлал III ” 2013
10. Соёлын Өвийн төв “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын лавлах” 2017
11. Соёлын Өвийн төв “Соёлын биет бус өвийн лавлах” 2017
12. Соёлын Өвийн төв “Соёлын өвийн эрсдэлийн атлас” 2017
13. Аялал жуулчлалын багш судлаачдын нийгэмлэг “Хангайн бүсийн аялал жуулчлалын өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага” 2010
14. “Хангайн нурууны байгалийн цогцолборт газрын экосистемийн үйлчилгээний салбарын хөгжилд оруулж буй хувь нэмэр буюу эдийн засгийн үнэ цэнэ” судалгааны тайлан 2015
15. “Хан Хэнтийн дархан цаазат газрын экосистемийн үйлчилгээний салбарын хөгжилд оруулж буй хувь нэмэр буюу эдийн засгийн үнэ цэнэ” судалгааны тайлан 2015
16. БОНХАЖЯ “Тусгай сонирхлын аялал жуулчлал” 2016
17. Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар нутгийн сүлжээ төсөл “Тусгай хамгаалалттай газар нутгууд хоорондын уялдаа холбоог бий болгох замаар төлөөл нь бүрэн хамрагдаагүй экологийн бүс нутаг болох цагаан зээр, аргаль хонь цэн тогоруу, ойн туруутан амьтны нүүдлийн болон тархац нутаг” судалгааны тайлан 2018
18. Managing Tourism at World Heritage Sites: a Practical Manual for World Heritage Site Managers By Arthur Pedersen, UNESCO World Heritage Centre (2002)

19. ETIS toolkit for sustainable destination management, March 2016
20. WORLD ECONOMIC FORUM “Travel and Tourism Competitiveness Report” 2017
21. Institutional Relation and Resource Mobilization –Tourism and SDGs
22. “ Critical thinking to realize sustainability in tourism systems: reflecting on the 2030 SDGs” (The Journal of Sustainable tourism) Karla Beluk, Chirstina T.Cavaliere, Freya Higgins-Desbiolles
23. Whistler-Community Performance Indicators, Corporate Plan Performance Reporting
24. Eagles,P.F.J., McCool,S.F and Haynes 2002
25. <http://www.eic.mn/>
26. <https://www.1212.mn>
27. <http://legalinfo.mn>
28. <http://tourism.ub.gov.mn>
29. <http://www.iltod.gov.mn>
30. <http://monheritage.mn/mn>
31. <http://reports.weforum.org/travel-and-tourism-competitiveness-report-2017/ranking/>


ХАВСРАЛТ

Хүснэгт 1. Аялал жуулчлалын байгууллагын ангилал, тавигдах шаардлага

Ангилал	Төрөл	Үйл ажиллагаа / Зэрэглэл Тавигдах шаардлага		
Tour operator	International tour operator	Гадаад орноос жуулчин хүлээн авах болон гадаад орон руу жуулчин илгээхтэй холбогдсон үйлчилгээ үзүүлэх ба дээрх чиглэлүүдээр 10-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан, аялал жуулчлалын байгууллагад мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан 4-өөс дээш боловсон хүчинтэй байна.		
	Inbound	Монгол улсын нутаг дэвсгэр дээр аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, бүрдүүлэх, сурталчлах, багцаар болон хэсэгчлэн худалдах, аялал зохион байгуулах, тээврийн хэрэгслийн тийз, байр үзвэрийн захиалга, аялалын бичиг баримтын бүрдүүлэлт хийх, виз авахтай холбогдсон үйлчилгээ үзүүлнэ.		
		Inbound A	Inbound B	Inbound C
		10-аас дээш жил ү/а, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан 3-аас цөөнгүй боловсон хүчинтэй байна.	5-аас дээш жил үа, мэргэжлээрээ 3аас дээш жил ажилласан 3-аас цөөнгүй боловсон хүчинтэй байна.	2-оос доошгүй жил ажилласан, 2оос дээш боловсон хүчинтэй байна.
	Outbound	Гадаад улс орнуудад аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг төлөвлөх, бүрдүүлэх, дотоодод сурталчлах, багц болон хэсэгчлэн худалдах, аялал зохион байгуулах, тээврийн хэрэгслийн тийз, байр үзвэрийн захиалга, аялалын бичиг баримтын бүрдүүлэлт, виз авахтай холбогдсон үйлчилгээ үзүүлнэ. Мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан 2-оос дээш боловсон хүчинтэй байна.		
Domestic	Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бий болгох, бүрдүүлэх, сурталчлах, багцаар болон хэсэгчлэн худалдах, аялал зохион байгуулах, тээврийн хэрэгслийн, байрны, үзвэрийн захиалга, аялалын бичиг баримтын бүрдүүлэлттэй холбогдсон үйлчилгээ үзүүлнэ.			
Tour agent		Гадаад, дотоодын аялал жуулчлалын үйл ажиллагааг зуучлагч тур агент /tour agent/ нь виз болон аялалын бичиг баримтын бүрдүүлэлт хийх, байр, хоол, унаа, үзвэрийн захиалга хийх, гадаад дотоодын тур операторын бүтээгдэхүүнийг гэрээний үндсэн дээр бүхэлд нь болон хэсэгчлэн зуучлан худалдаалахтай холбогдсон үйлчилгээ үзүүлнэ.		

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 31 дүгээр тушаал


ЗОЧИД БУУДЛЫН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ, улирлаар, улсын дүнгээр



Эх сурвалж: Статистикийн Үндэсний Хороо

Зураг 2. Зочид буудлын салбарын үзүүлэлт

ЗОЧИД БУУДЛЫН ТОО




■ Улаанбаатар хот ■ Баруун бүс ■ Хангайн бүс ■ Төвийн бүс ■ Зүүн бүс

Эх сурвалж: Статистикийн Үндэсний Хороо

Зураг 3. Зочид буудлын тоо, бүсээр

ЗОЧИД БУУДЛЫН САЛБАРЫН ОРЛОГО



Эх сурвалж: Статистикийн Үндэсний Хороо

Зураг 4. Зочид буудлын салбарын орлого

Хүснэгт 5. Зочид буудлын салбарын үзүүлэлт

ЗОЧИД БУУДЛЫН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ, улирлаар, улсын дүнгээр					
зочид буудал	2013-IV	2014-IV	2015-IV	2016-IV	2017-IV
Зочид буудлын салбарт ажиллагчдын тоо, улирлаар	4,901.0	4,630.0	4,894.0	4,795.0	4,483.0

Эх сурвалж: Статистикийн Үндэсний Хороо

Зам дагуух байгууламжийн жишээ, Япон улс

Япон улсын хувьд зам дагуух байгууламжийг авто зам ашиглаж буй аялагчдад зориулсан авто замын аюулгүй, тав тухтай үйлчилгээгээр хангах, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор байгуулдаг.

Мичино эки нь дараах үндсэн 3 зарчимтай. Үүнд :

- Амралтын үйлчилгээ үзүүлэх (24 цагийн үнэгүй зогсоол, ариун цэврийн өрөө)
- Мэдээлэл түгээх (Замын мэдээлэл, орон нутгийн аялал жуулчлалын мэдээлэл, түргэн тусламжийн гэх мэт)
- Орон нутгийн хамтын ажиллагааг дэмжих (Соёл боловсрол, аялал, амралт чөлөө цаг зэрэг орон нутгийн хөгжлийг дэмжих)

Япон улсын орон нутгийн жижиг хот тосгоны хувьд жилээс жилд залуучуудын хот руу шилжих хөдөлгөөнөөс үүдэлтэй хүн ам болон хөдөө аж ахуй эрхлэгчид цөөрөн орон нутгийн эдийн засаг уналтад орох гэсэн нийтлэг асуудал үүссэн. Урьд өмнө

дотооддын аялагчид ихээр очдог байсан газруудын хувьд ч аялагч, амрагчид эрс буурах хандлагатай болсон. Эдгээр асуудлыг шийдвэрлэх зорилгоор 1991 онд анхны Мичино эки Ямагүчи, Гифү, Точиги 3 мужид анх туршилтаар байгуулагдсан бөгөөд 1993 онд Мичино эки концепт батлагдсан байна. Одоо Япон улс даяар 1,145 мичино эки бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж байна. (2018 оны 4 сарын 25-ны байдлаар). Зам дагуух байгууламж концептээр байгуулагдсан хэдий ч одоо нэг төрлийн аялал жуулчлалын зорин очих газар болтлоо хөгжсөн, зөвхөн тухайн Мичино экиг зорьж очих аялагч, амрагчид ихтэй газар олон байна.



Эх сурвалж: Япон улсын Зам тээвэр, дэд бүтцийн яам

Зураг 5. Мичино эки үндсэн загвар

Хурдны зам ашигласан олон цагийн аялал, хөдөлгөөн нэмэгдэн, авто замын тав тухтай байдлыг хангахаас гадна тухайн орон нутгийн түүх соёл, дурсгалт газар, онцлох бүтээгдэхүүн зэрэг үйлчилгээг нэг дор аван, орон нутгийн эдийн засагт хувь нэмэр оруулах зорилготой концептыг Япон орон даяар хөгжүүлсэн байна.

Орон нутгууд Мичино экиг байгуулснаар шинэ бренд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлж, ХАА-н аялал жуулчлал болон орон нутгийн нөөцийг ашиглан жуулчдыг олноор татах зорилгоор идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг байна.

Нэг жишээ болгон Чиба мужийн Томиура хотын Мичино эки буюу орон нутгийн захиргаа болон хувийн хэвшлийн түншлэлийн Бива клубыг танилцуулья.

Бива клубыг 1993 оны 11 сарын 27-нд хуучин Томиура хотын (Одоогийн Минами Боосо хот) захиргаа нутгийн онцлог болох Бива жимсээр дамжуулан зорчин ирэх хүмүүсийн тоог нэмэгдүүлэх зорилгоор анх байгуулсан. Тус байгууллага худалдаа, ХАА, аялал жуулчлалаас гадна соёлын арга хэмжээ зохион байгуулах зэргээр жил бүр үйл ажиллагаагаа улам бүр амжилттай өргөжүүлсээр байгаа. Үүний үр дүнд 2003 оны 8 сарын 8-нд тус орон нутагт цэцгийн үйл ажиллагаа эрхэлдэг Хана клубыг “Ооцүно Сато Мичино эки ” хэмээн албан ёсоор Мичино Эки-гийн батламж олгосон. “Бива клуб” хэмээх цогцолбор байгууламжийг бие даасан, өөрийн гэсэн онцлогтой орон нутагт хувь нэмэр оруулахуйц байгууллага болгох зорилгоор

хуучин Томиура хот (одоогийн Минами Боосо хот) хот болон Томиура ХК (Одоогийн Чива Минами Боосо ХК) гэсэн хамтарсан хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх болсон.

Тус байгууллага нь 2000 оны 3 сарын 2-нд зохион байгуулагдсан 2000 оны шилдэг Мичино Эки-гийн шалгаруулалтанд Гран При шагналыг хүртэж, мөн 2002 оны 11 сард “ Хүн ам цөөрч буй орон нутгийг хөгжүүлэх шилдэг төсөл” шагнал, 2008 оны 7 сард “ХАА, үйлдвэр худалдааны хамтын ажиллагааны” шилдэг байгууллагуудын 88-д шалгарч, 2009 оны 7 сард “Японы шилдэг үйлчилгээ бүхий байгууллагын шалгаруулалтанд 300”-д, 2015 оны 1 сарын 30-нд Япон улсын загвар “Мичино эки” батламжийг тус тус хүртсэн.

2012 оны 10 сарын 1-нээс Минами Боосо хотын 3 компанитай нэгдэж, Чива Минами Боосо ХК хэмээн нэрээ өөрчлөн, дахин үйл ажиллагаа шинээр эхлүүлсэн юм. Цаашид ч Минами Боосо орон нутгийн нөөц, бололцоог илрүүлэн, Бива клубын үйл ажиллагааг байнга шинэчилэн, хөгжүүлэхээр хичээл зүтгэл гарган ажилладаг байна.

Тухайн орон нутгийн онцлог бүтээгдэхүүн болох Бива жимс нь 250 жил тариалсан түүхтэй, орон нутгийн бэлэг тэмдэг болтлоо олонд танигдсан, нэр хүндтэй тансаг хэрэглээ гэгддэг бөгөөд нийт улсын хэмжээнд тариалалтын хэмжээ бага байсан. Гэсэн хэдий ч уг жимс маш хурдан мууддаг, зах зээлд нийлүүлж борлуулалт, хүргэлт хийх хүртэл маш их хэмжээгээр хаягддаг, мөн тариалсан жимсний 25-30% нь стандарт бус хэмжээтэй хэмээн хаягдал болдог байсан байна. Иймд жимс, цэцэг, үрийг л ашигладаг байсан жимсийг ашиглан жимсний чанамал, жигнэмэг гэх мэт бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн байна. Бива жимс тариалагчид Мичино экитэй хамтын ажиллагаа байгуулснаар хаягдал болдог байсан жимсээр бүтээгдэхүүн үйлдвэрлэн, мичино эки дээр борлуулалт хийн өндөр ашигтай ажиллах болсон. Аялал жуулчлалаас олох орлого 2011 онд 63,433 мянган иен, 2013 онд 81, 631 мянган иен, 2015 онд 83,149 мянган иен гэх мэт жил ирэх тусам нэмэгдсээр байна.


Асуудлыг шийдэх чиг хандлага

~Орон нутгийн өөрсдийн санаачилгаар тогтвортой хөгжлийг бий болгох~

Төслийн зорилт ➔ Орон нутгийн аж үйлдвэр • соёлын хөгжил • мэдээлэл түгээх

Идэвхжүүлэх чиглэл	Үйл ажиллагааны чиглэл
<ul style="list-style-type: none"> ① Харилцааг өргөжүүлэх (өдрөөр ирэх жуулчдыг нэмэгдүүлэх) ② Стандартад нийцээгүй 『Бива』 -гаар шинэ бүтээгдэхүүн боловсруулах ③ Интернет ашиглан мэдээлэл түгээх ④ Орон нутгийн нөөц баялаг, соёлыг дахин тунгаан иргэдийн бахархалыг бий болгох 	<ul style="list-style-type: none"> ① Экомюзе (таруу байгууламжуудыг удирдах нэгдсэн менежментийн онол) аргаар орон нутгийг цогцоор нь хөгжүүлэх ② Идэвхжүүлэх байгууламж (Бива клуб, Хана клуб) ③ Аж үйлдвэрлэл, соёлын мэдээлэл ④ Шинэ аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх ажлын байрыг нэмэгдүүлэх ⑤ Онцлог бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх ⑥ Нутгийн иргэдэд зориулсан соёлын арга хэмжээ

Бива клубын голлох үйл ажиллагаа



Томиура Экомюзе судалгааны нийгэмлэг ТББ

Эх сурвалж: Чива Минами Боосо ХК

Зураг 6. Томиура мичино эки үйл ажиллагаа



Зураг 7. БОАЖЯ-ны 2019 оны төсвийн төсөл